


Ногоон хөгжлийн төлөө

MONGOLIAN ECONOMY

2015 ОНЫ 1 САР. №01 (080)



www.mongolianeconomy.mn



БИЛЭГЭНОМИКС

- ▶ Улсын төсвийг танаж, халамжийг зорилтот бүлэгт чиглүүлэх
- ▶ Гадны хөрөнгө оруулалтыг дэмжиж, гаднаас хөрөнгө босгох
- ▶ Өрийн таазыг дээшлүүлэн шинэ өрөөр хуучин өрөө дарах
- ▶ Хөдлөх болон үл хөдлөх хөрөнгийн татварыг нэмэгдүүлэх



РЕГАНОМИКС

- ▶ Засгийн газрын зардлыг танах
- ▶ Хүн амын орлогын албан татварыг бууруулах
- ▶ Төрийн оролцоог багасгах
- ▶ Мөнгөний нийлүүлэлтийг багасгаж, инфляцийг бууруулах



АБЭНОМИКС

- ▶ Төсвийг нэмэгдүүлэх
- ▶ Мөнгө хэвлэж зах зээлд нийлүүлэх
- ▶ Бүтцийн өөрчлөлт хийх



ОБАМАНОМИКС

- ▶ Хүртээмжтэй эрүүл мэндийн үйлчилгээний тухай хууль (Обамакер)
- ▶ Баялгийг дахин хуваарилах (Баячуудын татварыг өсгөх)
- ▶ Санхүүгийн зохицуулах системийг шинэчилсэн Додд-Фрэнкийн хууль
- ▶ Эрчим хүчний салбар дахь төрийн оролцоог шинэчлэх

АЯГА ТАВГА УГААГЧ



Бактери устгач

75C -ын халуун усаар нян бактерийг 100% устгах



Эрчим хүч зарцуулалт хамгийн бага

Усны зарцуулалт 7-12 литр
Угаах горимноос шалтгаалан
цагт 0.67 -1.0 кВт



Цаг хугацаа хэмнэх

13 төрлийн тохиргоог
ердөө 15 минутанд угаана



Илүү эмх цэгцтэй

Галын өрөөнд илүү эмх
цэгц, тохилог орчинг
бүрдүүлнэ



Дээд зэргийн аюулгүй байдал

Хөөсөн угаалга нь хутга, сэрээ
гэх мэт төмөр эдлэл угаахад
ямарч эрсдэлгүй



Хамгийн бага эрчим хүч, усны зарцуулалт

Green
Technology
inside





БОРЛУУЛАЛТАА ӨСГӨХ ШИЛДЭГ АРГА

Ногоон хөгжлийн төлөө

MONGOLIAN ECONOMY

Монголын сэтгүүлдийн эвлэлийн

“2013 оны Шилдэг сэтгүүр”

ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ, ЭРХЛЭГЧ:

Д.Бэхбаяр / 9999-4248

ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ, ОРЛОГЧ ЭРХЛЭГЧ:

И.Отгонжаргал / 8800-6228

СЭТГҮҮЛИЙН РЕДАКТОР:

Б.Үүрийнтуяа

АНГЛИ ХЭЛНИЙ РЕДАКТОР:

Ийланд Роберт Мэн

ВЭБ РЕДАКТОР:

Б.Энхцэцэг

СЭТГҮҮЛЧИД:

Б.Баяртогтох

Э.Зоригт

А.Бүрэнжаргал

ДИЗАЙНЕР:

Ш.Оюундарь

МАРКЕТИНГИЙН МЕНЕЖЕР:

Д.Баранжав / 9409 2904

Б.Наранцогт / 9409 2905

ХАЯГ:

Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг.

VI хороо, Их сургуулийн гудамж.

AB center. 504 тоот

15160 Улаанбаатар, Төв шуудан, ш/ х-2762

www.mongolianeconomy.mn

info@mongolianeconomy.mn

Утас/Факс: 976 - 7011 5476

“Улаанбаатар принт” ХХК-д хэвлэв

www.ubprint.mn

БОРЛУУЛАХ ЦЭГҮҮД:

“Интер ном”

“Цэцэг төв”

“Минж плаза”

“Алтантүлхүүр” номын дэлгүүр

“Номин” супермаркетийн бүх салбар

“Макс” супермаркетийн бүх салбар

“Фреско” супермаркет

BTSI супермаркет

“Аз орчлон” номын дэлгүүр

“Билэг” их дэлгүүрийн номын тасаг

“Гранд Плаза” дахь супермаркет

“Мир” номын дэлгүүрийн

“Grand plaza”

“Metro mall”

“Sky” супермаркет

“Улаанбаатар” их дэлгүүр

“Max mall” дэх салбарууд

РЕДАКТОРЫН ЗУРВАС

Уншигч та бүхэндээ шинэ оны эхний дугаараа энэ өдрийн халуун мэндийн хамт хүргье. Улиран одсон 2014 он “Mongolian Economy” сэтгүүлийн хамт олны хувьд амжилт, бүтээлээр дүүрэн өнгөрсөн онуудаа дүгнэсэн жил байлаа. Үүний нэг илрэл нь оны өмнөхөн сүүлийн гурван жилийн хөдөлмөр, бүтээлийнхээ цомирлог болгон Сорилт, гарц, хөгжил хэмээн гарчигласан эмхэтгэл дугаар маань байлаа.

Угтан авсан 2015 ондоо бид ирээдүйн холыг ойртуулах зорилго тээн алсын хараатай, дүн шинжилгээ бүхий нийтлэл, сурвалжлага бэлтгэхээс гадна Монголын төдийгүй дэлхийн хүмүүсийн бодол, санааг хүргэхээр зорин ажиллах болно.

Оны шинэхэн дугаартаа бид уншигчиддаа манай улсын болон, дэлхийн эдийн засаг хааш чиглэж буйг шинжин хүргэж байна.

Шийдлийн хэмээн тодотголтой Ч.Сайханбилэгийн Засгийн газар хямралд автаад буй улсынхаа эдийн засгийг эрчимжүүлэхээр ханцуй шамлан орлоо. Үргүй зардлаа тэвчин урт хугацааны хөгжилд хүрэхээр бүсээ чангалах тодорхой арга хэмжээнүүдийг ч авахаар ард олондоо зарласан. Чухам хасах, танахаар зураглах бус хасах, танах аргачлалаа хэрхэн төсөөлөх нь эдийн засгийг хямралын ангалаас татах чухал зэмсэг байх биз ээ. Тиймээс дэлхий дахинд Реганомикс, Обаномикс, Абэномикс гэх мэтээр алдаршсан эдийн засгийн туршлагауудыг төр засгийнхан төдийгүй холбогдох салбарынхантай хуваалцахаар бэлтгэлээ.

Монгол Улсын уул уурхайн салбарт хэрэгжүүлэх мега төслүүд манай эдийн засгийн хөдөлгүүр. Тэгвэл олны анхаарлыг татсаар ирсэн Тавантолгойн асуудал шуудрах шатанд орсныг тэмдэглэхэд таатбай байна. Энэ талаар уншигч Та манай сэтгүүлд багтсан “Тавантолгой амь орлоо” нийтлэлээс сонирхоорой.

Мэргэжлийн сэтгүүлийн хувьд хаа нэгтэйгээс хялбархан олоод уншиж болох мэдээ, мэдээллийг хүргэлгүй мэргэжлийн хүний нүдээр харсан, үзгээр дүгнэсэн үзэл бодол, эдийн засаг болоод холбогдох салбаруудын энэ оны төрх хэрхэх талаар сонирхолтой анализ, дүгнэлтийг мөн багтаалаа.

Оныхоо эдийн засаг, бизнесийн “зурхай”-г ийн шинжих боломжийг төр, түмнийхээ төлөөлөлд хүргэж буйдаа баяртай байна. Та бүхэн шинэхэн дугаараа шимтэн уншаарай.

Редактор Б.ҮҮРИЙНТУЯА



facebook.com/MongolianEconomy



twitter.com/EconomyMongolia



youtube.com/user/MongolianEconomy

АГУУЛГА

ЭДИЙН ЗАСАГ

- 8 Билэгэномикс
- 10 Царцсан эдийн засаг
- 12 Хямралыг удирдахуй
- 16 Монголын эдийн засгийн төлөв 2015 онд
- 18 Өнгөрсөнд нуугдах ирээдүй
- 20 Б.Түвшинтөгс: Институцийг сайжруулснаар эдийн засгийн хүндрэлээс гарна
- 24 Эдийн засгийн тулгуур зах зээл



УУЛУУРХАЙ

- 26 Тавантолгой амь оров
- 28 Боловсруулах үйлдвэр боломжгүй зүйл биш
- 30 Хүлээлт үргэлжлэхгүй



БАНК, САНХҮҮ

- 32 Монгол Улс чухал зорилтууддаа анхаарч, шаламгай хөдлөх хэрэгтэй
- 35 Онцлох үйл явдлууд ба шинээр юу хүлээж болох вэ?
- 38 Япон Монголын бизнесийн боломж

БИЗНЕС

- 42 Хямралын гарц бол экспорт
- 44 Монголд тавтай морил
- 45 “Луу”-гийн эрин ба өөртөө итгэх өмнөд хөрш
- 47 Тэд ийн өгүүлэв

Манай сайт руу зочилж, өдөр бүр эдийн засаг, бизнесийн талаар шинэ мэдээлэл аваарай. MongolianEconomy.mn/ дээр доорх улаанаар тодруулсан тэмдэгтүүдийг нэмээд холбогдох нийтлэлийг уншаарай.



Эдийн засагт 500 сая ам.доллар орж ирнэ

Монголбанкны зарласан ханшаар ам.доллар 1897 төгрөгтэй тэнцэж байна. Энэ нь ханшийн одоогийн зах зээл дээрх хамгийн бага үнэ. Ханш чангарч байгаа нь эдийн засгийн хүндрэлийн нэг шалтгаан гэдгийг СЭЗДС-ийн Санхүүгийн удирдлагын тэнхимийн багш Б.Мөнхзаяа тодорхойлсон - mn/e/7109

ЭДИЙН ЗАСАГЧДЫН БУЛАН

MongolianEconomy.mn/ дээр доорх улаанаар тодруулсан тэмдэгтүүдийг нэмээд холбогдох нийтлэлийг уншаарай.



Б.Эрдэнэбат

Монгол Улс хэзээ хөгжих вэ?


Косово улсад болсон моно жүжгийн фестивалд амжилттай оролцож, эх орныхоо нэрийг гаргаж чадсан жүжигчинд Монгол улсын Засгийн газрын 120-р тогтоолоор 65 сая төгрөгийн шагнал олгов гэсэн мэдээ уншлаа. Уг мэдээ Олимпын наадмын алтан медальтныг 4 сая - mn/p/6216



Л.Бямбаа

Бодлогын үр нөлөөгүй мөнгөний бодлого

Монголбанк Төрөөс мөнгөний бодлогын талаар 2015 онд баримтлах үндсэн чиглэлийн төслийг УИХ-д өргөн барилаа. Төрөөс баримтлах аливаа бодлого нь зорьсон үр дүндээ хүрдэг байх нь чухал. Дэвшүүлсэн зорилгодоо хүрэхгүй, эсвэл зарим тохиолдолд бүр эсрэг үр дүнд - mn/b/6948



Ө.Ганзориг

Төрийн хар хүн (statesman)

Миний сууж байсан курсэд Бутаны оюутан байв. Бутан бол Төвд ба Энэтхэгтэй хил залгаа жижигхэн улс гэдгийг мэдэх байх. Анх тэр хүнээс Үндэстэний Аз Жаргал (Gross National Happiness) хэмээх албан ёсны хэмжүүрийн тухай сонсож билээ - mn/p/6867



Твиттер дээр биднийг дагаарай
[@MN_Economy](https://twitter.com/MN_Economy)



Фэйсбүүк дээр бидэнтэй нэгдээрэй
Facebook.com/Mongolian.Economy

Онлайн захиалга өгөхдөө
<http://goo.gl/KVV50W> линкээр
орох буюу энэ кодыг
сканнердаарай:



МОНГОЛД

Шинэ үйлдвэр

Төв аймгийн Сэргэлэн сумын нутагт жилд 300 мянган тонн шахмал түлш үйлдвэрлэх хүчин чадалтай “Дэрст тохой” шахмал түлшний үйлдвэр ашиглалтад оржээ. Үйлдвэрийн хүчин чадал Улаанбаатар хотын шахмал түлшний хэрэглээний тал хувийг дангаараа хангах боломжтой аж. Тус компанийн мэдээлснээр илчлэг өндөртэй 2.5 тонн шахмал түлшний чанар дөрвөн тонн нүүрсгэй ижил түвшинд байдаг аж. Үнийн хувьд шахмал түлш тонн нь дунджаар 125 мянган төгрөг буюу түүхий нүүрснээс харьцангуй хямд юм байна. Тус үйлдвэрийг 2.8 тэрбум төгрөгийн хөрөнгөөр босгожээ.

Үнэ ханш



Өнгөрсөн оны арваннэгдүгээр сарын байдлаар нүүрсний экспорт 5.1, алтных 14.1, газрын тос 39.7 хувиар, зэсийн баяжмал хоёр дахин өссөн үзүүлэлттэй гарсныг Уул уурхайн яамнаас мэдээлсэн. Эдгээрээс улсын төсөвт нэг их наяд 75.4 тэрбум төгрөг төвлөрүүлсэн байна. Ирэх 2-3 жилд зэсийн үнэ төдийлэн өсөх хандлага ажиглагдахгүй байгааг мэргэжилтнүүд хэлж буй. Эдгээрийг бодитойгоор тооцоолон ирэх онд уул уурхайн салбараас нийт нэг их наяд 126 тэрбум төгрөгийн орлогыг улсын төсөвт төвлөрүүлэхээр төлөвлөжээ. Тухайлбал, “Оюутолгой”-гоос 324.3 тэрбум, “Эрдэнэт” үйлдвэрээс 447.5 тэрбум, “Эрдэнэс Таван толгой” компаниас 60.8 тэрбум төгрөгийг төсөвт оруулах аж.

Орон сууц

Нийслэлээс хэрэгжүүлэ буй “Гэр хорооллын дахин төлөвлөлт” хөтөлбөрийн хүрээнд энэ онд орон сууцны ипотекийн зээлийн урьдчилгаа төлбөр дутагдалтай иргэдэд батлан даалт гаргаж санхүүгийн үйлчилгээ хүргэх шат дараатай арга хэмжээг хэрэгжүүлэхээр болжээ. Улаанбаатарын орон сууцны сан дахь 13.5 тэрбум төгрөгөөр урьдчилгаа 30 хувийг батлан даахаар болжээ. Энэ ажлын хүрээнд Нийслэлийн орон сууцны эрэлт, нийлүүлэлтийн судалгааг “Kesemar marketing association” компаниас гаргажээ. Өнгөрсөн оны хувьд 40-50 ам метр орон сууцны борлуулалт их байсан аж. Учир нь гэр хорооллын дахин төлөвлөлтийн хүрээнд ашиглалтад орсон 168 айлын орон сууц бүгд борлогдсон. Түүнчлэн нийслэлд 204 мянган айлын орон сууц хэрэгтэй байгаа тооцоо гарчээ. Түүний 65 мянга орчим нь 30 хувиа төлөх чадвартай аж.

Автозам

Энэ онд 1800 гаруй км хатуу хучилттай автозамыг ашиглалтад оруулснаар зарим аймгийн төвтэй холбогдсон замын урт 5000 орчим км-т хүрчээ. Түүнчлэн энэ онд бүх аймгийн төвийг нийслэлтэй хатуу хучилттай авто замаар холбоход 5700 орчим км автозамыг ашиглалтад оруулахаар төлөвлөж байгаа аж. Замын урсгал засвар, арчилгаанд анхаараагүйн улмаас хот хоорондын зам дахин шинэчлэх хүртэл эвдрэлд өртөж байгаа талаар мэргэжилтнүүд хэлж байна. Тиймээс энэ



оноос Засгийн газрын хуралдаанаар “Улаанбаатар автозамын засвар арчлалт” төрийн өмчит хувьцаат компанийг хувааж, Төв аймгийн Баянчандмань суманд “Баянчандмань АЗЗА”, нийслэлийн Налайх дүүрэгт “Налайх-АЗЗА” төрийн өмчит хувьцаат компани байгуулахыг зөвшөөрчээ. Түүнчлэн Дундговь, Өмнөговь, Баян-Өлгий аймаг болон Дорноговь аймгийн Замын-Үүд суманд автозасварын арчлалт хийх компанийг сонгон шалгаруулж, гэрээ байгуулан ажиллуулахыг эдгээр аймгийн Засаг дарга нарт даалгасан байна.

ДЭЛХИЙ ДАХИНД

Энэтхэгийн батлан хамгаалахын тусламж



Хил хамгаалах газрын цэргийн генерал Ж.Лхачинжаваар ахлуулсан Монголын төлөөлөгчид өнгөрөгч арванхоёрдугаар сард Энэтхэгийн Нью Дели хотноо тус улсын дотоод хэргийн сайд Ражнатай уулзаж хоёр орны батлан хамгаалахын салбарын хамтын ажиллагааны талаар ярилцлаа. Айлчлалын үеэр Энэтхэгийн талаас Монголын цэрэг, зэвсэг, аюулгүй байдал болон тусгай ажиллагааны боломж бололцоог хөгжүүлэхэд тусламж дэмжлэг үзүүлэхээр болсон.

Газрын тосны үнийн уналт

Өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүний ханш огцом унасан 2014 онд газрын тосны үнэ сүүлийн таван жилийн доод хэмжээнд хүрэв. Нэг баррель нь 100 ам.доллараар



худалдаалагдаж байсан газрын тос зургадугаар сараас хойш үнийн уналтад орж нэг баррель нь 50 ам.долларт хүрсэн. Ийнхүү буурч буй нь АНУ-д тус бүтээгдэхүүний үйлдвэрлэл, нийлүүлэлт өссөн, Хятадын үйлдвэржилт удааширан эрэлт буурсантай холбоотой аж. Шинжээчдийн үзэж буйгаар газрын тосны ханш буурсаар байх төлөвтэй байна.

ОХУ-ын эдийн засгийн хямрал

Нефтийн бүтээгдэхүүнд суурилсан ОХУ-ын эдийн засаг газрын тос, байгалийн хийн үнийн уналт, ОХУ-д барууны орнуудын тавьсан хориг арга хэмжээний улмаас хямралд орж байна. Оросын экспортын гол бүтээгдэхүүн болох газрын тос, байгалийн хий улсын төсвийн тал хувийг санхүүжүүлдэг бөгөөд төсвийн алдагдлыг тэнцвэржүүлэхэд 60 ам.доллараас бага үнээр борлогдож буй тус төрлийн бүтээгдэхүүний ханш хоёр дахин нэмэгдэх шаардлагатай байгаа юм. Барууны хориг арга хэмжээнээс үүдэн тус улсад чиглэл олон улсын хөрөнгө оруулалт эрс буурсан төдийгүй Оросын компаниуд болон банкуудын олон улсын хөрөнгийн зах зээлд оролцохыг хориглосон байна. Үүний зэрэгцээ ОХУ-ын рубль газрын тосны үнэтэй зэрэгцэн унаж байна. Арванхоёрдугаар сарын байдлаар Төвбанкны бодлогын хүү огцом өссөн нь валютын ханшид нөлөөлж нэг ам.доллар 80 орчим рубльтэй тэнцэх болсон.

Мицубишигийн зэсийн гэрээ



Оюутолгой “Мицубиши Материал Корпораци”-тай хамтран туршилтын хүрээнд 5000 тонн зэс экспортлох гэрээ байгуулжээ. Мицубиши жилд нэг сая тонн зэс импортлодог. Өргөтгөлийн ажил нь олон жил хойшилж буй Оюутолгойн ордоос 200 мянган тонн зэсийн баяжмал үйлдвэрлэхээр тооцжээ.

Евро бүс



Евро бүсийн эдийн засаг арванхоёрдугаар сард сул өсөлттэй байсан бөгөөд энэ нь жил гаруй хугацаанд хамгийн муу өсөлттэй улирал байсан гэдгийг Маркит санхүүгийн байгууллагын судалгаа харуулж байна. Евро бүсийн худалдан авалтын индексийн үзүүлэлт нь өмнөх сарынхаа 51.7 нэгжээс 51.4 рүү буурчээ. Гэвч энэ нь өмнөх сард үзүүлсэн 51.1 нэгжтэй харьцуулахад дээрдсэн хандлага юм. Евро бүсийн эдийн засаг 18 дахь сардаа үргэлжилсэн сул өсөлттэй байна. Барилга байгууламж, үйлчилгээ, боловсруулах үйлдвэрлэл зэрэг салбар тус бүрийн судалгааны дүнгээс үзэхэд Евро бүсийн эдийн засгийн өсөлт 2014 оны сүүлийн гурван сарын байдлаар ердөө 0.1 хувиар өсчээ. Маркит судалгааны байгууллагын мэргэжилтнүүд Европын Төв банкыг эдийн засгаа дэмжихийн эрчтэй бодлогыг хурдан хэрэгжүүлэх шаардлагатай гэлээ. ■



МОНГОЛ

ЖИРГЭЭНИЙ ЕРТӨНЦӨД

UHRSN@uhrsn 11.29

#Монгол улс хориг арга хэмжээ авсныхаа төлөө НҮБ-ын хүний эрхийн консулын шалгалтаар орж байна ... <http://ow.ly/F0HSB>

Монгол улс одоогийн визний бодлогынхоо хүрээнд гаднын иргэдийг тодорхойгүй шалтгаанаар хорьж чадаж байна. Сауд Гоби Ресурст ажиллаж байсан гурван ажилтан-- Justin Karla, Hilarion Cajusom Jr. Crisotbal David нарт ямар нэг гэмт хэрэг холбогдуулан үүсгээгүй атлаа тодорхойгүй шалтгаанаар хоёр жил гаруй хугацаанд Монголыг орхин явахыг нь хориглоод байгаа. Энэхүү хориг нь олон гаднын хөрөнгө оруулагчдыг Монголд ирэхээс эмээхэд хүргэж байна. Америкийн Нэгдсэн улсын Төрийн департамент “Монголын төр болон хувийн хэвшлийнхэн 2010 оноос хойш визний системийг гадаадын хөрөнгө оруулагчдыг дарамтлах замаар урвуулан ашиглаж, арилжааны болох иргэнийн харилцаанд үүссэн маргааныг таслах зорилгоор урвуулан хэрэглэсээр байна. Монголын Засгийн газар нөхцөл байдал шийдэгдтэл ямар ч хүсэлт тайлбаргүйгээр гаднын иргэдийг Монгол улсаас гарахыг нь хаах эрхтэй байна” Нэгдсэн Үндэстний байгууллага нь одоогоор Монгол улс өөрөө гарын үсэг зурж нэгдэн орсон олон улсын хүний эрхийн санааж бичгүүдийг зөрчин Америкийн иргэн Жастин Каплаасыг зөрчин хорьж байгаа эсэхийг шалгаж байна.

Жаргалсайхан @SJJargalsaikhan 12.22

Хөгжлийн хэлэлцүүлэг : Эмэгтэйчүүдийн улс төрийн эрх мэдэл 2014 оны 12-р сарын 23, Улаанбаатар www.mn.undp.org/content/mongolia/en/home/presscenter/development-dialogues-/DevelopmentDialogue10WomanPoliticalEmpowermentInMongolia.html#GenderEquality

НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр болон Хүйсийн тэнцвэрт байдлын Үндэсний Хорооноос хэлэлцүүлэг зохион байгууллаа. Энэ үеэр Монголын улс төр дахь эмэгтэйчүүдэд тулгарч буй сорилтууд болон Засгийн газарт хүйсийн тэнцвэрт байдлыг нэмэгдүүлж чадах хууль болон шийдлүүдийг хэлцлээ. Монгол дахь НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр: “УИХ дахь эмэгтэйчүүдийн төлөөлөл 2012 оны ерөнхий сонгуулийн дүнгээс харахад 14.5 хувиар өссөн байна. Гэвч Монгол улс одоо болтол дэлхийн дундаж үзүүлэлт болох 21.9 хувиас доогуур байна. Ялангуяа ирэх 2016 оны сонгуульд Монголын дээрх үзүүлэлт хэвээр үлдэнэ эсвэл өснө гэх баталгаа байхгүй байна.

Катерин Жонстон @Katherine_A_J 12, 29

ODI's /Хилийн чанад дахь орнуудын хөгжлийн хүрээлэн/ 2014 оны сайн мэдээ #Монголын #боловсрол www.developmentprogress.org/decline-recovery-post-primary-education-mongolia

1990 оны эхэн үеийн бууралтаас хойш Монголын бага сургуулийн дараах боловсролын элсэлт болон хүртээмж нь одоогийн өндөр түвшинд хүрсэн бөгөөд өндөр орлоготой орнуудын дундаж түвшинтэй ойртоод байна. Их Британийн олон улсын хөгжлийн “Overseas Development Institute” хүрээлэнгийн удирдаж явуулсан “Хөгжлийн үйл явц” тайланд Монгол улсын орон нутаг болон хот дахь бага ангиас дээших боловсрол нь ижил түвшинд өндөр өсөлттэй байсаар ирсэн бөгөөд дунд болон дээд боловсролын элсэлт, хүртээмжтэй байдлын хувьд дэлхийн жишигт ойртож байна гэдгийг үзүүлжээ.

А.Отгонбаатар @AОтгонbaatar Jan 7

Жижиг дунд бизнесийг Төр дэмжих гэхээс илүү Таны худалдан авалт хамгийн сайн дэмждэг. #Үндэснийүйлдвэрлэл

Хөгжингүй орнуудын жишигт үндэсний бараа бүтээгдэхүүнийг худалдааны байгууллага болгон импортын бараатай зэрэгцүүлэн тавьсан байхыг шаарддаг. Энэ хэрээр үйлчлүүлэгчид үндэсний үйлдвэрлэлээ дэмжих боломж олдох юм.

Baika Puntsag @baikar Jan 5

Шангри Ла зочид буудал нээгдэнэ, хоёр ч кинотеатр нээгдэнэ. Хүннү моллын дөрвөн улирлын каток нээгдэнэ. #ЭнэЖил

Манай улсын хөгжил цэцэглэлт өнгө төрхийг бүрдүүлж буй бүтээн байгуулалтын дийлэнх нь хувийн хэвшлийн хөрөнгөөр боссон байдаг.



“Тэжээнэ, тэтгээнэ” гэж амалсаар ирсэн төрийн бодлогыг хүртээмжтэй, хүртээлтэй болгоно гэх Ерөнхий сайдын эдийн засгийн бодлогыг манай сэтгүүлийн зүгээс “Билэгэномикс” гэж нэрлэлээ.

ЗАСАГЛАЛ

Билэгэномикс



Б.ҮҮРИЙНТУЯА
“Mongolian Economy”
этгүүлийн редактор

Оросын эдийн засаг хямраад эхэлжээ. Гэсэн ч төрийн тэргүүн нь “ОХУ-ыг хэн ч хэзээ ч ганцаардуулж, гацаанд оруулж чадахгүй” хэмээн олон улсад зарлаад авсан. Урд хөршийн удирдагч ч мөн удааширч буй эдийн засгаа унахаас нь өмнө аврахаар өсөх боломж нь өөдөө орнуудыг өөртөө урвуулан “Түнш” гэсэн шошгоор баталгаажуулахаар ажиллаж байна. Тухайлбал, Өмнөд Америкийн нөлөө бүхий улсуудын чухал гэсэн төлөөлөгчдийг эх орондоо урьж хамтын ажиллагаагаа өргөжүүлэх тал дээр тал засаад эхэлснийг харж болно. Дэлхийн эдийн засаг тийм ч таатай бус байгаа энэ үед хөршүүд маань хэдийнэ хөдлөөд эхэлсэн. Манай улсын хувьд ч шийдлийн Засгийн газар байгуулж, шинэ Ерөнхий сайд Ч.Сайханбилэгийн багийг хэрхэн ажиллахыг харж, хүлээж сууна.

Эдийн засагч, шинжээчдийн үзэж буйгаар Монгол Улс эдийн засгийн хямралд бус хүнд үед орсон гэх. Гэвч дөнгөн данган өдрийн хоолтойгоо залгах иргэдийн тоо нь боломжтой хэсгээсээ хавьгүй илүү учраас хүндрэл хямрал руу халтирахад тун ч амархан. Өнгөрсөн

борооны хойноос цув нөмрөхтэй адил хямраад ирэхээрээ “Хавтгайрсан халамжаас боллоо. Үргүй зардлаас үүдэлтэй” гээд халаглах хүн олон бий. Мөнгө модонд ургадаг мэт сэтгэж хоосон амлалтаар иргэдийг “худалдах” гэсэн улс төрийн явуургүй ролдлогууд өнөөгийн эдийн засгийн хүндрэлийг үүсгэсэн. Ерөнхий сайд Сайханбилэг хэлэхдээ “Энэ удаагийн хямралын үр үндсийг бид нэлээд хэдэн жилийн хугацаанд өөрсдөө бий болголоо. Дан ганц том төслийн хөрөнгө оруулалт, түүхий эдийн үнийн өсөлтөөс орж ирсэн орлогыг бэлнээр нь тараагаад, дутууг нь арилжааны зээлээр гүйцээх нь эдийн засгийн битгий хэл улс төрийн хүссэн үр дүн авчирдаггүйг өнгөрсөн сонгуулиуд харуулсан. Бонд, зээл хэчнээн босгосон ч, байдгаараа эдийн засгаа тэлэх гэж оролдсон ч бодлогоо зөв гаргаж, үр өгөөжөө зөв төлөвлөхгүй бол эдийн засаг хүссэнээр өсөхгүй байгааг бид харлаа” хэмээсэн. Мөн тэрбээр “Хасъя, багасгая, тэсье, тэвчье гэдэг зүйлсийг ярих нь байтугай бодох хүсэлтэй улстөрч лав байхгүй. Тэр тусмаа ийм зүйл хийх хүсэлтэй Ерөнхий сайд байна гэдэг

нуугаад яахав хүсээд байх зүйл биш. Гэхдээ гашуун ч гэсэн эм. Гачлантай хяслантай ч гарцаагүй хийх ёстой ажлыг барьж авахаас өөр сонголт энэ удаагийн Ерөнхий сайдад, Засгийн газарт байхгүй” гэдгийг УИХ-ын Чуулганы нэгдсэн хуралдаанд хэлсэн үгэндээ онцолсон.

Түүний зөв. Улсынхаа эдийн засгийг элгээр нь эвхрүүлэхгүйн тулд хэмнээд, гамнаад явахад буруудах зүйл үгүй. Нэгдсэн төсөвтэй болж орлого, зарлагаа зөв тооцохоос эхлээд төсөв нэртэй “хүслийн жагсаалт” батлахаа болих цаг ирсэн. Хөнжлийнхөө хэрээр хөлөө жийх бус, хүрч чадахгүй амлалтуудаар улс төрд үлдэх гэсэн өрсөлдөөнийг халах нь хүндрэлээс гарах эхний алхам гэх түүний үгтэй санал нийлэх нь олон буй за.

Мөн Тэрбээр төсвийн хэмнэлтийн хатуу бодлого явуулах ч халамжийг зорилгод бүлэгт нь чиглүүлнэ. Өрийн хэмжээг өсгөнө. Ингэхдээ арилжааны зээл биш, урт хугацаатай/30-40 жил/, бага хүүтэй тусламжийн зээл хөөцөлдөж олно. Ингэснээр хувийн хэвшлийг дэмжиж, тэднийг зээл авахад нь Засгийн газрын баталгаа гаргадаг болох хэрэгтэй гэж үзэв. Мөн төрийн албан хаагчдын орон тоог 15 хувиар бууруулна. Хөрөнгийн татварын тухай хууль хэрэгжүүлнэ. Ерөнхий сайдын албаа хүлээн аваад эдийн засгаа дапуурахаас нь өмнө авах арга хэмжээнүүдээ тэрбээр ийн багцаллаа. Товчхондоо, монголчууд үрэлгэн зангаасаа татгалзаж, хүний гар харж амьдрахаа болих нь ээ. Сайханбилэг сайдын эдийн засгийн бодлого монголчуудад “Хүний эрхэнд жаргахаар өөрийн эрхэнд зов” гэсэн сургаалийг суулгаж өгөх бололтой. “Тэжээнэ, тэтгэнэ” гэж амалсаар ирсэн төрийн бодлогыг хүртээмжтэй, хүртээлтэй болгоно гэх Ерөнхий сайдын эдийн засгийн бодлогыг манай сэтгүүлийн зүгээс “Билэгэномикс” гэж нэрлэлээ. Энэ нь олон улсад нэртэй Абэномикс, Обаманомикс гээд цөхөрсөн эдийн засгаа хөлд оруулсан эрхмүүдийн амжилт лугаа биелээсэй гэсэн далд хүсэлт тээсэн хэрэг.

Өнгөрсөн хоёр жилд ХАХНХЯ-аас хэрэгжүүлсэн төслийн хүрээнд Монгол Улсын бүх хүн ам, өрхийн судалгааны дүнд Монгол төр монгол хүнээ таньдаг болсон гэх. Ингэснээр халамжийг хавтгайруулах биш хэнд хэрэгтэй түүнд хүртээнэ гэсэн зарчим үйлчлэх болж байгаа аж. Данхар төр, давхар дээлээ ярьсаар буй улстөрчид өөрчлөлтийг өөрсдөөсөө бус иргэдийн

халааснаас хэмнэж эхэлсэнд ард олон тус бүрийн байр суурьтай байна. Халамж, хангамж шаардлагагүй гэж үзээд “Монгол Улсын УИХ-ын гишүүдийн төсөв” гэгдэх жилийн 90 сая төгрөгөөсөө татгалзах УИХ-ын гишүүн байна. Гэвч энэ талаар цөөн хэдэн гишүүнээс бусад нь ам ангайх дургүй байгаа нь “хоосон шоу” явуулаад байна гэх хардлагыг төрүүлж байгаа юм. Тухайлбал, УИХ-ын гишүүн Г.Баярсайхан “Туслахуудын цалин, бинзен, унааны мөнгө, утасны төлбөр гээд гишүүдэд зарцуулах төсөв гэж байдаг. Миний хувьд гишүүнийхээ цалинг аваад явж болж байна. 15 мянган төрийн албан хаагчийг халж чадаж байгаа юм чинь УИХ өөрөөсөө хэмнэлт хийж болно шүү дээ” хэмээн ярьжээ.

Хэдийгээр Засгийн газрын зардлыг танахаар яригдаж байгаа ч хэрхэн гүйцэлдүүлэх нь тодорхойгүй хэвээр. Тэгсэн атлаа иргэдэд хүртээх мөнгөн халамжийг хасах нэг бус хувилбар хэдийнэ бэлэн болжээ. Хүн бүр халамж хүсэлгүй амьдралаа залгуулаад явсан он жилүүд бидэнд бий. Гэнэт хаслаа, таналаа гээд ирэхээр иргэд ч таатай хүлээж авахгүй нь мэдээж. Гэхдээ халамжийн уршигаар бэлэнчлэх сэтгэлгээ сууж, хөдөлмөрлөх ч хүсэлгүй болсон иргэдийн тоо олширсоор буйг хөдөлмөр эрхлэлт, ажилгүйдлийн тоо гэрчлэх. Халамжийн бодлогыг өөгшүүлж ирсэн нь төр. Гэд алдаагаа засах гэж оролдож буй ч хүндрэл хямрал болоод байгаа энэ үед хүүхэд, хөгшид, нярайлсан эсвэл нярайлах гэж буй эхчүүдийг бүсээ чангал гэж “зарлигдах” нь хэнд хэрэгтэй түүнд хүртээнэ гэх ярианд нь хэр нийцэж буйг эргэн бодох хэрэгтэй. Хүүхдийн, ээжүүдийн одонгийн мөнгийг яригдаж буй хэмнэлтийн горимд шижүүлснээр 28.6 тэрбум орчим төгрөг хэмнэхээр байгаа аж. Гэтэл сүүлийн гурван жилд 300 орчим тэрбум төгрөгийг тэтгэлэг нэрээр Монгол Улсад сурч буй бүх оюутанд тараасан нь “Сурч байгаад баярлалаа” гэсэн халамж болж хувирсантай “70-д дуртай” оюутнууд ч санал нэг буй.

2015 оны төсвийн тодотголын эхний хэлэлцүүлэг УИХ-аар халуухан хэлэлцэгдэж буй энэ үед Төсвийн урсгал зардлыг 518 тэрбум төгрөгөөр танаж байгаа нь олзуурхах зүйл. Нэг тэрбум төгрөгөөр яригддаг төсвийн хөрөнгө оруулалт 320 тэрбумаас дээшлэхгүй болсон энэ цагт тэвчиж болох хөрөнгө оруулалтыг эцэст нь тулгал царцаахаас аргагүй. Шийдлийн Засгийн газар таналтыг тулгал нь

хийнэ гэж байгаа ч цөөнгүй аймгийн хэд хэдэн сумын Хөгжимт драмын театр, соёлын төвийг барихад энэ онд тус бүр 1-2 тэрбум төгрөг төсвийн төсөлд туссан байх жишээтэй. Сургууль, цэцэрлэгийн барилга л биш бол эдгээрийг энэ жилдээ зогсооход юу нь болохгүй байх билээ. 2011 оноос төсвөөс хөрөнгө татаж эхэлсэн дээрх Хөгжимт драмын театруудын нэг сумынх нь театрын нийт төсөв л гэхэд 8-9 тэрбум төгрөг шаардлагатай аж. Хэдэн он дамнасан засвар шинэчлэлд хямралтай жил нэг тэрбум төгрөг тавиад ч дуусахгүйгээс хойш хөрөнгө оруулалтыг хойшлуулахад буруудахгүй.

Мөн оюутны 70 мянгыг бүр болиулах боломж харагдаж буй. Сургалтын төлбөртөө нэмэрлэдэг оюутан мэр сэр бий л байх. Гэхдээ Засгийн газар тэднийг бэдэн мөнгөөр “эрхлүүлж” байгаа нь оюутан залуусын тансаглал хэрээс хэтгэж байгааг илтгэсэн баримт нотолгоо ч багагүй сонсогдох болсон. Тэгээд ч эх, хүүхдийн халамжийн хэдэн төгрөгийг хоёр, гурван сараар нааш цааш татаж, гавьтай мөнгө хэмнэхгүй зүйлээр оролдож, иргэдийг бухимдуулж байхаар нь оюутны тэтгэлэг гэгдэх 90 тэрбумыг онилоход гэмгүй. Засгийн газрын тусгай сангуудыг цөөлж 10 тэрбум төгрөгийн хэмнэлт гаргасан шигээ л үзэх хэрэгтэй. Түүнчлэн Засгийн газраас Хөрөнгийн татварын тухай хууль санаачлан /автомашин, орон сууц, буу, малын хөлийн татвар/ гэсэн дөрвөн төрлийн татварыг нэмэгдүүлэх хуулийн төсөл чуулганаар хэлэлцүүлж байна. Хэдийгээр хямралтай үед иргэдийг татвараар дарамталж болохгүй гэх яриа Төрийн ордонд их ч бэлчээр доройтож, зарим нутагт худаг уснаас болж дайн дэгдэх нь холгүй болж буй энэ үед малын хөлийн татварын асуудлыг ярихад буруудах юун.

Эдийн засаг хүндрэлтэйн сацуу сонгуулийн өмнөх жилийн төсвөөс санасан хэмжээний хэмнэлт гаргахад бэрх. Гэхдээ юуны тулд шийдлийн гэсэн тодотголтой засаг билээ бодлого, зорилгоо илүү тодорхой байлгаж, шийдвэртэй, зоримог хандахаас аргагүй.

Ямартай ч Ерөнхий сайд Ч.Сайханбилэгийн хэмнэлтийн Засгийн газарт амжилт хүсье. Яарвал даарах. Тэгэхээр зөв, буруу гэж дүгнээд яахав. Билэгэномиксийн бүсээ чанагалах арга зам нь хэр их хэмнэлт авчрахыг, ямар үр дүнд хүрэхийг харж, хамтаараа тунгаан бодъё. ■

АБЭНОМИКС

Царцсан эдийн засаг

Б.БАЯН

Эдийн засгаа өсгөх хүсэлтэй ихэнх орнууд инфляцийг бууруулахаар онилж, өгөөжгүй зардлаа хумих, мөнгөний нийлүүлэлтийг багасгах аргуудыг эрэлхийлдэг. Аралын Японд байдал харин эсрэгээрээ. Ерөнхий сайд Абэ, Төвбанкны хамтаар инфляци бууруулах бус харин ч өсгөн хоёр хувьд хүргэхээр зорьж байна. Ингэхийн тулд эдийн засагтаа их хэмжээний мөнгө “цутгахаар” тусгасан. Түүнчлэн төрийн оролцоог эдийн засгийн зарим салбараас халах, багасгах замаар үйлдвэрлэлийг дэмжин, экспортыг нэмэгдүүлэх юм. Хэрэглэгчдийн худалдан авалт нэмэгдэх нь Японы эдийн засгийг эргэлтэд оруулах бас нэгэн хүчин зүйл тул цалингийн хэмжээг нэмэх, хөрөнгө оруулалт татах үүднээс олон улсын бизнес эрхлэгчдэд “хямд” иен санал болгож байна. Ингэхийн тулд эдийн засагтаа иен зохист хэмжээнд бэлнээр нийлүүлж буй. Абэномикс энгийнээр нэг иймэрхүү.

“ Эдийн засгийн эерэг өөрчлөлтүүд гарсаар байгаа ч Япон улс дефляциас хараахан холдоогүй байна.

Өсөлт хэрхэхийг ажиглах нь чухал. ”

Хүн ам нь хөгширсөн, эдийн засаг нь царцсан, өсөлт үзэлгүй 20-иод жилийг үдсэн гээд хөгжлийн үлгэр жишээ гэгдэх Японд хөгжихгүй зогссон зүйл олон. 1990-ээд оны эхээр Японы хөрөнгийн зах зээл, үл хөдлөхийн салбарт үнийн хөөс хагарснаар компаниуд өр барагдуулах, үйлдвэрлэлээ гадаад орнууд руу


шилжүүлэх асуудалд түлхүү анхаарах болов. Улмаар цалингийн хэмжээ буурсан нь, хэрэглэгчдийн худалдан авах чадварт хүчтэй нөлөөлсөн. Ийн тус улсын эдийн засаг царцаж эхэлсэн. Хүнсний бүтээгдэхүүн, тус улсын гол нэрийн бараа бүтээгдэхүүн болох сакений үнэ огцом уруудаж байлаа. Бараа, бүтээгдэхүүний үнэ ийн буурч, »



Японы эртний нэгэн үлгэрт гардгаар багцалсан гурван сумыг хугалахад нэгийг хугалахаас хэцүү гэсэн сургаамжит санаанд үндэслэн Абэномиксийг боловсруулсан гэдэг.

ДЕФЛЯЦИЙН ҮЗҮҮЛЭЛТ

Хүнсний хэрэглээний үнийн индекс



Эх сурвалж: Японы дотоод хэргийн яам

худалдан авалт зогсонги байдалд орсон зэрэг нь эцэстээ дефляци болж хувирсан. Эдийн засгаа сэргээхээр олон Ерөнхий сайд суудал сэлгэж байжээ. Улмаар 2006 онд Шинзо Абэ Ерөнхий сайдын албыг хүлээн авсан ч өсөлт мөн л талаар болсон. Гэвч тэрбээр 2012 онд шинэ бодлого, шинэ төлөвлөгөөтэй эргэн ирсэн нь Абэномикс гэж олонд алдаршив.

Японы эртний нэгэн үлгэрт гардгаар багцалсан гурван сумыг хугалахад нэгийг хугалахаас хэцүү гэсэн сургамжит санаанд үндэслэн Абэномиксийг боловсруулсан гэдэг. Абэгийн гурван сумт бодлогын хүрээнд тус улсын Төвбанк 20.2 их наяд иен буюу 210 тэрбум ам.доллараар үнэлэгдэх тогтворжуулах хөтөлбөр хэрэгжүүлэх бөгөөд үүний тэн хагас нь зам, гүүр, цунамигаас хамгаалах далан барих гээд дэд бүтцийн салбарт чиглэх юм. Түүнчлэн Абэгийн Засгийн газар 600 мянган ажлын байр шинээр бий болгохоор ажиллаж байна. Ингэхдээ эмэгтэйчүүдийг хөдөлмөрийн зах зээлд уриалан оролцуулах, хөдөлмөрийн зах зээлээ төрөлжүүлэх бодлого баримталж буй. Удаах чиг нь эдийн засгийг дэмжигч салбарууд дахь төрийн оролцоог багасгах, улмаар аж үйлдвэр, эрчим хүч, эрүүл мэндийн салбарыг чөлөөлөх зорилт тээж байгаа юм.

Иенийн ханш суларсаар өнгөрсөн оны сүүлийн сарын байдлаар нэг ам.доллар 125 иентэй тэнцэж байв. 2012 оны сүүлээс хойш нэг ам.доллартай харьцах иенийн ханш 7.8 хувиар буураад буй. Улмаар өнгөрсөн арванхоёрдугаар сард сүүлийн 27 сард гараагүй доод хэмжээнд хүрсэн нь үйлдвэрлэлд эерэг хүлээлт авчрах нь гэх хүлээлт үүсгэсэн юм. Борлуулалт нэмэгдсэнээр байгууллагууд цалингаа өсгөх боломжтой болж, иргэдийн худалдан авалт нэмэгдэх найдлага бий болжээ. Түүнчлэн хөрөнгийн зах зээл дээрх хувьцааны үнэ ч өсөх хандлагатай байгаа юм.

Абэномиксийн нэг зорилт ийн хөрсөнд бууж, дэлхий нийт хямд үнээр

Япон бүтээгдэхүүн худалдан авах таатай нөхцөл бий болсон. Экспорт нэмэгдсэн нь үйлдвэрлэл өсөх таатай боломж бүрдүүлсэн. “USForex Inc”-ийн дилер Леннон Свийтинг “Иен суларч байгаа нь Японы эдийн засагт урагшлах боломж өгнө. Учир нь Япон чанарын бүтээгдэхүүнийг дэлхий нийт хямд үнээр хүртэх боломжтой болж буй. Түүгээр ч зогсохгүй олон улсын бизнес эрхлэгчдэд Японтой түншлэхэд өртөг багатай болж байгаа юм” гэсэн байна.

Гэвч мөнгөн тэмдэгт хэт их унавал дотоод зах зээлд халтгай болохыг Олон улсын валютын сангаас Японы Засгийн газарт анхааруулсан. Учир нь гадаад зах зээлд нэвтрэх хүсэлтэй Японы бизнес эрхлэгчид ханшийн зөрүүнд “дарлагдах” эрсдэлтэй бөгөөд иенийн сулрал хэдийнэ ДНБ-ийг нь хоёр дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх тус улсын гадаад өрийн хэмжээг өсгөхөөр байгаа юм. Тус улсын өрийн хэмжээ өдгөө 10.46 их наяд ам.долларт хүрээд байна. Үүний улмаас зээлийн хүүг өсгөх боломжгүй болж байгаа юм. Энэ нь бондын зах зээлд сөрөг мессэж түгээх эрсдэлтэй. “Японы өрийн хэмжээ хэт их байгаа учир хүүг өсгөх нь төсөвт хүндрэл учруулж болзошгүй. Энд нэг зүйлийг ойлгох хэрэгтэй. Абэгийн бодлогын чухал бүрэлдэхүүн нь инфляцийн өсөлтийг хүүгийн өсөлтөөс давуулах. Тэгэхээр инфляци үүсгэх зорилгоор бонд худалдаж авна гэсэн үг. Улмаар ДНБ-ий өсөлт өрийн өсөлтөөс их болж, ДНБ-тэй харьцах өрийн хэмжээг багасгах юм” хэмээн “The Economist”-ийн редактор Ип тайлбарлав. Тэрбээр “Дэлхийн баян гэгдэх орнуудын зээлийн хүү тэг хувьд гацчихаад байна. Эрх баригчид үүнээс

гарах арга зам хайсаар буй ч шийдэлд хүрч чадахгүй байгаа юм. Япон энэ тойргоос мултарч чадвал бусаддаа итгэл өгөх болно” гэсэн юм. Харин “Project Syndicate”-д нийтэлснээр өрийн таазыг нэмэх, зээлийн хүүг өсгөх гэсэн хоёр зүйлийг нэг дор хийх нь гамшиг дагуулах “жор” аж.

Олон улсын валютын сан тус улсын Засгийн газар мөнгөний бодлогоо хэт тэлэх нь Засгийн газрын бондын өгөөжийг хэт өсгөж улсын өрийн хэмжээг тогтворгүй болгоно гэж үзжээ. Тус улсын бондын өгөөж бусад хөгжингүй орнуудынхтай харьцуулахад хамгийн бага хэвээр байгаа.

Хөрөнгө оруулагчдын зүгээс Абэ шийдэмгий алхам хийхийг хүлээж буй. Тодруулбал, АНУ-тай хийх худалдааны гэрээг үзэглэх нь тус улсад гадаадын бүтээгдэхүүн, үйлчилгээ нэвтрүүлэх чухал алхам болох учиртай юм. Уг гэрээ нь Америк болон Ази тивийн 11 оронтой чөлөөт худалдаа явуулах зөвшилцөл юм. Эдийн засагт онцгой үүрэгтэй гэгдэж буй ч дотоодын өрсөлдөх чадварт сөрөг үр дагавар авчирна гэж Японы зарим салбарын төлөөлөгчид үзэж байгаа билээ. Харин олон улсын шинжээчдийн харж буйгаар тус гэрээг үзэглэснээр АНУ, Япон хоорондын харилцаа ахисан түвшинд хүрэх бөгөөд хоёр улсын хамтын ажиллагаа Америк төдийгүй Азийн хэмжээнд чухал үр дүн авчирна аж. Түүнчлэн Америк, Японы аль нь ч эдийн засгийн удаашралд орох хүсэлгүй тул хүчээ нэгтгэн гадаад худалдаагаа өргөжүүлэх нь дэлхийн эдийн засгийн эргэлтэд ч эерэг нөлөө болох учиртай гэдгийг эдийн засагчид онцолж буй. ■



"Wall Street Journal"-ийн санхүүгийн зах зээлийн ахлах аналитст Стив Моор
"Реганомикс АНУ-д сүүлийн 20 жилд бүтээсэн баялгаас ч илүүг иргэддээ өгсөн" хэмээжээ.

РЕГАНОМИКС & ОБАМАНОМИКС

Хямралыг удирдахуй

Б.ЖАРГАЛ

Дэлхийн хүчирхэгүүдийн тоог зүй ёсоор гүйцээх АНУ-д эдийн засаг хямарвал дэлхий нийт дагах нягууртай. XX зуун гарснаас хойш тохиосон эдийн засгийн хямралыг даван туулах бодлого, арга замаараа түүхэнд мөнхлөгдөн үлдсэн ерөнхийлөгчдийн нэг болох АНУ-ын Ерөнхийлөгч асан Роналд Реган 1981 онд албан үүрэгтэй томилогдож байлаа. Тэрбээр 1969 оноос эхтэй Америкийн эдийн засгийн уналтыг зогсоох ширүүхэн бөгөөд хүндхэн "тулаанд" ялалт байгуулж чадсан нэгэн. Түүний засагласан тэдгээр оныг 2008-2009 оны санхүүгийн хямралаас ч хэцүү, тогтворгүй үе байсан гэдэг.

Ерөнхийлөгчийн албыг хүлээн авахдаа Реган 10.8 хувьд хүрч дээд "амжилт" тогтоогоод байсан ажилгүйдлийг бууруулах, 13.5 хувьд гаарсан өндөр инфляцийг нам дарах хагуухан зорилттой нүүр тулсан. Тухайн үеийн томоохон эдийн засагчид "АНУ инфляци гэгч тахалд гүн нэрвэгдсэн. Үүнийг зогсоох арга байхгүй тул Америк эдийн засгаа нуран унахыг харах л үлдлээ" хэмээн дуу нэгтэй мэдэгдэж байжээ. Зээлийн хүү тэнгэрт хадаж 1980 он гэхэд 21.5 хувьтай гарч байв. Ядуурал газар авч Америкийн хүн амын 33 хувьд хүрсэн, дундаж өрхийн орлого 10 хувиар буурсан гээд муу мэдээ мундахгүй их. Түүнчлэн 1982 оны байдлаар "Dow Jones"-ийн зах зээлийн үнэлгээ 70 хувиар буурсан нь тус улсад хөрөнгийн зах зээл ямар түвшинд хүрсэн байсныг гэрчилж буй.

Ийн сөхөрсөн эдийн засгийн улмаас туйлдаж байсан иргэдээ аврахаар Реган дөрвөн чиг бүхий эдийн засгийн бодлого хөтөлбөр хэрэгжүүлэхээ зарлав.

- Эдийн засгийн өсөлтөд түлхэц болох үүднээс татварын хэмжээг бууруулах. Татварын бодлогоор эдийн засгаа дэмжихээр шийдсэн Реган 70 хувь байсан хүн амын орлогын албан татварыг 50 хувь болгон бууруулсан байдаг. Улмаар 25 хувь хүртэл шатлан багасгасан юм.
- Улсын зардлыг танах замаар тэрбээр хэмнэлтийг хийж чадсан. Реган улсын төсвийн таван хувьтай тэнцэх хэмжээний хэмнэлт хийхээр төлөвлөсөн нь АНУ-ын өнөөгийн төсвөөс 175 тэрбум ам.доллар танасантай дүйх юм. Түүнчлэн батлан хамгаалахын салбараас бусад салбарын зардлыг 1981-1982 онд 14.4 хувиар, 1981-1983 онд 16.8 хувиар бууруулжээ. Ийнхүү 1983 онд ДНБ-ийх нь 23.5 хувийг эзэлж байсан АНУ-ын Засгийн газрын зарлага 1989 онд 21.2 хувь болж буурсан байдаг. Хэдийгээр хоёр орчим хувийн таналт их биш мэт боловч тухайн үед дунджаар 10 орчим хувиар өсөж байсан эдийн засагт томоохон хэмжээний өөрчлөлт авчирсан юм.
- Инфляци Реганы гол дайсан байлаа. Үүний эсрэг тэмцэхдээ тэрбээр мөнгөний нийлүүлэлтийг багасгах арга хэмжээ авчээ. Улмаар ам.долларын ханиа тогтворжиж, бусад валюттай харьцах ханшийг нь чангаруулсан. ►



Харин өдгөө Обаманомикс Америкийн хөргийг бүтээж байна. Түүний бодлого Реганомиксоос тэс өөр.

- *Реганы хэрэгжүүлсэн удаах арга хэжээ нь эдийн засгийн онцлох салбаруудад төрийн оролцоог багасгах, халах байлаа. Ингэснээр тус улс нэг жилд 100 тэрбум ам.доллар хэмнэсэн аж. Ерөнхийлөгчийн эхний захирамж газрын тос, байгалийн хийд ногдуулах үнийн хязгаарлалтыг зогсоох байсан юм. Улмаар үйлдвэрлэл нэмэгдэж, ам.долларын ханишийн таатай нөхцөлөөс үүдэн газрын тосны бүтээгдэхүүний үнэ 50 гаруй хувиар буурсан.*

Дээрх замаар хэмнэлтийн горимд шилжин, татвар, хөнгөлөлтийн бодлогоор чухал салбаруудаа дэмжсэн нь эдийн засгийн түүхэн дэх хамгийн амжилттай “туршилт” болсон гэдэг. “Reagan recovery” гэгдэх Роналд Реганы авчирсан эдийн засгийн сэргэлт албан ёсоор хэрэгжиж эхэлснээс буюу 1982 оноос хойш 92 сарын турш ухралт үзүүлээгүй. Харамсалтай нь, тус улсын Засгийн газар 1990 оны төсвийн хүрээнд татварын хэмжээгээ нэмэх асуудлыг дэмжсэн нь Реганомикст цэг тавьсан гэж болно. Энхтайвны жилүүд гэсэн тодотголтой Реганомиксийн засаглал дэлхийн эдийн засгийн түүхэнд хамгийн урт оршин тогтносон гэдгээрээ алдартай. Түүний бүтээсэн, авчирсан ололтууд АНУ-ын эдийн засгийг тухайн үед дэлхийн гурав дахь том эдийн засаг болж байсан Баруун Германы эдийн засгийг бүхэлд нь нэмсэнтэй адил тэлж.

Нуран унах дээрээ тулсан АНУ-ын эдийн засаг 1984 онд гэхэд л 6.8 хувийн бодит өсөлт үзүүлжээ. Энэ нь сүүлийн

50 жилд гараагүй сайн үзүүлэлт байсныг тухайн үеийн хэвлэлүүд онцолсон байдаг. Ерөнхийлөгчөөр ажилласан хугацаандаа Реган ажилгүйдлийн түвшинг 20 сая шинэ ажлын байраар цөөлж, улмаар хөдөлмөр эрхлээгүй иргэдийн тоог 5.3 хувьд хүргэн бууруулсан. Өмнөх ерөнхийлөгчдийн үед цойлж байсан инфляци уруудсаар нэг жилийн дотор 3.2 хувьд хүрсэн юм. Түүнчлэн нэг хүнд ногдох бодит орлогын хэмжээ 18 хувиар тэлсэн нь америкчуудын амьжиргааны түвшнийг 20 хувиар нэмэгдүүлсэн байдаг. Ядуурлын харьцаа жил бүр дээд хэмжээнээс 1/6-ээр унаж байсан төдийгүй тус улсын хөрөнгийн зах зээл сэргэж эхэлсэн. Эдгээр нь сүүлийн 10 жилд гараагүй дээд амжилт болсон байдаг.

“Wall Street Journal”-ийн санхүүгийн зах зээлийн ахлах аналитст Стив Моор хэлэхдээ Реганомиксийн ачаар АНУ-ын эдийн засаг 25 жил үргэлжлэх өсөлтийн замналд орсон бөгөөд 1990, 2001 оны хямралыг эс тооцвол харьцангуй сайн өсөж ирсэн” гэжээ. Тэрбээр “Реганомиксийн үе бол дэлхийд эдийн засаг гэдэг ойлголт түгэснээс хойшхи баялаг бүтээсэн хамгийн шилдэг онууд байсан гэж болно. 1980 онд АНУ-ын нийт эдийн засаг өнөөгийн ханшаар 25 тэрбум ам.долларт үнэлэгдэж байсан. Тэгвэл Реганы бодлогын ачаар тус тоо 2007 он гэхэд 54 их наяд ам.доллараар хэмжигдэх болов. Дүгнээд үзвэл Реганомикс АНУ-д сүүлийн 20 жилд бүтээсэн баялгаас ч илүүг иргэддээ өгсөн” хэмээжээ.

Харин өдгөө Обаманомикс Америкийн хөргийг бүтээж байна. Түүний бодлого Реганомиксоос тэс өөр. Эсрэгээрээ ►►

ч гэж болох. АНУ-ын Ерөнхийлөгч Барак Обама “Баян нь татвараа ахиухан төлдөг байх ёстой” гэдэг философийг баримтлагч. Үүнийгээ баялгийн дахин хуваарилалт гэж үзэж буй. Обамагийн хэрэгжүүлж буй эдийн засгийн бодлогод “Obamacare” буюу эрүүл мэндийн реформ багтсан нь гол онцлог нь. Реганомиксоос хойш түгээмэл яригдах болсон эл бодлогыг шүүмжлэгчид “Баячуудад ногдуулах татварын шинэчлэлээс бусад арга хэмжээ улсын эдийн засагт нөлөө бүхий бусад салбарыг хөлдөө чирч буй” гэх. Харин Обамаг дэмжигчид “Хэдийгээр улс орны эдийн засаг хүнд байгаа ч Обамагийн зоримог шийдвэр асуудлын гарц. Хөгширсөөр буй хүн амынхаа эрүүл мэнд, нийгмийн асуудлыг орхигдуулахгүй байгаа нь сайшаалтай” хэмээн “Obamacare”-д саналаа өгсөөр. Ядууралтай тэмцэхээр Обама цалингийн доод хэмжээг нэг цагийн 7.25 ам.доллар болгох санаачилгыг 2011 онд гаргаж байсан бол удаах сонгуульд ялсныхаа дараа уг хэмжээг 9.50 ам.доллар болгох, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хуульчлах тухай санал дэвшүүлжээ. Улмаар төсвийн байгууллага болон барилгын салбарт ажиллагсдын цалинг 10 ам.доллар болгохоор 2014 оны нэгдүгээр сард шийдвэрлэсэн нь энэ оны эхээр хүчин төгөлдөр хэрэгжихээр байна. Мөн Обама АНУ-д хэдийгээр татвар төлөгчид жилд 15 тэрбум ам.долларыг эрүүл мэндийн даатгалын санд төвлөрүүлж буй ч 47 сая иргэн эрүүл мэндийн даатгалд хамрагдаж чадахгүй байгаад халаглаж байгаагаа илэрхийлж байсан. Обамагийн онцолж байгаагаар эрүүл мэндийн даатгалын босго өндөр байгаа нь дээрхийн үндсэн шалтгаан аж. Иймд эрүүл мэндийн реформоо хүртээлтэй, хямд болгохоор ажиллана гэдгээ мэдэгдсэн.

Танах биш тэлэх замаар эдийн засгаа хөгжүүлэхээр зэхсэн Барак Обама улсынхаа эрчим хүчний салбарт шинэчлэл хийхээр мөрийн хөтөлбөртөө тусгасан. Үүнийхээ хүрээнд АНУ-ын газрын тосны хэрэглээг 35 хувиар буюу өдрийн 10 сая бареллиар багасгах юм байна. Улмаар 2030 он гэхэд ОПЕС-ийн орнуудаас импортлох нефтийн бүтээгдэхүүний хэмжээг бууруулах бөгөөд импортоос хараат бус байдлаа нэмэгдүүлэхээр зорьж байна.

Реганомикс татварын хөнгөлөлтөөр эдийн засгаа дэмжиж байсан бол Обама татварыг нэмэх нь асуудлын гарц гэж үзжээ. Тухайлбал, “Obamacare” бодлогын хүрээнд сүүлийн хоёр жилийн хугацаанд эрүүл мэндийн салбарыг дэмжих үүднээс хүн амын орлогын албан татварыг 60 орчим хувиар нэмсэн. Мөн байгууллагын ногдол ашгийн татварыг гурав дахин өсгөсөн байна. Түүнчлэн баялаг бүтээгчид гэх цолтой хувийн хэвшил, хөрөнгө оруулагчдын эрүүл мэндийн татварыг 62 хувиар нэмжээ. Нас барагсдад ногдуулах татвар ч мөн 55 хувь болон шинэчлэгдсэн аж. Татварын асуудал ингээд дуусахгүй, бусад салбарт шинэчлэгдэн нэмэгдэнэ гэдгийг Обамономикс судлаачид хэлж буй.

Обамагийн Засгийн газар зардлаа хэмнэх бус өсгөх төлөвлөгөө барьжээ. Үүрэгт ажлаа анх авахдаа нэг тэрбум ам.долларын нэмэлтийг төсөвтөө суулгасан нь Засгийн газрын зардлыг 28 хувиар тэлж буй хэрэг болсон. Түүнчлэн 2012 оны зарлагын саналдаа уг үзүүлэлтийг 2021 он гэхэд 57 хувиар тэлэх асуудлыг багтаажээ.

Реган мөнгөний нийлүүлэлтийг багасган ам.долларын ханшийг өсгөж байсан бол Обамагийн эринд тус улсын мөнгөн тэмдэгтийн бусад валюттай харьцах ханш суларч, улмаар инфляци өсөж байна гэх. Реганомиксийн үндсэн зарчмуудын нэг улс төрийн оролцоог халах байсан бол одоогийн Ерөнхийлөгч хувийн хэвшлийг чөдөрлөж байгааг эрүүл мэнд, эрчим хүч, санхүүгийн салбаруудад авч хэрэгжүүлэх бодлогоороо харуулж байна хэмээн зарим дэлхийд нэртэй эдийн засагч, судлаачид үзэж байгаа юм. Тодруулбал, Реган “Эрчим хүчний салбарыг чөлөөлье” гэсэн уриатай ажиллаж байсан бол Обамагийн эрчим хүчний боломжит хувилбаруудыг нэмэх гэсэн ногоон тэмүүлэл нь уламжлалт хэрэглээг багасгахын тулд үнэ, татварын бодлогоор уяж байгаа гэнэ.

Харьцуулан үзвэл эсрэг голдиролоор замнах дээрх эдийн засгийн засаглалууд тун ялгаатай. Реган эдийн засгийн өсөлтөө 7.1 хувьд тогтворжуулсан бол Обама дөнгөж 2.8 хувийн амжилт үзүүлжээ. Реганомиксийн үед ажилгүйдэл долоон улирлын турш буурсаар 7.5 хувьд хүрсэн байдаг. Обамономикс хэрэгжсэнээр эл үзүүлэлт 1.3 хувийн ухралт хийсэн байна.

Дэлхийн II дайны дараа тохиосон хямралууд дунджаар 10 сар үргэлжилсэн гэдэг. Хамгийн удаан үргэлжилсэн нь 16 сар. Харин өнөөдрийг хүртэл үргэлжилж буй Америкийн хямрал 40 сар үргэлжилж байгаа бөгөөд ажилгүй иргэдийн тоо 8.8 хувиас буурахгүй байгааг тус улсын эдийн засагчид онцолж байна. Их хямралаас хойш АНУ ийм тааруу үзүүлэлт харж байгаагүй аж. Өнгөрсөн онд тус улсын “Census Bureau”-оос хийсэн судалгаанд АНУ-ын ядуурлын түвшин сүүлийн 51 жилд байгаагүйгээр өссөн тухай дурьджээ.

Реганомикс эдийн засгийн өсөлтийн дайсан болох өндөр инфляцийг дийлж чадсан. Харин Обамономикс 25 жилийн турш харьцангуй нам байсан инфляцийг хөөрөгдөж байгааг Америкийн зарим эдийн засагч шүүмжилж байгаа юм. Эдийн засагч Жон Лотт “Ерөнхийлөгч Обама сүүлийн жилүүдэд үргэлжилж буй эдийн засгийн хямралыг Их хямралаас хүнд хэмээн ярьсаар буй. Би үүнтэй санал нийлэхгүй. Миний харж байгаагаар бол хямрал гол асуудал биш. Түүний зорьж буй эдийн засгийн сэргэлтийг Их хямралаас хойшхи гарсан хамгийн муу нь гэж хэлмээр байна” гэжээ.

Татварын тогтолцоо нь хэдийнэ тогтворжсон үед Реган Засгийн газраа байгуулжээ. Харин Обама хуучирсан тогтолцоог шинэчлэхээр ажиллаж байна. Тэрбээр татварын шинэчлэлээ 2013 онд өргөн барьсан бөгөөд хэрэгжилтийн явцтай хамт хөгжиж байна. ■

“
 Үр хойчдоо өрийн дарамт
 үүрүүлэхгүйн тулд Засгийн
 газар үрж буй цент бүрээ сайтар
 тооцоолох хэрэгтэй. Миний хувьд
 Засгийн газрын хөтөлбөр бүрийг
 хүлээн зөвшөөрөх хэрэггүй гэж
 үздэг. Үр дүн авчрахгүй төрийн
 албад, мөрийн хөтөлбөрт хөрөнгө
 зарах асуудлыг хязгаарлаж,
 Засгийн газрын бүхий л хэсэгт
 хэрэгжиж болохуйц туршлага,
 технологийг нэвтрүүлэх замаар
 хувийн хэвшилтай хамтрах болно

БАРАК ОБАМА

”

MONGOLIAN
ECONOMY

| Тавантолгой Монголын эмгэнэл | Бидний алдааг битгий давтаарай |
| Оюутолгой бол манай улсын одоогийн улс төрийн үнэн төрх | "Эмэгтэйчүүд тэнгэрийн
талыг дааж явдаг" | Модоо барьсан зуун жил | Төр гэдэг бизнес |

СОРИЛТ ГАРЦ ХӨГЖИЛ

(2011-2014 ЭМХЭТГЭЛ)



ЭМХЭТГЭЛ 2014

“Mongolian Economy”
сэтгүүлийн
2011-2014 оны онцлох
ярилцлага, нийтлэлүүд

ХУДАЛДАХ ҮНЭ
40.000₮

www.mongolianeconomy.mn





Л.БЯМБААГИЙН БУЛАН

Монголын эдийн засгийн төлөв 2015 онд

Дэлхийн эдийн засгийн төлөв

Дэлхийн эдийн засгийн өсөлтийн 2014 оны эцсийн гүйцэтгэл өмнө нь төсөөлж байснаас ялимгүй доогуур байдалтай хаагдахаар байна. АНУ-ын эдийн засаг сэргэж байгаа хэдий ч энэ нь хөгжиж буй орнуудын, нэн ялангуяа, ОХУ-ын эдийн засаг буурсан, Хятад, евробусийн гүйцэтгэл төсөөлж байсан хэмжээнд хүрээгүйтэй холбоотой байна.

2015 онд дэлхийн ДНБ-ий өсөлт дунджаар 2.2, АНУ 3, Евро бүсийнх 1.3, Хятадын эдийн засгийн өсөлт 7.0 хувь байх таамаг байна. Энэ нь оны эхэнд хийж байсан таамгуудтай харьцуулахад дэлхийн өсөлтийг бууруулсан байдалтай байна. Гэхдээ шагахуун түлшний үнэ огцом хямдарч байгаа нь 2015 онд зарим талаараа дэлхийн эдийн засагт сэргэхэд эерэг нөлөө үзүүлж болзошгүй байна.

Монголын эдийн засаг 2014 онд

Өнгөрсөн онд хамгийн их нөлөө үзүүлэх байсан Оюутолгойн далд уурхайн санхүүжилтийн хэлцэл зургаадугаар сард хийгдэх байсан боловч дахин хойшилсон нь Монголын эдийн засаг дахь эмзэг байдлыг даамжруулав.

2014 оны эцсээр ДНБ өсөлт нь 6.5 орчим хувь руу бууж ирэх төлөвтэй байна.

Экспортын бүтээгдэхүүний үнэ дэлхийн зах зээл дээр нэмэгдээгүй, гадаадын шууд хөрөнгө оруулалтын хэмжээ буурсаар байгаа тул ам.долларын дотогш чиглэсэн урсгал тоймтой байдлаар нэмэгдэж өсч чадахгүй байгаагаас ам.долларын ханш үргэлжлүүлэн чангарч түүхэн дээд хэмжээнд хүрч хаагдах нь. Харин гадаад худалдааны тэнцэл зэсийн экспорт нэмэгдсэн, импорт их хэмжээгээр буурсан зэргээс улбаалан эерэг тэнцэлтэй гарах боломжтой боллоо.


Инфляцийн өсөлтийг тогтоох, ханшийг тогтворжуулах зорилгоор Монголбанкнаас мөнгөний хатуу бодлого хоёрдугаар хагаст явуулж эхэлсэн, мөн бизнесийн идэвхжил, эрэлт буурсантай холбогдуулан инфляцийн өсөлтийн хурд саарч жилийн эцсээр 12 орчим хувь болох төлөвтэй байна. ▶

Хүснэгт 1. ДНБ-ий өсөлтийн таамаг 2014, 2015 онд, хувиар

	Дэлхий		АНУ		Евро бүс		Хятад	
	2014	2015	2014	2015	2014	2015	2014	2015
Fitch	2.5	2.9	2.4	3.1	0.8	1.1	7.3	6.8
CitiBank	2.7	3.1	2.3	3.0	0.8	1.1	7.3	6.9
Дэлхийн банк	2.8	3.4	2.1	3	1.1	1.8	7.6	7.5
ОУВС	3.4	4	1.7	3	1.1	1.5	7.4	7.1


Эх сурвалж: дурдсан байгууллагуудын эдийн засгийн тайлан, 2014 оны сүүлийн хагаст хийсэн таамаг

Зураг 1. ДНБ-ий улирлын өсөлт, 2010 оны зэрэгцүүлэх үнээр



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Зураг 2. Улсын жилийн инфляцийн түвшин /хувиар/



Хүснэгт 2. 2014 оны үндсэн үзүүлэлтийн таамаг

Үзүүлэлт	2014 оны гүйцэтгэлийн урьдчилсан таамаг	2015 онд
ДНБ-ий өсөлт, хувь	6.5%	5%
Инфляци, хувь	12%	12%
Зээлийн хүү, хувь	18%	19%
USD/MNT, оны эцэст	1,900	2000
Чанаргүй зээлийн хэмжээ, хувь	5%	6%

ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСАГ

Өнгөрсөнд нуутдах ирээдүй

Б.ҮҮРИЙНТУЯА

ОХУ-ыг хямрах санхүүгийн хүндрэл. Шалдаа буусаар буй газрын тосны ханшийн эсрэг ам.долларын чангарал болон АНУ-ын эдийн засгийн сэргэлт. Моданаас гарах хөгжиж буй орнууд, тэдний үнээ алдах мөнгөн тэмдэгт.

Дээрхийг ажихад 2015 оны дэлхийн эдийн засгийн өнгө нэг л таагүй агаад тэртээх 1990-ээд оны түүхийг хүүрнэх мэт.

Сүүлийн жилүүдэд дэлхийн эдийн засгийн түүхэн хуудсыг бараан бэхээр тамгалаж ирсэн үйл явдлуудад 2008-2009 оны санхүүгийн хямралыг буруутгаж болох аж. Ийм болоод ч тэр үү, түүнээс өмнө хямрал байгаагүй мэт бодох болжээ. Гэвч 15 жилийн тэртээ рүү эргэн харваас сурч, мэдэж бас урьдчилан сэргийлэх зүйл тун олон бийг анзаарах аж.

Тухайн үед буюу 1990-ээд онд АНУ жишиг орон байв. Түүгээр ч зогсохгүй өнөөгийн адил дижитал ертөнцийн “эрэлхэг хамгаалагч” нь байсан гэх. Цахим ертөнц дэлхийд нээлттэй болсноор тус улсын талаарх сэтгэл баясгасан сайхан мэдээллүүд түгэж интернэтийн тусламжтайгаар инновацийн олон шийдэл дэлхийг донсолгож байлаа. АНУ-ын ДНБ 1999 онд жилд дөрвөн гаруй хувийн өсөлттэй гарсан нь “баян” гэх тодотголтой орнуудын дунджаас хоёр дахин их байсан юм. Ажилгүйдлийн түвшин дөрөв хүртэл хувьд унасан нь 30 жилд гараагүй нам үзүүлэлт болов. Гадаадын хөрөнгө оруулагчид АНУ руу уралдаж ам.доллар болон хувьцааны ханшийг тэнгэрт хадаасан юм. Тус улсын эдийн засаг тухайн үедээ дэлхийн хаана ч байхгүй үзүүлэлтээр урагшилж байлаа. Өдгөө энэ амжилт давтагдах нь хэмээн дэлхийн эдийн засагчид үзэж буй аж.

Тэгвэл дэлхийн томоохон эдийн засгуудын нэг Япон 1997 онд дефляци руу гулсах нь тэр. Евробүсийн хүчирхэг эдийн засаг Герман 1990-ээд онд тун хүнд “өвчилсөн” байсныг нэртэй эдийн засагчид өдгөө ярьдаг. Тухайлбал, зогсонги байдалд орсон хөдөлмөрийн зах зээл, өндөр зардал

тус улсын эдийн засгийг хямралын ангал руу түлхэх нь гэсэн хүлээлт үүсээд байсан юм. Тэгвэл хөгжиж буй гэх эдийн засгууд мөн л өнөөгийн адил уналтын голдиролд орсон түүхийг 1990-ээд оны үйл явдлууд харуулах. Тэдгээрээс дурьдвал 1997-1999 онд Тайланд, Бразил зэрэг орны үндэсний мөнгөн тэмдэгт цаас болохын хажуугаар гадаадын хөрөнгө оруулагчид тэдгээр улсаас “дайжиж”, ам.доллараар хэмжигдэх өр, зээл “Эргэн төлөгдөх боломжгүй” гэх ангилалд орсоор байлаа. АНУ ч мөн хаа сайгүй нүүрлэх эдийн засгийн хямралыг тойрч чадаагүй юм. Технологийн салбар дахь хөрөнгө оруулалт эрс буурсан нь хувьцааны ханшийг навс унагаж байсан бөгөөд дэвшилт технологийг хэрэглэгчид ч цөөрсөн байв. 2000 онд эхэлсэн эл үзэгдэл үргэлжилсээр 2001 оны эхээр

АНУ болон бусад баян орон, хүнд биш ч, уналтад орсон байлаа.

Тухайн үед дэлхийн эдийн засгийг тогтворгүйжүүлж байсан гурван хүчин зүйл 2015 онд эдийн засгийг ганхуулж мэдэх нь. Нэгдүгээрт, Америк ба бусад орон гэсэн эсрэгцэл. Энэ нь АНУ-д өсөлт “өндийж” байхад дэлхийн бусад орны эдийн засгийн өсөлт удаашрахыг хэлж буй. 1990-ээд оны сүүлээр тухайн үед АНУ-ын Сангийн дэд сайдын албыг хашиж байсан Ларри Саммерс дэлхийн эдийн загийг нисэх онгоцтой зүйрлэн “Дэлхийн эдийн засаг нэг моторын хүчээр нисэж байна” гэсэн. Тэгвэл “The Economist”-ийн шинжээчдийн таамгаар Америкийн эдийн засаг гурван хувийн өсөлт үзүүлэх бол Япон болон евробүс дөнгөж 1.1 хувийн өсөлттэй байна гэх таамгийг дэвшүүлээд байгаа аж. Хятад улсын өсөлт долоон хувьд хэлбэлзэх гэнэ. ▶



► “1990-ээд он америкчуудыг өөдрөг үзэл нь аварсан” хэмээн ярих нь бий. Шинэ зууны эхээр бий болсон олон мянган ажлын байраас гадна, газрын тосны үнэ унаж байсан нь хэрэглэгчид болон бизнесийн салбарынханд тун таатай боломж бүрдүүлсэн. Хөрөнгө оруулалт ч сэргэсэн байлаа. Харин 2015 онд байдал тийм ч таатай бус байх ажээ. Тухайлбал, газрын тосны бүтээгдэхүүний ханш унасаар буй нь Америкийн занар боловсруулагчдыг дампуурал руу түлхэх эрсдэлтэй. Түүнчлэн дэлхийн дийлэнх орны эдийн засаг удааширч байгаа үед ам.долларын ханш чангарч буй нь тус улсын экспортлогчдод халтай гэдгийг эдийн засагчид өгүүлж байгаа юм. Яг л 15 жилийн тэртээх түүх давтагдах мэт.

Их Британийн эдийн засаг ч мөн евробүсийн эдийн засгийн хямралаас үүдэн чихнээс хонх уях бололтой.

Хоёрдугаарт, дэлхийн томоохон эдийн засагтай орнуудын уналт. Германы эдийн засгийн өсөлт 1.0 хувьд эргэлдэж ирсэн. Гэхдээ тэдэнд үүнээс ч том асуудлууд бий. Эдгээр нь тун бага хөрөнгө оруулалт, асар том эрсдэл дагуулах эрчим хүчний бодлого

болон мөнгөний бодлогоо чандлан биелүүлэх, реформоос түтгэлзэх гэсэн Засгийн газрынх нь хатуу зарчим.

Япон эдийн засгийн зогсонги байдлаасаа ангижрах зорилгоор хэрэглээний татвараа нэмэгдүүлсэн нь 1997 оны санхүүгийн хямралын үед гаргасан алдаагаа давтаж байгаа хэрэг аж.

1990-ээд оны хямралын сүүдэр өнөөдөр биднийг нөмрөх нь гэх гуравдугаар параллел бол хөгжиж буй орнуудад үүсээд буй нөхцөл байдал. Тухайн үед тогтвортой валютын ханш болон их хэмжээний гадаад өр асуудал болж байсан. Харин өдгөө улс орнуудын гадаад өр харьцангуй буурсан, валютын нөөц бүрдүүлэх болсон. Гэсэн хэдий ч асуудал цэгцрээгүй хэвээр. Газрын тосны үнэ унах нь олборлогч, экспортлогч орнуудад хүнд тусаж байна. Тэр тусмаа өргөн хэрэглээний бүтээгдэхүүн экспортлогч Африкийн орнууд ханшийн хямралд хүндхэн өртөх нь. Тухайлбал, Нигер улсын экспортын 95 хувь, төсвийн орлогын 75 хувийг газрын тосны экспорт бүрдүүлдэг. Тэгвэл Гана улс хэдийнэ Олон улсын валютын санд тусламж

хүсэн хандсанаа мэдэгдсэн байна.

Дэлхийн бусад орны бизнесийн салбар хямралын горыг хамгийн ихээр амсах аж. Бразилийн олон компани ам.долларын зээлийн санхүүжилтээр үйл ажиллагаагаа эрхэлдэг. Хэдийгээр зээлийн эргэн төлөх чадвар сул байгаа ч 1990-ээд оны Азийн санхүүгийн хямралтай дүйх хохирол учруулахгүй гэж шинжээчид үзжээ. Гэвч “Сайны хажуугаар саар” гэгчээр дээрх асуудал хөрөнгө оруулагчдыг үргээхээс гадна валютын нөөц шавхагдах эрсдэлийг бий болгох юм.

Дээрх бүхнийг нэгтгээд үзвэл 2015 онд дэлхийн эдийн засаг багагүй бартааг туулах бололтой. Ам.доллар, еврогийн тогтворгүй байдал, хөгжиж буй орнуудын хямрал АНУ-ын эдийн засагт сөргөөр нөлөөлөх нь цаг хугацааных. Хөрөнгийн зах зээл дээр таагүй мэдээ цувраагүй ч хөрөнгө оруулагчид мөнгөө хайр найргүй цацахаас тагталзаж эхэлсэн. Хэрэв дэлхийн эдийн засаг бүхэлдээ хямралд автах аваас тогтвортой байдлыг эргүүлэн авч ирэхэд нь хүндрэлтэй болно. Учир нь бодлого тодорхойлогчдод жолоо атган зөв тийш зүтгүүлэх хугацаа тун бага байна. 1990-ээд онд ихэнх орны бодлогын хүү таван хувьд хэлбэлзэж байсан нь хямралын үед таналт хийж, хүүг бууруулах боломж бүрдүүлж байсан. Өнөөдөр дэлхийн баян гэгдэх орнуудын бодлогын хүү бараг тэг хувьд ойртсон байх жишээтэй.

Улс төрийн хувьд ч байдал таагүй чиглэлд өөрчлөгдсөн. 1990-ээд оны сүүл гэхэд баян орнуудын иргэд хөгжлийн шимийг харамгүй хүртэж байсан. Жишээлбэл, Америк иргэний дундаж цалин 1995-2000 онд 7.7 хувиар өссөн гэх тоо бий. Харамсалтай нь, 2007 оноос хойш дорвитой өсөлт үзэлгүй өнөөдрийг хүрчээ. Иргэд нь Засгийн газартай итгэл алдарч буйг сонгуульд оролцох иргэдийн тоо харуулах болсныг холбогдох судалгааны байгууллагууд тайлагнаж байна.

Энэ оны эдийн засаг 1990-ээд оныхтой ижил хэмнэлттэй өрнөх бол улс төрийн байдал бүр ч хүнд өрнөх нь гэсэн таамаг биелэлээ олоход ойр байгаа аж. ■





Б.БАЯРТГОГТОХ

Эдийн засгийн судалгаа, эрдэм шинжилгээний хүрээлэнгийн захирал, дэд профессор Б.Түвшинтөгстэй ярилцлаа. Эдийн засгийн хүндрэлийг хэрхэн даван туулах, цаашид ямар бодлого барьж ажиллавал үр дүнтэй талаар бидний яриа өрнөсөн юм. Түүний удирддаг байгууллага эдийн засгийн “өвчин”-ийг онилох чиглэлийн судалгаа хийдэг учир одоогийн нөхцөлд байр суурь нь жин дарна гэж үзэж байна. Эдийн засгийн судалгаа, эрдэм шинжилгээний хүрээлэн /ERI/ нь 2010 онд МУИС-ийн Эдийн засгийн сургуулийн дэргэд байгуулагдсан.

МЭРГЭЖЛИЙН ХҮНИЙ ҮГ

Б.Түвшинтөгс: Институцийг сайжруулснаар эдийн засгийн хүндрэлээс гарна

-Монголын эдийн засгийн дунд болон урт хугацааны хэтийн төлөв байдлыг та хэрхэн харж байна вэ?

-Асар их өсөх боломжтой эдийн засаг хэвээрээ шүү дээ. Тиймээс дунд болон урт хугацааны хөгжлийн эдийн засгийг өөдрөг харж байгаа. Үүний баталгаа нь газрын хэвлий дор буй байгалийн баялаг. Энэхүү эдийн засгийн боломжийг нийт хүн амынхаа амьжиргааг сайжруулахад чиглүүлэх нь л хамгийн чухал асуудал. Энэ нь Засгийн газруудын толгойны өвчин байх ёстой. Хэдий эдийн засаг хүндрэлтэй байгаа ч ерөнхий утгаар нь аваад үзэхэд дунд болон урт хугацаанд өсөлттэй байна. Ийм хүлээлт ч хүн болгонд бий. Түр зуурын хүндрэл, хямралд итгэл унах учиргүй.

-Шинэ Ерөнхий сайд Монголын эдийн засаг хямарсан гэж УИХ-ын чуулганд хэлсэн үгэндээ онцолсон. Эдийн засгийн өнөөгийн хүндрэлийг 2009 оны хямралтай адилтгаж болох уу?

-Хүндрэл, хямрал харилцан адилгүй ойлголт. Тиймээс 2009 оны нөхцөл байдалтай одоог жиших нь өрөөсгөл. Эдийн засагт үүссэн шинж тэмдгээ бид зөв олж тогтоох ёстой. Ер нь дэлхийн улсууд ажилгүйдлийн өсөлт, ДНБ-

ийхээ бууралтаар эдийн засгаа хямралаа тодорхойлсон байх нь элбэг. Манай улсын эдийн засгийн өсөлт саарсан ч одоогоор долоон хувь байна. Ийм эдийн засгийг хямралд автсан гэж хэлэх нь өрөөсгөл. Учир нь зөвхөн ДНБ-ий өсөлт буурах үзүүлэлтээр нийт эдийн засгийг дүгнэж болохгүй. Өнөөдөр эдийн засаг маш төвөгтэй байдалд байгаа нь төсвийн алдагдал, инфляцийн түвшин, ханшийн сулралт, гадаадын хөрөнгө оруулалт, гадаад худалдааны нөхцөл зэрэг үзүүлэлтүүдээс харж болно. Хэрвээ эдгээр хүндрэлүүд засал авахгүй удаан явбал хямрал болно.

-Хүндрэлд хөтөлсөн шалтгаан юу байсан юм бэ?

-Эдийн засгийн өнөөгийн тулгамдсан асуудлууд хэд хэдэн шалтгаантай. Нэгдүгээрт, өнгөрсөн хоёр жилийн хугацаанд гадаадын шууд хөрөнгө оруулалт огцом унасан. Энэ нь нэг талаас манай гол экспортын бүтээгдэхүүнүүдийн үнэ буурсантай холбоотой ч нөгөө талаас сүүлийн үеийн Засгийн газрын гадаадын хөрөнгө оруулалттай холбоотой гаргасан сөрөг шийдвэрүүд мөн нөлөөлсөн. Үүнийг ерөнхийд нь төлбөрийн тэнцлийн хүндрэл үүсчээ гэж хэлж байгаа. Хоёрдугаарт, төсвийн алдагдал нэлээд өндөр гарахаар хүлээгдэж байна. Төсвийн орлогын тасалдал асар өндөр гарахаар байгаа ▶

► нь алдагдлыг ийнхүү өндөр гаргахад хүргэж байна. Уг нь хуулийн заалтаар бол алдагдал тодорхой хязгаарт байх ёстой. Гуравдугаарт, инфляцийн түвшин зорилгот түвшнээс өндөр байгаа. Энэ нь сүүлийн хоёр жилд баримталж ирсэн мөнгөний болоод төсөв, сангийн тэлсэн бодлогоор дамжуулан нийт эрэлтийг өсгөсөнтэй холбоотой.

-Төгрөгийн ханш суларсаар байна. Үүнд мөнгөний гэлэх бодлого нөлөөлсөн үү?

-Байнга орж гарч эргэлдэж байсан гадаад валютын эргэлт татарч хомсдол үүссэн нь төгрөгийн ханшид дарамт үзүүлж байгаа. Тэр утгаараа төлбөрийн тэнцлийн хүндрэлд Монгол Улс орсон. Орох нь бага, гарах нь их байгаа тул гадаад валютын ханш улам чангарч байна. Монголбанкны валютын нөөц хязгаарлагдмал. Нөгөө талаас, мөнгөний тэлэх бодлого явагдсан нь энэхүү дарамтыг улам өсгөсөн. Ийм нөхцөлд ханш тогтвортой байна гэдэг бэрх. Үүнийгээ бид төлбөрийн тэнцлийн хүндрэл гэж нэрлээд байгаа.

-Цаашид анхаарал татах асуудал юу байна вэ?

-Үл хөдлөх хөрөнгийн зах зээл хэрхэх нь анхаарал нэлээд татах учиртай. Иргэд болон бизнесүүдийн худалдан авах чадвар, сонирхол буурч байна. Нэгэнт зах зээлд худалдан авагч цөөн учраас үнийн өсөлт саарч эхэллээ. Зарим тохиолдолд одоогийн байгаа түвшнээс үнэ нэлээн буурах хандлага ажиглагдаж байна. Мэдээж тухайн хүн, компани эдийн засаг өснө гэж тооцоод их хэмжээний хөрөнгө оруулалт хийсэн байж таарна. Гэтэл үл хөдлөх хөрөнгийн үнэ буугаад байвал хөрөнгө оруулсан хүмүүс төлбөр тооцооны хүндрэлд орно. Энэ нь санхүүгийн системдээ сөргөөр нөлөөлдөг талтай. Бусад орнуудын туршлагаас ч энэхүү зүй тогтлыг харж болно. Ер нь нийгэмд төдийгүй бизнесийн орчинд хүлээлтийн асар их зөрүү гарч байгаа нь эдийн засгийг улам эмзэг болгож байгаа том суваг юм байна гэж хэлж болохоор байна.

-Сүүлийн жилүүдэд өндөр хүлээлтэйгээр төсвөө баталдаг болсон. Дараа нь түүндээ хүрэхгүй болоод ирэхээр тодотгол хийдэг.

-Монголын Засгийн газар хэчнээн хүслээ ч өөрийн эдийн засгийн нөөц боломжоосоо илүү гарч чадахгүй. Гэхдээ төсвийг байнга тодотгоод байвал буруу жишиг тогтоно. Аль болох тодотгол хийхгүй байхаар төсвөө батлах ёстой. Харамсалтай нь сүүлийн жилүүдэд өндөр хүлээлтэйгээр төсвөө баталдаг болсон. Дараа нь түүндээ хүрэхгүй болоод ирэхээр тодотгол хийдэг зуршил бий болж байна.

-2015 оны төсөв цаг хугацааны шахалтад орсон. УИХ-ын зарим гишүүн тодотгол хийнэ гэсэн үгтэйгээр кнопоо дарцгаасан. Энэ оны төсөвт цалин, тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээг 2.5 дахин нэмэгдүүлэх боломж байна уу?

-Энэ оны төсөв буруу жишиг тогтоосон. Үүнд эдийн засгийн нөхцөл байдал гэхээс улс төрийн тогтворгүй байдал нөлөөлсөн. Манай улсад жил бүр төсөв өсөлттэй гардаг. Сүүлийн 10 жилийг эргээд харахад Монгол Улсын төсөв гурван жил тутам нугарсан байдаг. Тиймээс орлого, зарлага өсөх нь шинэ зүйл биш. Гол нь орлого төлөвлөлт хэр байхаас л төсвийн нөхцөл байдалд шууд шалтгаална. Өнөөгийн Засгийн газарт төсвийн алдагдлыг зээлээр санхүүжүүлэх орон зай хязгаарлагдмал. 2015 оны эдийн засгийн нөхцөл байдлыг өнөөдрийн өнцгөөс харахад сайнгүй харагдаж байна. Аль болох уламжлалаа

хадгалсан төсөв байх хэрэгтэй. Энэ нь амьдралд ойрхон гэсэн үг. Өндөр хүлээлттэй, амьдралаас хол баталвал дахиад л тодотгол хийх болно.

-Хуулийн засаглал сул, түүнийг хэрэгжүүлэх идэвх зүтгэл тааруу байснаас эдийн засгийн хүндрэл нь үүссэн гэж зарим хүмүүс ярьж байна. Энэ тухайд?

-Хуулийн засаглал гэхээсээ илүүтэй институцын чанар гэж бид их ярьдаг. Үүнд хуулиа мөрдөхийн зэргэцээ хуулийн үзэл баримтлалдаа үнэнч байх асуудлууд багтдаг. Ер нь бодлогын тууштай байдал алдагдаж байгааг бид анхаарах ёстой. УИХ, Засгийн газар өөрсдөө баталсан хуулиа үгүйсгэх, түүнийхээ хэм хэмжээнд төсвөө баталж, сахилга батаа сайжруулаагүй. Бид институцын чанараа сайжруулж чадахгүй бол эдийн засгийн хүндрэл, хямралаас өөрсдийгөө хамгаалж чадахгүй. Үүнийг өнөөгийн эдийн засгийн хүндрэл нотолж байна. Бид 2008-2009 онд сургамж авсан гэж бодсон ч 2014 онд буцаад хуучин байран дээрээ ирсэн. Эдийн засаг хүндрэхгүй, дахиж хямрахгүй юм шиг бүгдээрээ бодож, хүлээж бодлого явуулж ирсэн нь өнөөгийн байдалд хүргэсэн гэсэн үг.

-Эдийн засгийн өнөөгийн хүндрэлээс гарахад төсөв, мөнгөний бодлогын үзүүлэх нөлөө хэр байх бол?

-Төсөв, мөнгөний

бодлого сүүлийн жилүүдэд харилцан адилгүй тэлж ирсэн. Эдийн засаг хүндрэлд ороход тэлэх бодлогоор хямралыг давах ёстой. Харамсалтай нь одоогийн нөхцөлд ийм боломж хомс. Эдийн засгийг тодорхойлох хоёр бодлогын хувьд орон зай хязгаарлагдмал байна. Мөнгөний бодлогын хүрээнд инфляци зорилгот түвшнээс өндөр байгаагаас мөнгөний нийлүүлэлтийг илүү

өсгөх боломж багатай. Нөгөө талаас төсвийн бодлогоо аваад үзэхэд улсын өрийн хэмжээ ДНБ-тэй харьцуулахад хуулийн хязгаараасаа давсан. Тэр утгаараа төсөв тэлэх боломжгүй. Төсөв, сангийн бодлогоор дамжиж эдийн засгийн удаашралаас гарах бололцоо хязгаарлагдмал байна.

-Бодлогын нөлөөлөл эдийн засгийн хүндрэлийг давахад хүчтэй нөлөө үзүүлэхгүй гэсэн үг үү?

-Аль аль бодлого дээрээ аваад үзсэн ч эдийн засгийн хүндрэлтэй тулахад түүнийг сөрөх зэр зэвсэг муутай байна. Бидний үргэлж ярьдаг байсан макро эдийн засгийн тогтвортой байдал, Төсвийн тогтвортой байдлын тухай хуулиа тууштай баримтлах байдал эргээд бидэнд асуулга тавьж байна. Хуулийнхаа үзэл баримтлалыг ягштал мөрдсөн бол өнөөдрийн түвшнээс хамаагүй дээр байх байсан гэдгийг үйл явдал тодхон харууллаа.

-Эдийн засагт үүссэн хямралын эсрэг шинэ Засгийн газар ямар бодлого хэрэгжүүлбэл оновчтой байх вэ?

-Эргээд хүндрэл бий болгож буй гурван сувгаа харах хэрэгтэй. Энэ сувгуудаар орж ирж буй хүндрэлийг хаах эсвэл эргүүлэх боломжийг эрэлхийлэх. Нүүрс, зэс, алт гээд манай гол экспортын бүтээгдэхүүнүүдийн үнэ дэлхийн зах зээлийн үнээр тодорхойлогдож байгаа учраас ►

“ Бид институцийн чанараа сайжруулж чадахгүй бол эдийн засгийн хүндрэл, хямралаас өөрсдийгөө хамгаалж чадахгүй. Үүнийг өнөөгийн эдийн засгийн хүндрэл нотолж байна. ”

▸ үүний эсрэг юу ч хийж чадахгүй. Уул уурхайгаас ойрын хугацаанд хараат байгаа нь түүхий эдийн үнийн хэлбэлзэлд өртөмтгий болгосон.

Харин, хийж чадах зүйл гэвэл гадаадын хөрөнгө оруулалтын урсгалыг сайжруулах замаар төлбөрийн тэнцлийн хүндрэлээс ангижирах явдал. Ер нь Засгийн газар өөрчлөгдөх үед бодлого дагаад эргэдэг. Гэтэл бодлогын залгамж чанар хадгалагдах ёстой гэсэн зарчим давхар үйлчилж байх ёстой. Уул уурхайд түшиглэсэн эдийн засагтай орнуудын хамгийн зөв туршлагыг Төсвийн тогтвортой байдлын тухай хуулиар гаргаж ирсэн. Энэ нь өсөж байгаа үед нь хадгалаад, унах үед нь хадгаламжаасаа зарцуулах тэр боломжийг олгох юм. Харамсалтай нь гаргаж ирсэн ганц арга хэрэгслээ хэрэгжүүлэхгүй, тууштай авч явж чадахгүй байгаа нь өнөөгийн хүндрэлийг үүсгэсэн. Ороод ирсэн гадаадын хөрөнгө оруулалттай төслүүдэд үүссэн хүндрэлийг

нэн даруй шийдвэл тустай. Үүнийг ч эдийн засгийн өнөөгийн байдал шаардаж байна. Гэхдээ арга хэмжээ авлаа ч шинэ хөрөнгө оруулалтыг татаж чадахгүй байх вий гэсэн айдас бий. Шинэ бодлого, шинэ ёс зүй, шинэ уур амьсгал оруулж ирэх ёстой.

-Төвбанкны гол зорилго нь валютын ханш уу, инфляци уу?

-Төвбанкны гол зорилго бол инфляци. Ер нь эдийн засгийн хүндрэлтэй үед мөнгөний хатуу бодлого явуулбал харамсалтай. Учир

нь банкны системээс зээл болоод гарах ёстой байсан нөөцийг Төвбанк өөр дээрээ татан төвлөрүүлнэ гэсэн үг шүү дээ. Гэтэл инфляци зорилтот түвшнээс өндөр байгаа тул хатууруулах бодлого нөгөө талаас шаардана. Эдийн засаг хэт халалттай байгаа учраас мөнгийг нь татаж тэр халууныг нь дарах ёстой. Тийм учраас мөнгөний бодлогын хувьд одоо салаа замын уулзвар дээр ирээд байна. Бидний хувьд чангаруулах уу эсвэл хэвээр үлдээх үү гэсэн сонголттой тулгараад байгаа.

-Иргэдийн дунд харилцан адилгүй ойлголт байдаг.

-Ер нь Монголбанк ганцхан мандаттай байх ёстой гэж боддог. Тэр нь инфляци. Олон нийт валютын ханшийг онилох, удирдах нь зүйтэй гэх нь элбэг сонсогддог. Валютын ханш нь Төв банкаар биш зах зээлийн зарчмаар тодорхойлогдох учиртай. Өөрөөр хэлбэл, гадаад худалдааны тэнцэл, эдийн засгийн өсөлт, валютын урсгал, валютуудын өгөөж, эрсдэл зэрэг эдийн засгийн суурь үзүүлэлтүүд ханшийг тодорхойлдог. Ганцхан тохиолдолд буюу Монголбанк гадаад валютын асар их нөөцтэй үед л ханшийг удирдах боломжтой. Ер нь Монгол Улс ханшаа удирдах хэмжээний нөөцтэй байсан тохиолдол үгүй. Тиймээс Монголбанкны мандат бол инфляци. Монголбанк инфляци хангалттай нам түвшинд орсон гэж үзвэл дараагийн асуудал нь эдийн засгийн идэвхжлийг сайжруулах, өсөлтийг бий болгох, олон тулгуур суурьтай болгох талдаа байж болно. Энэ

талаас нь аваад үзвэл мөнгөний бодлого дээр ярьсан салаа зам дээр ирээд байгаа гэж бодож байна.

-Эдийн засгийг төрөлжүүлэх талаар байнга ярьдаг. Харамсалтай нь эдийн засаг ганц хөлтэй буюу уул уурхайгаас хамаарсан хэвээр байна.

-Нөхцөл байдал одоогийнхоос илүү сайн байхад ч төрөлжүүлэх тухай ярьж байсан. Ер нь эдийн засагт байнгын сэдэв болсон. Төрөлжүүлэх нь өнөөдөр импортыг орлох болж хувирсан. Импортыг орлуулах санаа 60, 70-аад онуудад их хүчтэй явж байсан ч амжилт олсон нь маш цөөхөн. Гэтэл сүүлийн үед өндөр хөгжсөн орнуудын туршлагаас харахад импортыг орлох гэхээсээ экспортыг дэмжих нь илүү өндөр үр ашигтай, тогтвортой гэж үздэг. Энэ нь ч онолын үндэслэлтэй.

-Эдийн засгийн өсөлт иргэдийн амьдрал наалдацгүй байгааг олон нийтийн зүгээс шүүмжлэх болсон.

-Монголын нийт баялагийн гуравны хоёр нь 35 хүнд төвлөрсөн талаар өгүүлсэн илтгэл саяхан гарсан байсан. Энэ нь орлогын тэгш бус хуваарилалт, өсөлт өгөөжгүй байгааг харуулж байгаа. Дээрх тоо нь шинжлэх ухааны аргаар гаргасан тоо биш ч нөхцөл байдал ямар түвшинд хүрээд байгааг нэг талаар илтгэн харуулж байна. Ер нь өндөр хөгжсөн орнуудад ч мөн адил хөгжлийн эхэн үед орлогын тэгш бус хуваарилалт байдаг. Тэдний хүн амынхаа амьжиргааны түвшинг хэрхэн сайжруулж чадсан түүх л өнөөдөр бидэнд илүү сонирхолтой.


-Ашигтай төслүүдийг хэн гаргаж ирэх вэ?

-Хувийн хэвшил. Үүнийг бид хүлээн зөвшөөрөх ёстой. Хувийн ашиг сонирхол, ашгийн төлөөх эрэлхийлэл нь бидний хүсээд буй ашигтай салбаруудыг гаргаж ирдэг. Төрийн үүрэг гэвэл хувийн хэвшлийн эрэлхийллийг аль болох зардал багатай байлгах учиртай. Тухайлбал, хүнд суртлыг багасгах, авлигыг халах, дэд бүтцээр хангаж өгөх хэрэгтэй. Институцийн чанарыг сайжруулах, лиценз, зөвшөөрөл, гэрчилгээ ойлгомжтой, цэгцтэй байх нь чухал. Ийм таатай орчинг бүрдүүлсэнээр дараагийн асуудлыг ярих хэрэгтэй. Манайхан их туйлшрамтгай. Үүндээ ч хэт автдаг. Тиймээс өрсөлдөх чадвар, зах зээлийн нөөц боломжоо сайн тооцоолж үзэх ёстой.

-Монголд Хятадын "Bank of China" салбараа нээх тухай асуудлыг та хэрхэн хүлээн авсан бэ?

-Гаднын том банк салбараа нээх асуудлыг манайхан эмзэг хүлээж авах шиг болсон. Заавал Монгол эзэнтэй, Монголын банк байх нь хуучирсан ойлголт төдийгүй туйлширсан хэрэг. Манай дотоодын санхүүгийн эх үүсвэр хязгаарлагдмал. Нэг төслийг санхүүжүүлэх хэмжээ тухайн банкны өөрийн хөрөнгийн 20 хувиар хязгаарлагддаг. Томоохон төслүүдийг санхүүжүүлж чадахгүй байгаа нэг шалтгаан нь арилжааны банкны цар хүрээ хязгаарлагдмал байгаа явдал. Гаднын банкны салбар орж ирлээ гэхэд тэр хязгаарлалт суларч, хүрээ нь тэлнэ. Одоогийн босгож байгаа хөрөнгөнөөс илүү бага зардалтай санхүүгийн эх үүсвэр орж ирэх боломжтой. Тэр утгаараа огт болохгүй зүйл гэж үзэж болохгүй. Нөгөө талдаа эдийн засаг дахь гадаадын банкны оролцоо, цар хүрээг нь хязгаарлах зохицуулалт дүрэм, журмынхаа хүрээнд хийж болно. Тиймээс огт болохгүй гэсэн хатуу байр суурь надад байхгүй. ■

“ Валютын ханш нь Төв банкаар биш зах зээлийн зарчмаар тодорхойлогдох учиртай. Өөрөөр хэлбэл, гадаад худалдааны тэнцэл, эдийн засгийн өсөлт, валютын урсгал, валютуудын өгөөж, эрсдэл зэрэг эдийн засгийн суурь үзүүлэлтүүд ханшийг тодорхойлдог. ”



Шнайдер Электрик компани 2014 оны Платц Олон улсын Эрчим хүчний Шагнал \Platts Global Energy Awards\ хүртлээ

Эрчим хүчний хэрэглээг 13 хүртэл хувиар, нүүрстөрөгчийн ялгаралыг 16 хувиар бууруулах Эрчим хүчний үр ашигтай хэрэглээнд чиглэсэн хөтөлбөр (Energy Action Program)

Эрчим хүчний зохицуулалтын чиглэлээр дэлхийд тэргүүлэгч Шнайдер Электрик компанид 2014 оны Платц Олон улсын эрчим хүчний шагнал гардуулах ёслолын ажиллагааны үеэр эрчим хүчний хэрэглээг зохицуулах, хэмнэх чиглэлээр хичээл зүтгэл гарган ажиллаж байгааг нь үнэлж Шилдэг манлайлагчийн (Stewardship Award) шагнал гардууллаа.

Шнайдер Электрик компанийн Маркетингийн ахлах ажилтан Крис Хаммел хэлсэн үгэндээ: "Эрчим хүчний үр ашигтай хэрэглээ гэдэг бол бидний нэн чухал зорилт бөгөөд ДНК мөн тул энэ талаар олон хөтөлбөр хэрэгжүүлснийг ийнхүү сайшаан урамшуулж байгаад бид баяртай байна. Бид цаашид дэлхийн олон орны компани, хувь хүмүүст хэрэглэж байгаа эрчим хүчээ үнэлж гамнан, нүүрстөрөгчийн ялгаралыг бууруулахад нь туслах болно. Платцийн олгосон энэхүү хүндтэй шагнал нь бидний өнөөдөр хүрсэн ололт амжилт болон тэргүүн туршлагыг нэвтрүүлэх хичээл зүтгэлийг маань онцгойлон үнэлсэн явдал юм." хэмээн онцоллоо.

Шнайдер Электрик нь Эрчим хүчний үр ашигт чиглэсэн (Energy Action Program) хөтөлбөр хэрэгжүүлж улмаар үр дүнд хүрсэн тул "Арилжааны эцсийн хэрэглэгчдэд чиглэсэн эрчим хүчний хэмнэлтийн талаарх санаачлага" гэсэн төрлөөр Шилдэг манлайлагчийн шагнал хүртсэн юм. Уг шагналыг стратегийн алсын хараа, аж үйлдвэрийн манлайлал, хариуцлагатай удирдлага, шинэлэг технологи зэрэг чиглэлээр томоохон ахиц гаргасан байгууллагад олгодог.

Шнайдер Электрик нь 2011 онд Эрчим хүчний үр ашигт чиглэсэн хөтөлбөр хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд хуримтлуулсан тэргүүн туршлагадаа үндэслэн, салбар байгууллагуудаараа дамжуулан эрчим хүчний хэмнэлтийн шинэ арга техник боловсруулж, шинэлэг, тогтвортой, шилдэг үйл ажиллагаа хэрэгжүүлэхэд голлон анхаарсан юм. Шнайдер Электрик компани нь 2014 оны 3-р улирлын эцэс гэхэд эрчим хүчний үндсэн хэрэглээг 13 хүртэл хувиар, тээврийн хэрэгслээс үүдэлтэй нүүрстөрөгчийн ялгаралыг 16-с илүү хувиар бууруулж, хөтөлбөрийнхөө зорилтыг давуулан биелүүлсэн байна. Мөн энэ үед тус компанийн экологийн тэнцвэртэй байдлыг дэмжихэд чиглэсэн Green Premium бүтээгдэхүүнээс орсон орлого компанийн нийт үйл ажиллагааны ашиг орлогын 70-с илүү хувийг бүрдүүлж чаджээ. Энэ нь тус хөтөлбөрийн бас нэг гол зорилт байлаа.

Платц Олон улсын эрчим хүчний шагналын хорооноос сүүлийн 15 жилийн хугацаанд эрчим хүчний аж үйлдвэрийн салбарт гарсан шилдэг манлайлал, шинэлэг арга барил, үйл ажиллагаа зэргийг шалгаруулж шагнадаг уламжлал тогтсон юм. Уг шагналд жил бүр 25 гаруй орноос 200 гаруй нэр дэвшигчийг санал болгодог аж. Тэдгээрийг шинжлэх ухааны тэргүүлэх эрдэмтэд, хууль тогтоогчид, эрчим хүчний сайд нар, аж үйлдвэрийн салбарын тэргүүлэх мэргэжилтнүүдээс бүрдсэн сонгон шалгаруулах шүүгчдийн бүрэлдэхүүн хянаж шилдэгийг нь тодруулдаг юм. Платц Олон улсын эрчим хүчний шагнал гардуулах хүндэтгэлийн ёслолын ажиллагаа жил бүр зохиогддог бөгөөд энэ жилийн арга хэмжээ 12 дугаар сарын 11-нд Нью-Йорк хотноо зохиогдсон байна.

Шнайдер Электрикийн тухай

Дэлхийн зуу гаруй оронд үйл ажиллагаа явуулдаг, эрчим хүч зохицуулалтын чиглэлээр дэлхийн хэмжээний мэргэжлийн компани болох Шнайдер Электрик нь эрчим хүч, дэд бүтэц, үйлдвэрлэлийн процесс, барилгын автоматжуулалт, Дата төв зэрэг олон салбарыг хамарсан цогц шийдлийг санал болгодог тэргүүлэгч байгууллагуудын нэг байхын зэрэгцээ орон сууц, ахуйн хэрэглээний салбарт мөн адил томоохон байр суурь эзэлдэг юм. Эрчим хүчийг аюулгүй, найдвартай, хэмнэлттэй, үр ашигтай байлгах асуудал дээр төвлөрч ажилладаг 150,000 гаруй ажилтаны хөдөлмөрийн үр дүнд 2013 онд компанийн борлуулалт 24 тэрбум гаруй еврод хүрч, хувь хүмүүс, байгууллагуудад эрчим хүчээ хамгийн үр ашигтайгаар зарцуулахад нь тусалцаа үзүүлэхэд бүхий л хүчээ дайчлан ажиллаж байна. www.schneider-electric.mn

Платц компанийн тухай

Тус компани нь 1909 онд байгуулагдсан бөгөөд эрчим хүч, нефть химийн бүтээгдэхүүн, метал нийлүүлэх, хөдөө аж ахуйн мэдээлэл, бодит болон хэтийн зах зээлийн харьцуулсан үнэ өртгийн судалгаа гаргах чиглэлээр дэлхийд тэргүүлдэг. Платц компанийн гаргасан мэдээлэл, үнэ, дүн шинжилгээ, тайлбар болон зохион байгуулдаг бага хурал зэрэг нь хэрэглэгчдэд мэдээлэл сайтай арилжаа хийх, бизнесийн шийдвэр гаргах зэрэгт нь тусалдаг бөгөөд түүнчлэн зах зээлийн үйл ажиллагааг ихээхэн ил тод, үр ашигтай байлгахад хувь нэмэр оруулдаг билээ. Платц компанийн боловсруулан гаргадаг био түлш, нүүрстөрөгчийн ялгарал, нүүрс, цахилгаан, газрын тос, байгалийн хий, метал, цөмийн эрчим хүч, нефть химийн бүтээгдэхүүн, усан тээвэр, элсэн чихрийн зах зээлийн талаарх мэдээллийг дэлхийн 150 гаруй орны хэрэглэгчид ашигладаг ажээ. Платц компанийн МкГрау Хилл (NYSE: MHFI) санхүүгийн хэлтэс нь Лондон хотод байрладаг бөгөөд дэлхийн хэмжээнд 15 салбартай, 1000 гаруй ажилтантай юм. Дэлгэрэнгүй мэдээллийг <http://www.platts.com> цахим хуудсанд зочилон үзээрэй.

ҮЛ ХӨДЛӨХ

Эдийн засгийн тулгуур зах зээл

С.БАТЗАЯА

Улаанбаатарт 200 орчим мянган өрх гэр хороололд амьдарч байхад орон сууц олноор баригдаж байвал л хэрэгтэй гэж үзэх хүн олон. Тэгвэл ямар ч төлөвлөлтгүй, зах замбараагүй олон байшин барилга нь үл хөдлөх хөрөнгийн салбараа унагах эрсдэлтэй аж.

Ганц энэ салбар гэлтгүй бусад чиглэл ч 2013 оноос уналтын байдалд орж эхэлсэн. Статистикаас харахад өнгөрсөн хоёр жилд барилгын салбар хамгийн өндөр өсөлттэй гарч байсан. Гэвч улс төрийн шийдэл тус салбарт орсон учраас өсөлттэй мэт хиймэл харагдаж байжээ. 2011, 2012 онд эдийн засгийн өндөр өсөлттэй байхад энэ зах зээлд нийлүүлэлт хомс байснаас хөөсрөлт явжээ. Барилгын салбар шинэ тутам хөгжиж байсан учир тухайн үед дотоодын томоохон компаниуд хуримтлагдсан үр ашгаа оруулах талбар байхгүй байснаас гэнэт үүссэн эрэлт, хэрэгцээ болох орон сууцны зах зээл рүү нэгэн зэрэг хөрөнгө оруулжээ. Үүнээс болж хэт хиймэл орчин бий болсон аж.

Барилга, хотбайгуулалтын шинэхэн сайд Д.Цогтбаатар “Зах зээлгүй бол барилгын салбар зүгээр хөрөнгийн түгжээс шүү дээ. Барилга, үл хөдлөх хөрөнгийн бизнес хоёр тус тусдаа маш их хөрөнгө шаардсан бизнес. Ийм их хөрөнгө, зардлыг барилгын компаниуд даахгүй. Тэгэхээр нэг л салбартаа буюу барилгадаа түлхүү анхаараад үл хөдлөх хөрөнгийн салбартаа дутуу анхаардаг юм байна. Аливаа нэг үл хөдлөх хөрөнгийн насжилтыг 100 жил гэж үзвэл барилга барих буюу барилгын бизнесийн хугацаа хоёрхон жил. Тэгэхээр барилгын бизнес үл хөдлөх хөрөнгийн нийт орших хугацааны хоёрхон хувийг эзэлж байгаа юм. Барилгаас олох нийт орлогын багахан хувьтай л түүнийг барих зардал тэнцдэг юм билээ. Гэтэл манай тогтолцооны бүхий л жин барилга талдаа төвлөрсөн байдаг. Тиймээс үл хөдлөх хөрөнгийн бизнесүүд гүйцэд торниж амжаагүй байна. Энэ гажуудал

нь үл хөдлөх хөрөнгийн зах зээлийг эрсдэлтэй болгож байгаа юм. Иймд энэ салбарын хөгжилд илүү анхаарал тавина” хэмээжээ.

Эдийн засгийн өсөлт 17 хувьтай байхад үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн өсөлт 28 хувьд хүрчээ. Зах зээлийг дагаад үнийн хөөрөгдөл үүссэн учир компаниудад үр ашгийн зөрүү өндөр гарахаар байжээ. Гэхдээ жижиг эдийн засагтай манайд богино хугацаанд үр ашиг авах бололцоо тааруугаас дээрх орон зайг амжиж ашигласан эхний 1-2 төсөл л ашигтай ажилласан байна. Бусад нь хөрөнгө оруулалтаа нөхөж чадахгүй байдалтай байгаа аж. Энэ талаар Монголын үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн судалгаа болон зөвлөх үйлчилгээ үзүүлдэг M.A.D компанийн гүйцэтгэх захирал Ц.Уянга “Эрэлт өндөртэй байснаас тухайн үеийн статистик тоо, баримтууд өндөр гарч байв. Ядаж богино хугацаанд зах зээл яаж “авирлах”-ыг тооцоололгүйгээр урагшаа явсан. Энэ үзэгдлээс урьдчилан сэргийлэхийн тулд манайх тайлан гаргаж байв. Гэвч дотоодын барилга, үл хөдлөхийн салбарын хөрөнгө оруулалт дээр тоглож буй компаниуд тухайн үзэгдэлд нэлээд яарч, богино хугацаанд ашиг олох гэж явсан учраас зах зээлийг ийм болгосон. Үүний үр дүнг ганц өөрөө ч бус салбараараа эдлээд явж байна” гэв.

Сонгуульд тулгуурласан моргейжийн зээл

Манайх шиг дэд бүтэц муутай газар дулаан, цахилгаан, ус хангамжийн алдагдлыг энэ зах зээлд оролцож буй иргэд үүрдэг байна. 2013 оноос олон улсад уул уурхайн бүтээгдэхүүний үнэ унасан нь манайд нөлөөлж эхэлсэн. Гэхдээ үүнээс илүүтэйгээр зах зээлийн голдрилоор бус ихэнхдээ улс төрийн шийдвэрээр эдийн засаг явдаг аж. Өөрөөр хэлбэл, төрөөс гаргаж буй шийдвэрийн хүрээнд сонгуульд тулгуурласан эдийн засгийн хөтөлбөр хэрэгжиж эхэлдэг учраас хиймэл орчин бүрддэг байна. Үүний нэг нь жилийн

найман хувийн хүүтэй моргейжийн зээл аж. Энэ талаар Ц.Уянга “Ийм зээлийг гаргах нь буруу биш. Эхлээд санхүүгийн зах зээлдээ томоохон шинэчлэл хийх ёстой байсан. Энэ зөвхөн үл хөдлөх хөрөнгө, барилгын салбарын асуудал биш юм. Ипотекийг хэрэгжүүлэхийн өмнө санхүүгийн зах зээлийн дархлаагаа бүрдүүлсэн байх ёстой. Манай банкны салбар, жижиг болон мега төслүүдийг эс тооцвол бизнесийн орчин муу байна. Тиймээс тооцоо, судалгаа муутай төсөл хэрэгжүүлэх нь нийт эдийн засгаа татаж унагах аюултай” хэмээв.

Зах зээлийн зарчмаар явж буй үл хөдлөх салбарын хөгжлийг нураан байж ипотекийн зээл оруулж ирэх ёсгүй байжээ. Ингэхдээ банкны салбарыг татаж унагаах эрсдэлийг арилжааны банкуудад үүрүүлж. Мөн ипотекийн зээлийг иргэдийн амьдралын түвшин нэмэгдэх орчин нөхцөл үүсээгүй үед хийж болдоггүй аж. Эдгээрийг бүрдүүлэхийн тулд хамгийн богино хугацаанд буюу 5-8 жилийн хөрс суурийг бэлдэх ёстой юм байна. Гэтэл манайх сонгуулийн мөчлөгөөр явдаг тогтолцоотой учир ийм хөрс суурь бэхжээгүй байхад оруулж ирсэн гэсэн үг.

Улсын хэмжээнд сүүлийн гурван жилийн дотор 40 мянган орон сууц ашиглалтад орсны 20 орчим мянга нь өнгөрсөн онд баригджээ. Орон сууцны жилийн найман хувийн хүүтэй зээл анх Сү.Батболдын Засгийн газрын үед хэрэгжиж эхэлсэн. Үүнээс хойш жил ирэх тусам банкуудын олгох зээлийн хэмжээ буурсаар ирснийг “Юу Эм Си альфа” компанийн гүйцэтгэх захирал Н.Монсор “Орон сууцны зах зээл-2015” илтгэлдээ хэлсэн. Иргэдийн орлогынх нь эх үүсвэр тогтвортой байх нөхцөл хангагдаагүй байхад уг зээл олгогддогдоос зорилтог зах зээлдээ очиж чадахгүй, дийлэнхдээ байртай, боломжийн амьдралтай иргэдэд хүрээд эхэлжээ. Эрэлтийг дагаад нийлүүлэлт бий болдог. Гэхдээ нийлүүлэлтийг хиймэлээр хийж болдоггүйг үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн судалгаа хийдэг M.A.D компанийнхан хэлж ▶

▶ байна. Энэ нь валютын ханшийг өсгөж, эдийн засгаа унагах эрсдэл дагуулдаг аж. Тэд “Манайх банкны салбараа сайн дэмжих ёстой. Орон сууцны нийлүүлэлтийг яаралтай зогсоох хэрэгтэй. Тэгж байж зах зээлд хуримтлагдаад буй бүтээгдэхүүнийг эргэлтэд оруулж, банкны салбар унахаас сэргийлнэ” гэв.

Найман хувийн зээлийн хөтөлбөрийг цаашид үргэлжлүүлэхээ Засгийн газар мэдэгдсэн. Энэ зөвхөн барилгын салбарыг дэмжиж буй арга хэрэгсэл аж. Банкны салбар бат бэх оршоогүй цагт үл хөдлөхийн салбар үйл ажиллагаагаа хэвийн явуулна гэж байдаггүй гэнэ.

Дэд бүтцийг шийдэж чадахгүйгээс

Манайх дэд бүтцийн хүчин чадлаа тооцохгүйгээр энэ салбарыг хөгжүүлэх нь мянгуужингийн үлгэр гэнэ. Ходоодныхоо хэмжээнд тааруулж хооллохгүй байгаатай адил ойлголт аж. Мөн барилгын түүхий эд үйлдвэрлэх зах зээлгүйн дээр тус салбарт ажиллах мэргэжлийн хөдөлмөрлөх хүч хомс байна. Дэд бүтцийн хүртээмж, хотын иж бүрэн төлөвлөлт алга буй учраас ам.доллараар авсан зээлийг төгрөгөөр тараахаар валютын хомсдол үүсч буй аж. Үл хөдлөх хөрөнгө гэхээр манайхан зуучлалын бизнес хийдэг компаниудын түвшинд хардаг байна. Гэтэл одоо зах зээл дээр борлуулалт худалдаа алга. Хотын төвийн барилгууд борлуулалтгүйгээс царцалт үүсч эхэлжээ. Маш өндөр өртгөөр баригдсан учир өртгөө нөхөж чадахгүйн дээр урсгал болон арчилгааны зардлаа нөхөхийн тулд гарч байгаа зардлаасаа бага үнээр түрээслэх боломжгүй байгаа аж.

Гэтэл манайх барилга бариад байхаас үл хөдлөх хөрөнгийн зах зээлийг яах вэ гэдгээ огт төлөвлөхгүй байна гэдгийг Ц.Уянга хэлсэн. Цаашид барилга барихаа зогсоохгүй бол дэд бүтэц ч хүрэлцэхгүй болно. Томоохон оффисын барилгууд насос ажиллуулан өртөг өндөртэйгээр ажиллуулж болох ч орон сууцны барилгыг ийм үнэтэй дулаанаар хангах боломжгүй юм. Мөн хот төлөвлөлтийг бодитойгоор хийж, түрээсийн зах зээл бий болгох хэрэгтэй байгаа аж. Тухайн хүн гэр бүл зохиогоод 5-10 жил болоход 1-2 хүүхэдтэй болж, тогтвортой, тогтворгүй гэр бүл байх уу гэдэг нь шийдэгдсэн байна. Ийм үед

моргейжийн зах зээлийг бий болгох ёстой гэнэ.

Энэ салбарт гадаадын хөрөнгө оруулалт маш бага. Эдийн засаг сайн байхад бүх салбарын хөрөнгө оруулагчид Монголыг сонирхож байсан ч үйлдвэрлэл хөгжөөгүй, дэд бүтэц тааруу эрсдэлтэй зах зээл рүү хөрөнгө оруулагч мөнгө хаяхгүйгээр үл хөдлөх хөрөнгийн салбар руу түрүүчээсээ орсон байна. Тэд дэлхийд алдартай зочид буудлуудын сүлжээ оруулж ирэхээр судалгаа хийжээ. Гэтэл манай нисэхийн эргэлтийн хүчин чадал, жилд ирдэг жуулчдын тоо, дотоод зах зээлийн багтаамж зэргийг судалж үзээд салбараа нээх боломжгүй гэдгийг эхнээсээ мэдэж, буцсан байна. Манайх жилд 86 мянган зорчигч хүлээж авдаг. Түүнээс таван одтой зочид буудлаар үйлчлүүлэх нь хэд байх вэ гэх тооцоог гаргаад эргэлтийн хөрөнгөө бодоод үр ашиггүй гэдгийг судлаад татгалзсан хэрэг. Харин түрүүлж орж ирсэн нь зочид буудалд оруулсан хөрөнгөө гаргаж авахаар толгойгоо гашилгаж байгаа гэх. Салбарын сайд Д.Цогтбаатар “Үл хөдлөх хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэхэд гадаадын хөрөнгө оруулалт татах нь чухал. Тиймээс хөрөнгө татах бодлого баримталж ажиллана. Дубай, Лондон, Хонконг зэрэг хотын хөгжилд гадны хөрөнгө оруулалт маш их тустай байдаг. Иргэд нь ч ийм хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмждэг. Манайхан ч тийм байдлаар салбартаа хандана гэж найдаж байгаа” гэв.

Тодруулбал, барилгын салбар дахь дотоодын хөрөнгө оруулалт 2013-2014 онд 2.3 дахин нэмэгдэж, банкин дахь барилгын салбарын зээлийн өрийн үлдэгдэл 60 орчим хувиар өсчээ. Харин гадаадын хөрөнгө оруулалт буурсан байна. Үүнд хөрөнгө оруулалтын орчин чухал нөлөөтэй байсныг үл хөдлөхийн “UMC Alpha” компанийн захирал Н.Монсор захирал хэлсэн.

Үл хөдлөх салбарын хууль эрх зүйн орчин маш сул байгаагийн дээр татварын орчин ойлгомжгүй аж. Орон сууцны болоод оффисын барилгууд татвар төлдөггүй. Бүгдэд нь татвар тогтоогоод эхэлбэл хүмүүс түрээсийн зах зээл рүү илүү байраа гаргана. Эндээс олох орлогоос шугам сүлжээгээ засаад явж болох. Одоо манайх борлуулж байгаа болон худалдан авч буй хоёрт л татвар ногдуулаад байдаг. Худалдаж байгаа арилжааг хөнгөлж өгөх ёстой. Ингэж байж арилжаа ил тод болох юм. ■



МЕГА ТӨСӨЛ

Тавантолгой амь оров

Б.БАЯРТГОТХ

Тавантолгойн орд дэлхий нийтийн анхаарлын төвд дахин орж, хэлэлцээрийн ширээнд шилжлээ. 7.4 тэрбум тонн нүүрсний нөөцтэй тус ордын стратегийн хөрөнгө оруулагчийг шинэ оны босгон дээр буюу 2014 оны арванхоёрдугаар сарын 25-нд албан ёсоор олон нийтэд зарлалаа. Дэлхийн коксжих нүүрсний томоохон сав нутагт байрлах Тавантолгойн стратегийн хөрөнгө оруулагчаар гурван улсын хамтарсан консорциум шалгарч, хөрөнгө оруулалтын орчинд нааштай уур амьсгал бий болголоо.

Өмнөговь аймгийн Цогтцэций сумын Улаан нуурын хөндийд орших Тавантолгойн орд нь эдийн засгийг идэвхжүүлэх мега төслүүдийн нэг. Дэлхийн жишигт нэг тэрбум ам.доллар болон түүнээс дээш хэмжээний өртөгтэй, эдийн засгийн томоохон ач холбогдолтой төслүүдийг “Мега” хэмээн нэрлэдэг. Тиймээс Тавантолгойг эдийн засгийн эргэлтэд оруулах нь хөгжлийн захиалга төдийгүй цаг үеийн шаардлага. Нүүрсний зах зээлийн үнэ одоогийнхоос харьцангуй өндөр, тогтвортой байх үед буюу 2011 онд уг тендер анх зарлагдах үед таван тивийн нийт 16 компани уралдаант шалгаруулгад материалаа ирүүлж байсан ч стратегийн хөрөнгө оруулагчийн төлөөх өрсөлдөөнд хэн ч ялж, хэнийг ч ялуулж чадаагүй. Тэдний дунд БНСУ-ын “Корес” группээр ахлуулсан компаниудын нэгдэл, Австралийн “Xstrata coal”, Бразилийн “Vale”, Люксембургийн “ArcelorMittal”, Хятадын “Shenhua Energy”, АНУ-ын “Peabody Energy” тунаж үлдээд байсан ч ялагч тодроогүй дөрвөн жилийг өнгөрөөсөн. Харин нүүрсний үнэ огцом унасан, зах зээлийн эрэлт багассан, төгрөгийн ханш 25 хувиар суларсан, нүүрс сонин биш болсон энэ үед Тавантолгойн орд хөрөнгө оруулагчтай болж байна. Гэхдээ өрсөлдөгчид энэ удаад “залуулж” ирсэн гэж хэлж болно. Монгол Улсын Засгийн газраас хөрөнгө оруулагчдад хандсан Тавантолгойн урилгыг өнгөрсөн онд илгээсэн юм. Үүний үр дүнд уралдаант шалгаруулалт эхэлсэн.

Энэ удаад зургаан компани саналаа ирүүлжээ. Хятадын зах зээлд нүүрсний үнэ унасантай холбоотойгоор уг салбарт хөрөнгө оруулах хөрөнгө оруулагчдын сонирхол илт буурсан ч Хятад, Япон, АНУ-гийн компаниуд материалаа ирүүлсэн нь Тавантолгойн үнэ цэнэ өндөр хэвээр байгааг илэрхийллээ. Тендерт Монголын нүүрсний толгой компанийн нэг “Энержи ресурс”-тэй консорциум болж оролцсон БНХАУ-ын “Шэнхуа Энержи”, Японы “Сумитомо” корпорацийн хамтарсан түншлэл уралдаант шалгаруулалтад ялсан. Олон улсын уралдаант шалгаруулалтад дээрх хамтарсан түншлэлтэй өрсөлдсөн компани нь АНУ-ын “Peabody energy”. Дэлхийд нүүрсний үйлдвэрлэл, технологиороо хамгийн томд тооцогддог тус компани Монголд үйл ажиллагаа явуулаад цөөнгүй жилийг үдэж буй. Тийм ч учраас Тавантолгойн шалгаруулалт дээр “Peabody energy”-г дээгүүр давхина гэдэг хүлээлт нийгэмд байсан. Харин шалгаруулалтад тус компани яагаад гарч чадаагүй вэ? гэдэг дээр Монгол Улсын сайд, Тавантолгойн уралдаант шалгаруулалтын ажлын хэсгийн ахлагч М.Энхсайхан тэргүүтэй холбогдох албаны хүмүүс дараах тайлбарыг өгч байгаа юм. “Шэнхуа Энержи” тэргүүтэй гурван улсын консорциумын хувьд Монголын Засгийн газрын зүгээс тавьсан шаардлагыг хүлээж авсан төдийгүй хэд хэдэн тодорхой санал угтуулан хэлсэн. Түүнчлэн дотоодын салбартаа туршлагатай том компанитай консорциум болж орсоноороо давуу байсан. Монголын Засгийн газрын зүгээс ч Тавантолгой дээр үндэсний хөрөнгө оруулагчийг оруулах бодлого барьсан” хэмээн тайлбарласан. Гэхдээ Уул уурхайн сайд Р.Жигжид “Peabody Energy бол дэлхийд нэртэй том компани. Манайд хэдэн жилийн өмнөөс үйл ажиллагаа явуулж, бэлтгэл сайн хийж байгаа. Тиймээс хэдийгээр сонгон шалгаруулалтад ялаагүй ч гэсэн цаашдаа Тавантолгой дээр хамтарч ажиллах боломж нээлттэй. Энэ бол дэлхийд дээгүүр орох том уурхай учраас бид аль болох шилдэг, тэргүүн туршлагыг нэвтрүүлж ажиллах болно” гэв.

Олон жил дуншсан Тавантолгойн хөрөнгө оруулагч 2015 оны босгон дээр тодорч, Монголын Засгийн газартай хийх хамтын ажиллагаа, хөрөнгө оруулалтын гэрээ хэлэлцээр энэ сарын 5-нд эхэллээ. Хөрөнгө оруулагчийн шалгаруулалтаас ч дутахгүй их ажил, ойлголцол шаардах тус гэрээ амжилттай байгуулагдсанаар энэ хавраас бүтээн байгуулалтын ажил эхлэх юм. Ажлын хэсгийн ахлагч М.Энхсайхан сайд “Хэлэлцээрийг Цагаан сарын өмнө буюу ирэх сарын дунд гэхэд байгуулчих болов уу гэсэн бодол бий” хэмээн мэдэгдээд буй. Шалгарсан консорциум нь дараах үүргийг хүлээнэ:

- Таван толгойн ордын ашигт малтмал ашиглах тусгай зөвшөөрлийг хөрөнгө оруулагчийн мэдэлд шилжүүлэхгүйгээр “Хөрөнгө оруулж хамтран ажиллах гэрээ”-ний хүрээнд бүрэн ашиглуулах;
- Хөрөнгө оруулагч нь Тавантолгойн Баруун болон Зүүн Цанхийн ашигт малтмал ашиглах тусгай зөвшөөрлийн талбайд нүүрс олборлох, тэдгээр талбайд нэмэлт хайгуул хийж нөөцийг нэмэгдүүлэх;
- Хөрөнгө оруулагчаар сонгогдон ажиллах эхний 2.5 жилийн хугацаанд багтаан Тавантолгойн бүс нутагт 30.0 сая тонноос багагүй нүүрсийг баяжуулах хүчин чадлыг бий болгох, үйлдвэрлэсэн баяжмалыг хоёроос доошгүй орны зах зээлд нийлүүлэх;
- Хөрөнгө оруулагч нь “Эрдэнэс Тавантолгой” ХК-иас БНХАУ-ын “Чалко” компанид төлөх өр төлбөрийн үлдэгдлийг хариуцан барагдуулж, тус компанитай байгуулсан гэрээний үүргийг хариуцах;
- Эхний ээлжинд Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын суурь бүтцийг өөрийн хөрөнгө оруулалтаар барьж байгуулах. Уг замыг ашиглалтад орсноос хойш 30 жилийн дараа 51 хувийг төрийн мэдэлд үнэ төлбөргүй шилжүүлэн өгөх үндсэн нөхцөл бүхий барих-өмчлөх-ашиглах-шилжүүлэх эрхийг Кон- ▶



► цессын тухай хуульд заасан журмын дагуу хөрөнгө оруулагчид олгох,

Тавантолгой төсөлд их хэмжээний хөрөнгө оруулалт шаардлагатай байгаа. Энэ утгаараа дэлхийн хэмжээний төсөл. Тиймээс шалгарсан консорциум эхний ээлжинд дөрвөн тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт хийнэ хэмээн амласан байна. Үүний дөрөвний нэгээр төмөр замын бүтээн байгуулалтын ажлыг санхүүжүүлэх аж.

Хэдий стратегийн хөрөнгө оруулагчийг тодруулсан ч Тавантолгойн орд Монгол Улсын төрийн өмч хэвээр байна.

Хамтарсан түншлэлд багтсан компаниудын өөрийн хөрөнгө, зах зээлийн үнэ цэнийн талаас цухас дурьдвал:

- Хятадын “Шинхуа энерги” группын зах зээлийн үнэлгээ нь 60 тэрбум ам.доллар. Энэ бол тус группын өнөөгийн үнэ цэнэ. Өөрийн гэсэн төмөр зам, үйлдвэр, нүүрсээ арилжаалах зах зээлтэй гэдгээрээ том давуу талтай.
- Японы “Сумитомо” корпорацийн зах зээлийн үнэлгээ нь 13 тэрбум ам.доллар. Ази, Номхон далайн бүс нутагт нүүрс болоод бусад ашигт малтмалын борлуулагч. “Сумитомо” корпорацийн Монгол дахь салбарын захирал Хирото Фиживара “Манай компани 1992 оноос эхлэн Монголд үйл ажиллагаа явуулж эхэлсэн. Энэ төслийн хувьд бидний оролцоо гуравдагч зах зээлд нүүрсний борлуулалт хийхэд төвлөрөх болно” хэмээсэн.
- Монголын “Энержи Ресурс” ХХК нь Хонконгийн биржид бүртгэлтэй “Mongolian Mining Corporation”-ийн 100 хувийн охин компани юм. 500 сая ам.долларын үнэ цэнэтэй. Компанийн нийгмийн хариуцлагыг тэргүүн зэрэгт анхаардаг тус компани жилдээ 15 сая тонн нүүрс баяжуулах үйлдвэртэй. Мөн өөрийн байгуулсан цахилгаан станцтай.

Монголын Засгийн газар болон консорциум хоорондын хамтын ажиллагаа ба хөрөнгө оруулалтын гэрээ” зурагдсанаар “Энержи Ресурс” ХХК нь өөрийн эзэмшилд буй жилд 15 сая тонн нүүрс угаах үйлдвэрээ бүрэн хүчин чадлаар нь ашиглаж нүүрс боловсруулах зардлаа бууруулах. Хоёрдугаарт, Баруун ба Зүүн цанхиас нүүрс олборлох нөхцөл нь тус компанийн одоогийн олборлолт хийж буй Ухаа-Худагаас хялбар тул олборлолтын зардал буурах. Гуравдугаарт, төмөр зам баригдаж ашиглалтад орсноор тээврийн зардал нэг тонн тутамд долоон ам.доллараас хоёр ам.доллар болж буурах. Дөрөвдүгээрт, хоёрдогч орны зах зээлд нүүрсээ өндөр үнээр нийлүүлэх боломж бүрдэх юм. Үүний үр дүнд ашигт ажиллагаа өсч, улмаар “Mongolian Mining Corporation”-ий хувьцааны ханш өсөх боломжтой.

Эдгээр түншлэгч компаниуд нь олон улсын хөрөнгийн биржид бүртгэлтэй бизнесийн нэг хэлтэй гэсэн үг.

Ямартай ч Монголын “эмгэнэл” болоод байсан Тавантолгой амь орлоо. Эдийн засагт ахиу жин дарах мега төслийн цаашдын зам нь дардан байна гэдэгт итгэе. ■



ГЭРЭЛ ЗУРГИЙГ Б.БЯМБА-ОЧИР

ГАЗРЫН ТОС

Боловсруулах үйлдвэр боломжгүй зүйл биш

Б.АЛТАЙ

Монгол Улс нефтийн бүтээгдэхүүнийг 100 хувь импортоор авч хэрэглээгээ хангаж ирсэн. Уул уурхайн яамны мэдээллээр импортын шатахууны 90.8 хувийг ОХУ дангаар эзэлж байна. Засгийн газрын зүгээс энэ оноос нефтийн бүтээгдэхүүн дээр хэрэгжиж ирсэн “Үнэ тогтворжуулах” хөтөлбөрийг зогсоох болсноо мэдэгдсэн. Монголбанкны дэмжлэгтэй тус хөтөлбөр хоёр жил гаруйн хугацаанд хэрэгжсэн. Энэ нь шатахууны үнэ тогтвортой байхад

томоохон үүрэг гүйцэтгэсэн хэмээн салбарынхан онцолж байна. Хэдий “Үнэ тогтворжуулах хөтөлбөр” зогссон ч ойрын 4-5 сарын хугацаанд томоохон үнийн өөрчлөлт гарахгүй хэмээн Газрын тосны газрын дарга Г.Өлзийбүрэн мэдэгдсэн. Нөөцийн хувьд авч үзвэл, Монгол Улс одоогоор 114.6 мянган тонн импортын шатахуунтай байна.

Дэлхийн зах зээлд газрын тосны үнэ өнгөрсөн оны гуравдугаар улирлаас эхэлж буурсан. Энэ нь үнийн бодлогыг чөлөөлөх, зах зээлийн системд нь шилжүүлэх таатай боломжийг нэг талаар олгож байгаа аж. Ингэснээр

нефтийн бүтээгдэхүүний томоохон үнийн савлагаанд манай улс өртөхгүй байх юм. “Үнэ тогтворжуулах хөтөлбөр” нь уламжлалт бус мөнгөний бодлогын хүрээнд авч хэрэгжүүлсэн богино хугацааны хөшүүрэг. Олон улсын болон хөрш орны зах зээлээс хараат бус байх хувилбар нь өөрийн гэсэн боловсруулах үйлдвэртэй болох явдал.

Газрын тос боловсруулж шатахуун үйлдвэрлэх төсөл өнгөрсөн 20 гаруй жилийн хугацаанд мөрөөдөл байсан. Одоо ч мөрөөдөл хэвээр байна. Энэ чиглэлийн төсөл, хөтөлбөр гарч ирээд алга болдог зуршил тогтсон ▶

гэхэд болно. Манай улсын шатахууны хэрэглээ 2011 онд нэг тонноос давж, өдгөө 1.4 сая тонн-д хүрээд байгаа. Энэ нь газрын тос боловсруулах үйлдвэр байгуулах хангалттай шалтгаан юм. Нефтийн бүтээгдэхүүний хэрэглээ жил бүр өсөн нэмэгдэх болсон. Манайх хэрэглээг хангах үүднээс их хэмжээний валютыг гадагш төлж байгаа. Тиймээс дотооддоо боловсруулах үйлдвэр нэн хурдан барихгүй бол одоогийнхоос илүүг цаашид шатахууны төлбөрт төлнө гэсэн үг.

Шинэчлэлийн Засгийн газар бүрэн эрхийнхээ хугацаанд газрын тос боловсруулах үйлдвэр барих зорилт дэвшүүлсэн. Гэвч хугацаанаасаа өмнө “халагдсан” тул боловсруулах үйлдвэрийн асуудал шийдлийн Засгийн газарт үлдлээ. Газрын тос стратегийн чухал түүхий эд. Зөвхөн хэрэгцээт бүтээгдэхүүн байгаад зогсохгүй үндэсний аюулгүй байдлын баталгаа. Нефть боловсруулах үйлдвэртэй байснаар химийн үйлдвэр хөгжих боломжтой юм. Боловсруулах үйлдвэрийн төслүүдээс ихээхэн найдлага төрүүлж байгаа нь “Дархан-газрын тос”-ны үйлдвэр. Жилдээ хоёр сая тонн түүхий нефть боловсруулах хүчин чадалтай уг төслийн урьдчилсан техник эдийн засгийн үнэлгээ /ТЭЗҮ/ Японы олон улсын банкны санхүүжилтээр хийгдсэн. Гэвч хаана барих нь одоо хүртэл эцэслэн шийдэгдээгүй тул дээрх төслийн ажил зогсоод байгаа. Дархан-Уул аймагт

Шарын гол нүүрсний уурхайн төмөр зам дагуу үйлдвэр байгуулах байршил сонгоод байсан.


Газар зүйн байршил тодорхой бус байгаа нь боловсруулах үйлдвэр ашиглалтад орох хугацааг хойш сунгасаар. Хэрэв байршлын асуудал шийдэгдсэн бол энэ хавар 1.7 сая тонн шатахуун үйлдвэрлэх хүчин чадалтай боловсруулах үйлдвэрийн барилгын ажил эхлэх байсан. Үйлдвэр ашиглалтад орсноор улсын төсөвт 340 тэрбум төгрөгийн орлого орох юм. Хоногт 44 мянган тонн буюу жилд хоёр сая тонн газрын тос боловсруулах хүчин чадалтай уг үйлдвэр 1.7 сая тонн шингэн бүтээгдэхүүн үйлдвэрлэнэ. Үйлдвэрийг барьж байгуулахад 600 сая ам.долларын хөрөнгө оруулалт шаардлагатай. Үүний 85 хувийг Японы Олон улсын хамтын ажиллагааны банкны урт хугацаатай, бага хүүтэй зээлээр санхүүжүүлэх, үлдэх 15 хувийг Монголын тал гаргах учиртай байв.

Сураг нь ойр сонсогдсон боловсруулах үйлдвэрийн төсөл дахиад л алсарч байна. Гэхдээ санхүүжилт авахаар Японы Олон улсын хамтын ажиллагааны банктай эхлүүлсэн хэлэлцээ, технологи нийлүүлэгч “Тоёо инженеринг” компани хэвээр байгаа. Зөвхөн байршил, түүхий эдээ худалдан авах нөхцөлд л өөрчлөлт орж байгаа юм байна. Хэрэв энэ онд байршлаа эцэслэн тогтоож чадвал 2018 онд боловсруулах үйлдвэр ашиглалтад орох боломжтой аж.


Газрын тосны газрын мэдээлж байгаагаар Тамсагийн бүсээс өнгөрсөн онд 1.4 сая тонн тос, Зүүнбаянгаас 100-150 мянган тонн тос олборлох төлөвтэй байсан. Эдгээр ордуудыг эзэмшиж байгаа компаниудаас бүтээгдэхүүн хуваах гэрээгээр Монголын Засгийн газар олборлосон тосны 26.5 хувийг захиран зарцуулах эрхтэй юм. Энэ онд 700-800 мянган тонн тос Хятадын компаниуд манайхаас авч боловсруулах боломжтой аж. Мэргэжлийн байгууллагын судалгаагаар жилд 3-5 сая тонн газрын тос боловсруулж байж эдийн засгийн үр ашиг гарна гэсэн тооцоо бий. Хэрэв ийм хүчин чадалтай үйлдвэр барина гэвэл газрын тосны олборлолтоо нэмэгдүүлэх зүй ёсны шаардлагатай болно.

Газрын тос олборлож буй гурван талбай бий. Энэ талбайгаас Хятадын “Доншен”, “Петро чайна дачин Тамсаг” гэсэн хоёр компани газрын тос олборлож байна. Улсын хэмжээнд газрын тос боловсруулах үйлдвэр байгуулахаар тусгай зөвшөөрөл авсан найман аж ахуйн нэгж байна. Монгол Улс газрын тосны баталгаат нөөцөө эцэслэн тогтоогоогүйн зэрэгцээ хувийн хэвшилдээ итгэл үзүүлэн бодитой дэмжиж хөгжүүлж чадаагүй юм. Үүнийг “Монгеофизик” компанийн ерөнхий захирал, геологич Б.Дэндэвчулуун дурьдаад хөгжих маш том боломж, орон зай байгааг хэллээ. Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого болон Газрын тосны

Газрын тосны бүтээгдэхүүний импортын хэмжээ /улсаар/



Газрын тосны бүтээгдэхүүний импортын хэмжээ /төрлөөр/



Газрын тосны бүтээгдэхүүний импортын хэмжээ /2006-2014/ мянган тонн

	2006	2007	2008	2009	2010	2011	2012	2013	2014.07
Автобензин	250.66	268.87	367.33	323.20	285.95	322.24	344.44	393.03	238.72
Дизелийн түлш	291.21	325.71	430.01	413.76	500.55	635.89	686.76	827.11	386.37
Оngoцны түлш		24.13	40.94	14.96	27.49	34.39	24.96	62.56	26.33
Бусад /тос, битум, мазут, хий/	65.41	2031.	45.83	27.67	52.43	63.35	57.73	125.21	62.19

Эх сурвалж: Газрын тосны газар

▶ тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг өнгөрсөн онд баталсан. Энэ нь тус салбарын хөрөнгө оруулалтын орчинд эерэг “мессэж” түгээх болсныг “ПетроМатад” компанийн гүйцэтгэх захирал Т.Амарзул онцлов.

“ПетроМатад” компани газрын тосны хайгуулын гурван талбайтай. Үүнээс баруун бүсэд буй хоёр талбайдаа ихээхэн найдлага тавьж, хайгуулын ажлаа эрчимжүүлэх болсон. Иж бүрэн шинэчлэгдсэн эрх зүйн орчин нь энэ салбар дахь хөрөнгө оруулагчдын сонирхлыг ихэд татаж байгаа. Өнгөрсөн онд тус салбарт 600 орчим сая ам.долларын хөрөнгө оруулалт орж ирсэн. Монгол Улс дэлхийн газрын тосны салбарт бүрэн танигдаж амжаагүй шинэхэн тоглогч. Хоногт дунджаар 2810 тонн газрын тос олборлож, мөн тооны тосыг БНХАУ-д экспортолж буй манайх олборлогч орон гэсэн статустай. Газрын тос нь үндэсний аюулгүй байдлын баталгаа төдийгүй олон улсын харилцаанд голлох үүрэг гүйцэтгэдэг. Хамгийн ашигтай, ирээдүйтэй, хөрөнгө оруулалт татах боломжтой, хүний хэрэглээ болсон тус салбарт хөрөнгө оруулагчид нүд унагасаар ирсэн. Түүнийг олборлож буй Монгол Улс зах зээлийн таатай талбар төдийгүй хөрөнгө оруулалтын шинэ орчин.

Манай улсын газрын тосны

баталгааг нөөц нь 43.3 сая тонн. Хамгийн залуу нь хэмээн тодотгож болох тус салбарт өнгөрсөн 20 жилийн хугацаанд нийт 2.6 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт хийгдсэн. Үүний 1.5 тэрбум нь хайгуулын үйл ажиллагаанд зарцуулагджээ. Одоогоор гадаад, дотоодын 12 аж ахуйн нэгжийн газрын тос боловсруулах үйлдвэр байгуулах нийт 1.8 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт бүхий төсөл байгаа юм.

Газрын тосны тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдан гарснаар энэ салбарт хөрөнгө оруулагчдын тоо эрс нэмэгдэх хандлагатай байна. Тодруулбал, эрлийн ажлын гэрээ байгуулах 27 хүсэлт ирээд байгаа аж. Үүний 80 орчим хувь нь уламжлалт бус газрын тосны салбарт хөрөнгө оруулалт хийх хүсэлт байна. Энэ оны байдлаар газрын тосны хайгуулын 30 талбайн зөвхөн гурван талбайд нөөц тогтоогдсон. Нөөцийн хэмжээ нь 332.6 сая тонн бөгөөд үүнээс 43.3 сая тоннын ашиглалтын баталгааг нөөц. Газрын тосны салбар энэ жил улсын төсөвт 245.3 тэрбум төгрөг төвлөрүүлсэнийг энд тэмдэглэе.

Монгол Улсад 1990-ээд оноос газрын тосны хайгуулын ажил идэвхтэй өрнөж эхэлсэн. Үүнээс хойш өнөөдрийн байдлаар улсын хэмжээнд газрын тосны хэтийн төлөв бүхий хайгуулын

31 талбай ялгаснаас Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу 16 компани 18 талбайд газрын тосны хайгуулын үйл ажиллагаа явуулж байна. Гурван талбай ашиглалтад шилжиж, найман талбай гэрээ байгуулах шатанд, нэг талбай нээлттэй байна.

Улсын хэмжээнд 1998-2013 оны хооронд нийт 2.6 сая тонн тос олборлосон байдаг. Үүнээс 2.48 сая тонн газрын тосыг БНХАУ-д экспортлон газрын тосны орлогоос нийт 520 тэрбум төгрөгийг Монгол Улсын төсөвт төвлөрүүлсэн. Гэхдээ үүнээс ч илүүг олох боломж байсныг тус салбарынхан хэлж байсан. “Wolf Petroleum” компанийн захирлуудын зөвлөлийн дарга Т.Лхагвадорж “Шинэ эрх зүйн нааштай орчинд бид илүү идэвхтэй байх ёстой” хэмээн газрын тосны салбараа дүгнэсэн юм. Монголд буй газрын тос бол эх газрын тунамал хур тос. Түүнийг олох ажил хэдийнэ эхэлсэн. Энэ нь шинэ хөрөнгө оруулалтаар илэрч, газрын тосны салбарт Монгол Улс бүс нутагтаа тодрох явдал. Ингэснээр өөрсдийн хэрэгцээгээ хангах хэмжээнд тосоо боловсруулах нь хараат бус хөгжлийн шинэ хувьсал юм. ■

УУЛ УУРХАЙН САЛБАРЫН ТӨЛӨВ

Хүлээлт үргэлжлэхгүй

С.ЗАЯА

Уул уурхайн салбарт улстөрчдийн гар хөл оролцож буй учраас уруудаж, эдийн засаг унасаар сүүлийн хоёр жилийг үдэв. Ирэх онд Монголын уул уурхайн салбар ямар байх вэ, олон улсын зах зээл дээр энэ төрлийн бүтээгдэхүүний үнэ өсөх болов уу гэх хүлээлт бий болоод буй. Уул уурхайн мөчлөг дагасан эдийн засагтай манай оронд ашигт малтмалын үнийн хэлбэлзлийн шуурга хүчтэй нөлөөлдөг. Улиран одож буй онд дэлхийн зах зээл дээр үнэ унасан байсан бол ирэх жил нүүрснээс бусад салбарын бүтээгдэхүүний үнэ ханш харьцангуй тогтвортой байх таамаг байна.

Ямартай ч тогтворгүй бодлогынхоо уршгаар хөрөнгө оруулагчдаа үргээсэн ч итгэлийг нь дахин олохын тулд УИХ өнгөрсөн онд энэ чиглэлийн хууль эрхзүйн орчиндоо нэлээд өөрчлөлт орууллаа. Товчхондоо, өнгөрсөн онд /2014/ Алтны тухай, Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулж, “Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого”-ын баримт бичигтэй болсон. Гэхдээ хууль батлагдсанаар асуудал шийдэгдэхгүй. Баталсан хуулиа хэр мөрдөж буйгаас их зүйл хамаарна хэмээн энэ чиглэлийн мэргэжилтнүүд хэлж байна. Учир нь, бизнесийг дэмжихийн тулд хуулиар хориглосноос бусдыг нь зөвшөөрөх байтал төр шинээр журам гаргах

эсвэл түүнийгээ нарийсган хувийн хэвшилд дарамт шахалт үзүүлдэг байна. Төрийн албан хаагчдын хандлага өөрчлөгдөхгүй буй учраас бизнес эрхлэгчид үйл ажиллагаа явуулахад хүндрэлтэй байна гэдгийг тэд тэмдэглэн хэлж буй.

Энэ онд уул уурхайн салбарт хүлээгдэж буй 2-3 асуудал бий аж. Засгийн газраас “Урт нэртэй” хуулийг хэрэгжүүлэхийн тулд 200 гаруй шороон ордын лицензийн үйл ажиллагааг хоёр жилээр зогсоогоод байгаа. Энэ хүрээнд зөвхөн нөхөн сэргээлт хийх үүрэг өгсөн. Гэтэл хоёр жил нь дууссан ч үйл ажиллагааг нь явуулахгүй байсаар буй юм. Тухайн компаниуд олборлолт явуулж мөнгө ▶

▶ олж байж нөхөн сэргээлт хийнэ. Мөн Засгийн газар нөхөн сэргээлт хийлгэхийн тулд компаниудад хохирлыг нь өгөх ёстой. Тэгж чадахгүй байгаагаас аль аль талдаа байдал гацчихаад байгаа аж.

Монголын нэр хүндийг шавраас татаж гаргана

106 лицензтэй холбоотой асуудлыг шийдэхээр төр засгийн түвшинд ажиллаж байгаа ч ахиц дэвшил нь тааруухан байсан. Тэгвэл УИХ хаврын чуулганы төгсгөлд уг асуудлыг шийдвэрлэв. Энэ хүрээнд 18 талбайд сонгон шалгаруулалт явуулахаар болсон талаараа Уул уурхайн яамнаас оны өмнө мэдэгдлээ. Дээрх 18 талбайн сонгон шалгаруулалтад оролцох саналыг нэгдүгээр сарын 9-нийг хүртэл хүлээн авах юм байна. Талбайн тогтоосон босго үнийн 30 буюу түүнээс дээш хувийг төлсөн байх шаардлагыг сонгон шалгаруулалтад оролцож буй компаниудад тавьж буй аж. Мөн татварын өргүй байх, гуравдугаарт, хууль хяналтын болон шүүхийн маргаангүй байхаас гадна тухайн талбайд санал болгосон үнийг төлөх чадвартай гэдгээ арилжааны банкуудаар баталгаажуулсан байх шалгуур тавьж байна. Өнгөрсөн ес, аравдугаар сард нийт 23 талбайд сонгон шалгаруулалт явуулснаас 15 нь эзэндээ очжээ. Үүний 11 талбайг өмнө нь үйл ажиллагаа явуулж байсан компаниуд өөрсдөө авсан байна. Харин гурван талбайд огт санал ирээгүй байгаа бол таван талбайд нэг оролцогч хүсэлт явуулсан учраас дахин сонгон шалгаруулалт зарлаж буй аж. Энэ талаар Уул уурхайн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Батхүү “Эдгээр талбайд өмнө нь үйл ажиллагаа явуулж, хөрөнгөө зарцуулсан компаниудын хохирлыг барагдуулахын тулд босго үнэ тогтоосон. Өмнө нь дээрх талбайг эзэмшиж байсан компаниуд сонгон шалгаруулалтад оролцвол босго үнэ авахгүй” гэв.

Нийт 18 талбайн зургаа нь Өмнөговь, дөрөв нь Дорноговь аймагт харьяалагдаж байна. Дээрх талбайнууд эзэддээ очсоноор гадаад дотоодын хөрөнгө оруулагчид Монголыг сонирхож эхлэх юм. Уул уурхайд хүлээгдэж буй дараагийн асуудал нь Оюутолгойн далд уурхайн санхүүжилт, “Эрдэнэс Тавантолгой”-д гүйцэтгэгчийг шалгаруулах сонгон шалгаруулалт байв. Тавантолгойд

гэрээгээр нүүрс олборлож, түүнийгээ борлуулах эрхтэй компанийг сонгон шалгаруулснаар нүүрсний олборлолт нэмэгдэж, менежмент нь сайжрахаас гадна зах зээл дээр маркетингийн бодлогод тус нэмэр болох талтай гэж үзжээ. Одоо үндэсний компаниуд Тавантолгойн ордын Баруун, Зүүн цанхи дээр бага хэмжээгээр нүүрс олборлож байгаа. Гэхдээ борлуулалт хүндрэлтэй буй учир үүнийг шийдэх зорилгоор уг сонгон шалгаруулалтыг хийсэн аж. / “Чайна Шэнхуа Энержи”, “Сумитомо” корпораци, “Энержи Ресурс” ХХК-ийн хамтарсан түншлэлийг Тавантолгойн нүүрсний ордод хөрөнгө оруулагчаар шалгаруулсаныг 2014 оны арванхорёдугаар сарын 25-нд албан ёсоор зарласан/.



Алтны салбар сэргэж эхлэв

Алтны ашигт малтмалын нөөц ашигласны татвар/АМНАТ-ыг багасгаж 2.5 хувь болгосон гэдгийг дээр дурьдсан. Энэ нь тус салбарт үйл ажиллагаа явуулж буй компанийн тоог гурав дахин нэмэгдэхэд хүргэсэн байна. Мөн Монголбанкинд тушаасан алтны хэмжээ өмнөх жилүүдийнхээс 70 гаруй хувиар нэмэгдэж, эдийн засагт бодитой хөрөнгө оруулалт болжээ. Монгол Улс 4000 гаруй тонн алтны нөөцтэйгөөс 1000 тонн нь Оюутолгойнх. Алтны шороон ордод түшиглэж олборлолт явуулдаг компаниуд энэ жил 11 тонн алт олборлож, Монголбанкинд тушаахаар төлөвлөсөн ч энэ хэмжээнээсээ давсан амжилттай байна. Алтны компаниуд

нэмэгдсэнээр энэ чиглэлд ажлын байр ч олноор бий болжээ.

2013 онд 62 аж ахуйн нэгж зургаан тонн алт Төвбанкинд тушаасан бол өнгөрсөн жил энэ тоо бараг хоёр дахин нэмэгдэв. Ашигт малтмалын газраас гаргасан мэдээллээр алтны салбарт үйл ажиллагаа явуулдаг 300 гаруй аж ахуйн нэгж байдгаас идэвхтэй ажилладаг нь 200 гаруй аж. Үүнээс Төвбанкинд тогтмол алт тушаадаг 120 гаруй байдаг байна.

Манайд ирэх жил уул уурхай сэргэх нөхцөл бололцоо байгаа аж. Оюутолгойн асуудлаа шийдчихвэл бүх зүйл шуудрах учиртай. Мега төслүүд урагшилж эхэлбэл гадаадын хөрөнгө оруулалт орж ирэх учраас бид өрнөөс айх шаардлагагүй болно хэмээн Уул

уурхайн ассоциацийн ерөнхийлөгч Н.Алгаа хэлсэн. Энэ талаар тэрбээр “Хууль эрхзүйн орчин хангалттай болж эхэлж байна. Одоо хандлагаа өөрчлөх ёстой. Уул уурхайн салбарт нүүрснээс бусдынх нь үнэ унаагүй байгаа. 2016, 2017 оноос нүүрсний салбар аяндаа сэргэнэ. Улсын төсөвт уул уурхайн салбараас олох орлогыг хэт өөдрөгөөр төсөөлж ирсэн. Эрсдэлээ тооцож, байгаа боломжоос 20-30 хувиас доогуур төлөвлөх ёстой. Хамгийн тааруу хувилбараар төлөвлөвөл төсөвт тодотгол хийх шаардлага гарахгүй” гэв.

Уул уурхай ирэх онуудад сэргэж хандлагатай байгаа учир дахин үнэ унах хүртэл дээр дурьдсан салбаруудаа бойжуулах хэрэгтэй байна. Тэгж байж Монголын эдийн засаг дан ганц уул уурхайгаас хамаарахгүй болох юм. ■



ГЭРЭЛ ЗҮРГИЙГ Б.БЯМБА-ОЧИР

БАНКИР

Монгол Улс чухал зорилтууддаа анхаарч, шаламгай хөдлөх хэрэгтэй

Монгол Улсын арилжааны тэргүүлэгч банкуудын нэг ХААН Банкны Гүйцэтгэх захирал Норихико Като манай улсад 2009 оноос хойш ажиллаж, амьдарч байна. Ноён Норихико Като “Bank of Tokyo-

Mitsubishi UFJ”-ийн Бахрайн дахь салбарын ерөнхий захирал, Ойрх Дорнодын бүс хариуцсан захирлын албыг олон жил хашсан, банкны салбарын арвин их туршилагатай нэгэн билээ.

► **-ХААН Банк гадна, дотныхарилцагч, үйлчлүүлэгчдэд эзлэх бэрхшээл олонтой байгаа байх. “Moody’s” олон улсын үнэлгээний агентлаг танай банкны зээлжих зэрэглэлийг хэвээр үлдээсэн тухай сонссон. Энэ талаарх мэдээллээсээ хуваалцахгүй юу?**

-Олон улсын хөрөнгө оруулагчид, үнэлгээний байгууллагуудын хувьд Монгол Улсын эдийн засгийг хүндхэн байна гэж үзэж байна. Саяхан Moody’s Монголын зарим банкны зээлжих зэрэглэлийг бууруулсан бөгөөд ХААН Банкны хувьд зээлжих зэрэглэлийн үнэлгээгээ хадгалж үлдсэн ганц арилжааны банк болж байна. Үүний шалтгааныг манай банкны бизнесийн багц төрөлжилт сайтайгаас гадна багцын ихэнх хувийг харьцангуй тогтвортой иргэд болон жижиг, дунд бизнес эрхлэгчид бүрдүүлдэгтэй холбож тайлбарлаж болох юм.

Бидний үйл ажиллагаанд өгсөн олон улсын үнэлгээнд нөлөөлсөн чухал үзүүлэлт бол ХААН Банкны ил тод байдал, компанийн сайн засаглалыг тогтвортой бэхжүүлж ирсэн явдал юм. Эдийн засгийн орчин сайнгүй, макро эдийн засаг хүнд хэвээр байгаа энэ үед бид илүү соргог байж макро эдийн засгийн асуудлыг шийдвэрлэхийн тулд түргэн хөдлөх хэрэгтэй. Өнөөгийн энэ нөхцөлд аль ч банк эрсдэлээ бууруулах, зөв удирдахын төлөө шаргуу ажиллаж байгаа гэдэгт итгэлтэй байна.

-ХААН Банк кастодиан үйлчилгээ нэвтрүүлэхээр ажиллаж байгаа. Энэ талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгөхгүй юу?

-Кастодиан үйлчилгээг асар том боломж гэж ойлгож болно. Ийм ч учраас Монгол Улс уг үйлчилгээг нэвтрүүлэх хэрэгтэй. Дэд кастодианы үйлчилгээг бий болгосноор Засгийн газрын бонд, Монголын том аж ахуйн нэгж, компаниудын хувьцаа зэргээр дамжуулан гадны хөрөнгө оруулалт татах таатай боломж нээгдэх юм. Ийм төрлийн үйлчилгээг эрхлэн явуулах нь эдийн засагт чухал ач холбогдол үзүүлдэг. Гэвч кастодиан үйлчилгээ нь найдвартай систем, сайн программ хангамжаас гадна маш нарийн детальчилсан үйл ажиллагаа шаарддаг. Гэхдээ кастодиан банкны үйлчилгээ үзүүлэх нь банкуудад илүү тохиромжтой ч үүнд асар их хэмжээний хөрөнгө оруулалт, хүчин чармайлт хэрэгтэй. Энэ төрлийн бизнес ашиг, өгөөжөө өгч эхлэх хүртэл олон жил хүлээх хэрэг гарах ч дунд болон урт хугацаандаа банкуудад бизнесийн том боломж гарна. Одоогоор арилжааны хоёр банк Кастодиан банкны үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй. ХААН Банк ч мөн зөвшөөрөл авахаар байна. Бид Гадаадын хөрөнгө оруулагчид болон дэлхийн хэмжээний Кастодиан банкуудтай ойр холбоотой байдаг. Тэд Монголд хөрөнгө оруулах сонирхол бүхий олон хөрөнгө оруулагчидтай хамтран ажилладаг. Дэлхийн хэмжээний кастодианууд хөрөнгө оруулагчдад сайн үйлчилгээ үзүүлэхийн тулд тухайн нэг орны дэд кастодиантай өндөр түвшинд хамтран ажилладаг. Монголын банкуудын хувьд үр ашигтай, найдвартай, хяналт зохион байгуулалтыг зохих түвшинд хадгалах, улмаар дэлхийн хэмжээний кастодиануудын шаардлагад нийцэхийн тулд ихээхэн хүчин чармайлт гаргах хэрэгтэй байна.

-Тэгвэл манай оронд кастодиан үйлчилгээний ирээдүй хэр гэрэлтэй харагдаж байна вэ? Таны бодлоор бүх арилжааны банкууд энэ үйлчилгээг нэвтрүүлэх хэрэгтэй юү?

-Дэд кастодианы үйлчилгээ үзүүлэх эсэх нь тухайн банкны стратегиас хамаарах боловч энэ бизнес үйл ажиллагааны өндөр чадавхаас гадна системд асар их хөрөнгө оруулалт шаарддаг. Бүртгэл, ноогдол ашгийн хуваарилалт, татвар төлөлт, үнэн зөв тайлагнал гээд олон зүйлийг автомагжуулсан байх шаардлагатай. Ямар нэгэн алдаа мадаг гарах учиргүй.

Эдгээр нь кастодиан үйлчилгээний үндсэн шаардлага. Иймд энэ салбарт тунаж үлдэх банк харьцангуй цөөн байх болов уу. Түүнчлэн тухайн улсын зах зээл, эдийн засгийн хэмжээ кастодиан үйлчилгээнд хязгаар болох нь бий.

Нөгөө талаар хөрөнгө оруулагчдыг сэтгэл амар байлгах үүднээс зах зээл дээр тодорхой тооны дэд кастодиан байх хэрэгтэй. Тухайн оронд ганцхан дэд кастодианд найдах нь эрсдэлтэй.

-Хөрөнгө оруулагчид энэхүү боломжийг хэрхэн харж байна вэ. Тэд яаж хүлээж авч байгаа бол?

-Монголыг сонирхож буй гадаадын хөрөнгө оруулагчид олон байгаа. Харамсалтай нь улсын өнөөгийн зах зээлийн нөхцөл байдал, имиж өмнөхөө бодвол харьцангуй муудсан. Хэдий тийм ч хэд хэдэн гадаадын томоохон хөрөнгө оруулалт хэдийнэ хийгдсэн байна. Монгол Улсад дунд болон урт хугацаанд илүү таатай боломжууд гарна. Дэлхийн хэмжээний томоохон кастодиан банкууд Монголын санхүүгийн зах зээлийн өсөлтийн үйл явцыг сонирхсоор байгаа бөгөөд уг бизнестэй холбоотой бүхий л мэдээ, мэдээллийг судалж, Монголын хөрөнгө оруулалтын орчны хөгжил хэрхэх бол хэмээн ажиг сууна. Олон улсын хөрөнгө оруулагчдад найдвартай үйлчилгээ үзүүлэх үүднээс дэлхийн кастодианууд болгоомжтой ажиглаж байгаа. Учир нь том байгууллагууд кастодиан үйлчилгээ нэвтрээгүй оронд ерөнхийдөө хөрөнгө оруулалт хийдэггүй. Харин жижиг эсвэл бие даасан хөрөнгө оруулагчид брокерийн фирмүүдээр дамжуулан Хөрөнгийн бирж, Засгийн газрын үнэт цаасанд хөрөнгө оруулалт хийдэг.

-Та Монголын банкны салбарын өнөөгийн түвшин, ирээдүйн хөгжлийг хэрхэн дүрслэх вэ?

-Банкинд тулгардаг түгээмэл асуудлын нэг нь хөрөнгийн чанар болон хөрвөх чадвар юм. Сүүлийн хоёр жилийн хугацаанд зээл давамгайлсан мөнгөний бодлого явуулсаны дүнд өнгөрсөн оны долдугаар сард бодлогын хүү өслөө. Монголын Засгийн газар болон Төвбанкны зүгээс тэдгээр зээлийн хөтөлбөрийг аажмаар зогсоох бодлого баримталж буй ч арай бага цар хүрээнд хөтөлбөрүүдийг санхүүжүүлсээр байна.

Эрх баригчид инфляци гаарч үнийн хөөсрөл хагарахаас сэргийлж мөнгөний нийлүүлэлтийг багасгаж буй нь мэдээж. Өмнөх үетэйгээ харьцуулахад зах зээлд төгрөгийн хомсдол үүсч, эдийн засгийн хөгжил ч саарч байна. Улмаар энгийн харилцагчдад банкнаас зээл авахад бэрхшээлтэй эсвэл өртөг өндөртэй болдог. ХААН Банк харилцагчдынхаа хэрэгцээ шаардлагыг хангахуйц хүрэлцээтэй хөрвөх чадвартай байх үүднээс хөрвөх чадвараа зохистой хэмжээнд хангах тал дээр маш хянамгай ажилладаг.

Хөрвөх чадвар, хөрөнгийн чанар нь Монголын банкуудад тулгамддаг түгээмэл асуудал. 2008, 2009 онууд ДНБ-ий өсөлт хасах үзүүлэлттэй гарч, банкуудын чанаргүй зээлийн харьцаа одоогийнхоос харьцангуй өндөр байсан. Өдгөө банкууд туршлагаасаа суралцаж, хөрөнгийн чанараа зохистой удирдахад илүү анхаарал хандуулах болсон.

-Монголчууд ХААН Банкнд ихээхэн итгэл хүлээлгэдэг. Харилцагчдынхаа хүрээг тэлэх тал дээр ямар төлөвлөгөөтэй ажиллаж байна вэ?

-ХААН Банкнд итгэл хүлээлгэн сонгон үйлчлүүлдэг эрхэм ►►

“Хөрвөх чадвар, зээлийн чанараа зөв удирдах, мөн ашгаа нэмэгдүүлэхийн тулд харилцагчийн үйлчилгээгээ сайжруулах хэрэгтэй”

► харилцагчиддаа бид үнэхээр их талархдаг. Улсын хэмжээнд хамгийн олон салбартай манай банкны харилцагчдын олонхыг жижиг, дунд бизнес эрхлэгчид болон өсөн нэмэгдсээр байгаа том аж ахуйн нэгжүүд эзэлдэг. Бидний зорилго харилцагчдынхаа итгэлийг алдалгүй тэдний хэрэгцээ шаардлагад хүрч ажиллахад оршдог.

Банк нь эдийн засгийн ямар ч үеийг давах санхүүгийн хүчирхэг чадамжтай, нээлттэй ил тод байх нь маш чухал. Одоогоор Монголын ямар ч банк хөрөнгийн бирж дээр гараагүй байна. Хөрөнгийн биржид хэрвээ бүртгэлтэй болвол банк болон аж ахуйн нэгжүүдийн хувьд олон улсын хөрөнгийн зах зээлийн ил тод байдлын шаардлагыг хангах үүрэгтэй байдаг. Монголын банкуудын тухайд Төвбанкны ил тод байдлын шаардлага болон зааварчилгааг мөрддөг. Нэг талаар энэ нь биелүүлбэл зохих хамгийн наад захын шаардлага юм. Банкуудын цахим хуудас дахь мэдээлэл зэргээс банк бүр аль болох ил тод байхыг эрмэлзэж буйг харж болно. Үүнийхээ хариуд тэд хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчид, хадгаламж эзэмшигчдийн итгэлийг хүлээнэ. Банкууд ил тод байдлын үндсэн шалгуурыг биелүүлэх төдий бус түүнийг давуулан биелүүлэх зорилт тавин ажиллах нь зүйтэй болов уу.

-Монголын эдийн засгийн чадавхыг та юу гэж харж байна вэ? Олон улсын хөрөнгө оруулагчид, банкируудын хүлээлтээс илүүг бүтээх боломж бий юу?

-Монгол Улс асар их байгалийн нөөц баялагтай, харьцангуй цөөн хүн амтай. Иргэд нь ерөнхийдөө өндөр боловсролтой, шаргуу хөдөлмөрлөдөг. Монголын ирээдүй тод гэрэлтэж байна. Мөн тун сонирхолтой боломжуудыг дэлхий дахинд нээж өгч байна. Гэхдээ зөвхөн газрын гүн дэх баялгаа ашиглах биш эдийн засгаа төрөлжүүлэх тал дээр анхаарах хэрэгтэй. Үүнийг инклюзив буюу хүртээмжтэй хөгжил гэдэг. Бодлого тодорхойлогчид үүнийг анхаарах хэрэгтэй байх. Зөв хөдөлбөл уул уурхай хөгжлийг хурдасгана. Уул уурхайгаас орж ирэх хөрөнгийг эдийн засгийн бусад салбараа хөгжүүлэхэд ашиглаж болно.

-Эдийн засгийг төрөлжүүлэхэд банкны салбар нэгэн хөдөлгүүр нь байж болох уу?

-Аливаа орны банкны салбар хөрөнгө босгож бусад салбараа санхүүжүүлэх, хөгжил өөд хөглөх үүрэг хүлээн ажилладаг. Бидэнд шууд хөрөнгө оруулалт хэрэгтэй учраас гадаадаас санхүүжилт босгож байна. Гэхдээ ирээдүйд Монгол санхүүжилт авдаг биш харин хөрөнгө экспортлодог орон болохыг үгүйсгэх аргагүй. Ийм хэмжээнд хүрэхийн тулд олон төрлийн санхүүгийн үйлчилгээ нэвтрүүлэх шаардлагатай. Тухайлбал, газрын тос олборлогч орнуудад сангийн хөрөнгө оруулалтыг удирдах зэрэг байж болно. Бусад хөрөнгийн зах зээлд хөрөнгө оруулахад санхүүгийн байгууллагуудаас нарийн үйлчилгээ шаардах тул эдгээрийг аажимдаа хийх байх. Мөрөөдөлтэй байх сайхан л даа, гэхдээ Монгол Улс өнөөдөр чухал зорилтуудаа анхаарч шаламгай хөдлөх хэрэгтэй байна.

-Тэгвэл банкны салбарын хувьд нэн тэргүүнд хийх зүйл нь юу вэ?

-Хөрвөх чадвар, зээлийн чанараа зөв удирдах мөн харилцагчийн үйлчилгээг сайжруулж тэдний эрэлт хэрэгцээнд нийцэхүйц үйлчилгээг хүргэх хэрэгтэй. Үүнийг хөрсөнд буулгах амар биш. Гэхдээ үйл ажиллагаагаа сайжруулахын төлөөх тасралтгүй хүчин чармайлт биднийг урагш хөглөж чадна.

-Танай банкны бүтээгдэхүүн, үйлчилгээний шинэчлэл рүү эргээд орё. ХААН Банк мэдээллийн аюулгүй байдлын олон улсын стандартыг хангасныг гэрчилсэн батламжаа авсан байна. ISO/IEC 27001:2013 гэж яг юу болох хэрэглэгчдэд ямар давуу талуудыг бий болгож

байгаа талаар дэлгэрүүлэхгүй юү?

-Мэдээллийн аюулгүй байдал гэдэг нь зөвхөн банкны салбарт бус бусад салбарт ч чухал хүчин зүйл байдаг. ХААН Банк харилцагчдынхаа мэдээллийн аюулгүй байдлыг хангахад чиглэсэн ISO/IEC 27001:2013 олон улсын стандартын батламжаа гардан авсан. Энэхүү батламж нь манай банк олон улсын стандартад нийцсэн мэдээллийн аюулгүй байдлын удирдлагын тогтолцоог бүрдүүлж чадсаныг гэрчилж буй юм.

Тус стандартыг нэвтрүүлснээр бид банкны мэдээлэл, мэдээллийн хөрөнгө, харилцагчийн мэдээллийг гаднын болон дотоодын элдэв халдлагаас хамгаалах, мэдээллийн аюулгүй байдалтай холбоотой аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх, үйл ажиллагааны тасралтгүй байдлаа хангах зэрэг олон давуу талтай болж байгаа юм.

Түүнчлэн тус олон улсын стандартын шаардлагад зохих систем, бодлого журмыг нэвтрүүлэх, харилцагчийн мэдээллийн аюулгүй байдалд тулгарч буй эрсдэлүүдийг тодорхойлж, арилгах зэрэг багтсан бөгөөд бид ч зохих ёсоор хэрэгжүүлсэн байгаа. Үүнд бид бүтэн жил хагасын хугацааг зарцуулжээ. Гэхдээ батламж авахдаа бус олон улсын стандартыг өдөр тутмын үйл ажиллагаандаа нэвтрүүлэх нь гол зорилго байсан юм. Бид жил бүр хяналтын шалгалтад орно. Тэгэхээр энэ бол нэг удаагийн амжилт биш. Ололт, амжилтаа хадгалж үлдэх урт зам бидний өмнө байна. ISO/IEC 27001:2013 бол мэдээллийн аюулгүй байдлыг хангах олон улсын стандартын хамгийн сүүлийн хувилбар юм. ХААН Банк энэхүү стандартыг хангасан Монголын анхны байгууллага болсондоо баяртай байна.

-ХААН Банкны баримталдаг гол үзэл баримтлал юу вэ?

-ХААН Банк бол Монголын банк. Манай банк Монгол болон гадаад хувьцаа эзэмшигчидтэй. Манай үйл ажиллагаа Монгол Улсын хууль эрх зүйн хүрээнд явдаг бөгөөд бид Монгол орны өнцөг булан бүрт суугаа харилцагчиддаа санхүүгийн үйлчилгээ үзүүлдэг. Бидний гол үзэл баримтлал бол Монгол Улсын эдийн засгийн тогтвортой хөгжилд цаашид ч хувь нэмрээ оруулж харилцагчдынхаа бидэнд хүлээлгэсэн итгэлийг хадгалах явдал юм. Мөн бид шилдэг туршлагыг нэвтрүүлэх замаар одоогийн үйл ажиллагаагаа улам бүр сайжруулахыг эрмэлздэг.

-Гүйцэтгэх захирлын албан тушаалыг авснаас тань хойш гарсан эдийн засгийн өөрчлөлтийн талаар хуваалцвал?

-Албан тушаалаа хүлээж аваад гурван жил болжээ. Би 2009 онд анх Монголд ирж байсан. Тухайн үед ХААН Банкны зөвлөхөөр томилогдож байсан юм. Улмаар 2011 оноос банкныхаа гүйцэтгэх захирлын албыг хашиж болсон. Энэ хугацаанд гарсан Монголын хөгжил, амжилтаар үнэхээр бахархаж байна. Амьжиргааны түвшин үнэхээр сайжирсан төдийгүй хувийн хэвшлийн салбар ч урд урдынхаасаа илүү хөгжсөн. Хэдийгээр шийдвэрлэх асуудал олон байгаа ч сүүлийн жилүүдэд гарсан эдийн засгийн хурдацтай хөгжил олон эерэг өөрчлөлтийг авчирсан. Гэхдээ дээр хэлсэнчлэн эрүүл, тогтвортой хөгжлийг цэцэглүүлэхэд яаралтай хийх ёстой зүйл их байна.

-Банкны салбарынханд хандан та ямар зөвлөгөө өгөх вэ?

-Дан ганц банкны салбар гэлтгүй санхүүгийн байгууллагууд ч гэсэн өсөлт, зорилгоо урт хугацаанд тогтвортой хадгалахын тулд удирдах ур чадвараа хөгжүүлж, үйлчилгээг мөн сайжруулахын тулд шаргуу хөдөлмөрлөх хэрэгтэй. Богино хугацааны боломж хайсан өсөлт тогтвортой байж чадахгүй. Зөв бодлого, зөв дүрэм журам, зөв практик урт хугацааны тогтвортой хөгжилд хүрэх түлхүүр гэж хэлмээр байна. ■

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ

Онцлох үйл явдлууд, шинээр юу хүлээж болох вэ?



Г.МӨНХ-ЭРДЭНЭ
/Гаули УЦК-ийн хөрөнгө оруулалтын шинжээч/

Сүүлийн хоёр жилийн хугацаан дахь цор ганц IPO




Эх сурвалж: www.mse.mn

Сүүлийн хоёр жилийн хугацаанд хөрөнгийн зах зээлд нэг ч IPO хийгдээгүй байв. Харин “Мерекс” ХХК нь өнгөрсөн онд олон нийтэд хувьцаагаа нээлттэй арилжаалж, нэгж бүрийг нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэтэй, 2.6 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтыг амжилттай татаж чадлаа. Хөрөнгө оруулалтаараа Солонгосын техник технологи бүхий цагт 150 шоо метр бетон зуурмаг үйлдвэрлэх хүчин чадалтай компани байгуулахаар төлөвлөжээ. Туршилтын үйлдвэрлэлтээрээ 1500 шоо метр бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн. Бетон зуурмаг үйлдвэрлэх тусгай зөвшөөрлөө авсан бөгөөд “Стандарт Пропертис” ХХК-д 80,000 шоо метр бетон зуурмаг нийлүүлэх гэрээг үзэглэсэн байна. Энэ оны хавраас үйлдвэрлэлээ жигдрүүлэхээр ажиллаж байна.


Засгийн газрын үнэт цаасыг биржээр дамжуулан арилжаалдаг болов

Хоёр жил гаруйн хугацаанд тасраад байсан ЗГҮЦ-ны арилжааг 2014 оноос МХБ-ээр дамжуулан арилжаалдаг боллоо. Эхний ээлжинд нийт 100 тэрбум төгрөгийн үнэт цаас арилжаалахаар төлөвлөснөөс хоёр сарын хугацаанд 31.3 тэрбум төгрөгийн үнэт цаас арилжаалагджээ. Энэхүү үнэт цаас нь эрсдэлгүй, хөрвөх чадвар сайтай, хүү өндөр хөрөнгө оруулалтын хэрэгсэл болсон учир жижиг хөрөнгө оруулагчдын анхаарлыг ихээхэн татаж байгаа юм. Жилийн хүү 16 орчим хувьтай байгаа нь банкны хадгаламжийн хүүтэй өрсөлдөхүйц өндөр, хугацаа нь 3, 7, 12 сарын хугацаатай учир хөрвөх чадвар сайтай, ЗГҮЦ учир эрсдэлгүй юм. Хүү ийнхүү өндөр байгаа нь эдийн засаг

ЗГҮЦ арилжааны мэдээ /тэрбум төгрөг



Өгөөжийн муруй /Жилээр



муудсантай холбоотой бөгөөд эдийн засаг сайжрах үед хүү буурах учир богино хугацаанд олдож буй уг боломжийг хөрөнгө оруулагчид ашигласнаар хөрөнгөө илүү хувиар эрсдэлгүй өсгөх боломжтой юм.

Шинэ хууль эрх зүйн орчин хэрэгжиж эхэллээ

2014 онд Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль, үнэт цаасны зах зээлийн тухай хууль хэрэгжиж эхлэв. Өнгөрсөн оны нэгдүгээр сарын 1-нээс хэрэгжиж эхэлсэн уг хоёр хуулиас хүлээгдэж буй нэн тэргүүний үр дүн нь хөрөнгө оруулалтын сан байгуулагдаж, зах зээлд эргэлдэх хөрөнгийн хэмжээ өсөх, мөн мэдээллийн ил тод байдал сайжрах байв. Хөрөнгө оруулалтын сан байгуулах материалаа Санхүүгийн зохицуулах хороонд бүрдүүлж өгсөн 2-3 компани байгаа гэсэн албан бус мэдээ бий. Гэхдээ сантай холбогдох журам нь өнгөрөгч арванхоёрдугаар сард батлагдсан учир хөрөнгө оруулалтын албан ёсны анхны сангууд 2015 онд байгуулагдах төлөвтэй байна. Хөрөнгө оруулалтын сангийн ▶▶

▶ хууль нь зөвхөн хамтын сан, хувийн сангийн зохицуулалтыг хийж байгаа бол Тэтгэврийн сангийн тухай хуулийг тусад нь баглахаар болсоныг дурьдах нь зүйтэй. Мэдээллийн ил тод байдал ялимгүй сайжирсан гэж үзэж болох юм. Иймээс хуулийн хэрэгжилтийг сайжруулахад онцгой ач холбогдол өгч ажиллах шаардлага үүсээд байгаа юм. Хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль, журмын дагуу хувьцаат компаниудад ямар боломжууд байгаа, ямар үүрэгтэй болсон, хөрөнгө оруулагчид хэрхэн өөрийгөө хамгаалах эрх зүйн орчин бүрдсэн зэргийг сурталчилан, таниулах, хууль хэрэгжүүлэх ажлыг Санхүүгийн зохицуулах хороо, мэргэжлийн компаниуд хамтран нарийн төлөвлөгөөний дагуу зохион байгуулах нь зүйтэй гэж бид үзэж байна.

Төрийн зүгээс хөрөнгийн зах зээлд анхаарч эхлэв

Сангийн яам өнгөрсөн онд Монголын хөрөнгийн биржийг өөрийн харьяандаа шилжүүлж, менежментийн багийг томилов. Төрийн өмчийн хорооны удирдлагад байсан тус биржийг яамны харьяанд шилжүүлсэн нь төрийн зүгээс хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэхэд анхаарал хандуулж буй эхний алхам гэж үзэж байна. Ингэснээр компаниудын санхүүгийн тайлагнал сайжрах, цаашилбал хөрөнгийн зах зээлд хөрөнгө оруулагч бий болгох ажлыг эхлүүлэх боломж бүрдэх юм. Мөн төрийн өмчийн хороо нь олон төрлийн салбаруудад үйл ажиллагаа явуулдаг компаниудыг нэгтгэн удирддаг, санхүүгийн зах зээлийн чиглэлээр мэргэшсэн байгууллага биш байсан бол биржийг энэ чиглэлээр мэргэшсэн Сангийн яаманд шилжүүлж буй нь урт хугацаандаа эерэг нөлөөтэй. Ингэснээр зах зээлийг хөгжүүлэхэд институцийн оновчтой бүтэц бүрэлдэж байна гэж бид дүгнэж байна. Уг үйл явдал нь зах зээлийг хөгжүүлэх хамгийн эхний алхам бөгөөд цаашид урт хугацааны тогтвортой хөгжлийн бодлого хэрэгжүүлэх шаардлагатай.

Эрдэнэс Тавантолгойн хувьцааны үнэ цэнэ нэмэгдэхэд нэг алхам урагшиллаа



2014 оны хамгийн чухал үйл явдал нь “Тавантолгойн тендер дуусч, ялагч тодорсон явдал” юм. Ингэснээр таван жил үргэлжилсэн Тавантолгойн орд эдийн засгийн эргэлтэд хэрхэн оруулах урт хугацааны гэрээ хэлцэл хийгдэхэд тун ойрхон байгаа юм. 2014 оны найман сард Тавантолгойн ордод хөрөнгө оруулалт, үйл ажиллагаа явуулах компанийг сонгон шалгаруулах Засгийн газрын 268 дугаар тогтоол гарсан. Тогтоолын дагуу компаниуд материалаа ирүүлснээс Хятадын “Шенхуа Энержи”, Японы “Сумитомо”, Монголын “Энержи Ресурс” компаниудын консерциум ялсан нь энэ юм. Ялсан консерциум нь төмөр зам, нүүрс боловсруулах үйлдвэр барих, “Чалко”-д төлөх өрийн асуудлыг өөрсдийн хөрөнгө оруулалтаар шийдэн, Баруун ба Зүүн цанхид олборлолт хийн, нүүрсийг баяжуулж, хоёроос доошгүй зах зээлд жилд хамгийн багадаа 30 сая тн нүүрс нийлүүлэх үүрэг хүлээнэ. Тендерт ялсан консерциум Монгол Улсын Засгийн газартай хамтын ажиллагаа ба хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах ажлаа энэ сарын 5-наас эхлэв. Монгол Улсын сайд М.Энхсайхан “Талууд гэрээг богино хугацаанд

байгуулах боломжтой” гэж үзэж байгаагаа илэрхийллээ. Тус консерциум нь уг ордод нийт 4.0 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт хийхээр тооцоолсон бол үүний 1.1 тэрбумыг төмөр замд зарцуулахаар төлөвлөжээ. Хэрэв талууд гэрээгээ байгуулвал удаан хүлээгдсэн Тавантолгойн орд эдийн засгийн эргэлтэд орж, иргэдийн гар дээрх Эрдэнэс Тавантолгойн хувьцааны үнэ цэнэ нэмэгдэх юм. Хэдийгээр иргэд Эрдэнэс Тавантолгойн 1072 ширхэг хувьцаагаа тэр даруйд нь эргэлтэд оруулах боломж бүрдэхгүй ч ногдол ашиг хэлбэрээр өгөөж хүртэх боломж нээгдэж болох юм.

2015 онд юу хүлээж болох вэ?

Тавантолгойг эдийн засгийн эргэлтэд оруулах магадлал өндөр байна

Тавантолгойн тендерт шалгарсан гурван улсын консорциумын Монголын Засгийн газартай байгуулах хамтын ажиллагаа, хөрөнгө оруулалтын гэрээг талууд Цагаан сарын өмнө байгуулахаар ажиллаж байгаа тухай М.Энхсайхан сайд мэдэгдсэн. Хэрэв гэрээ амжилттай зурагдвал гурван жилийн хугацаанд 4 тэрбум орчим ам.долларын хөрөнгө оруулалтыг таван толгойн ордод оруулж,

- Жилд 30 сая тн нүүрс баяжуулах үйлдвэр
- Таван толгойгоос Гашуун Сухайт хүртэлх төмөр зам зэргийг бүтээн байгуулж урт хугацаандаа жил бүр 30 сая тонн нүүрсийг олборлож, баяжуулан хоёроос доошгүй зах зээлд нийлүүлэх юм. Дээрх бүтээн байгуулалтыг хийснээр одоогийн нүүрсний олборлолт, баяжуулалт, тээвэрлэлтийн өртөг тонн тутамд хамгийн багадаа 20 ам.доллараар буурах урьдчилсан тооцоог хийж болох юм. Ингэснээр зардлын хэмжээ жилдээ 600 сая ам.доллараар буурч /30 сая.тн*20 ам.доллар хэмнэх зардал/ үүний хэрээр компаниуд ашигтай ажиллах боломж бүрдэнэ.

Уг төсөл хэрэгжсэнээр богино хугацаанд гадаад валютын дотогшилох урсгал нэмэгдсэнээр долларын ханш буурах, дунд хугацаандаа нүүрсний экспортын орлого нэмэгдэх, урт хугацаандаа иргэдийн эзэмшиж буй Эрдэнэс Тавантолгойн хувьцааны үнэ цэнэ өсөх боломж бүрдвэл энэ оноос дотоодын жижиг хөрөнгө оруулагчдын хөрөнгийн зах зээл дэх оролцоо өсөн нэмэгдэж, зах зээл тодорхой хэмжээнд идэвхжих юм.


Би Ди Сек ХК нэмэлт хувьцаагаа арилжаалж дуусна

“Би Ди СЕК” ХК нь 2014 онд нийт хувьцааныхаа 35.29 хувьтай тэнцэх хэмжээний хувьцааг нэмж гаргах, түүнээс тэргүүн ээлжинд хувьцаа эзэмшигч нарт зах зээлийн үнээс хямдаар худалдан авах бололцоо олгосны дагуу нэмж гаргаж буй хувьцааны 32.61 хувь нь буюу нийт 1,956,625 ширхэг хувьцааг худалдаалж нийт 3,778,242,875 төгрөгийг татан төвлөрүүлсэн. Үлдэж буй 4,043,375 ширхэг хувьцааг олон нийтэд нэг бүрийг нь 2,146 төгрөгөөс доошгүй үнээр 2015 онд арилжаалах юм. Татан төвлөрүүлсэн хөрөнгийн 94 хувийг андеррайтер, хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг өргөжүүлэхэд зарцуулах бол зургаан хувийг хүний нөөцийн хөгжил, ESOP хөтөлбөр хэрэгжүүлэхэд зарцуулахаар төлөвлөжээ. Андеррайтер, хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг өргөжүүлэх ажлын хүрээнд биржид хувьцаа ▶


Эх үүсвэр /тэрбум төгрөгөөр/



Орлого, ашиг /тэрбум төгрөгөөр/



Трейнинг P/B



► нь арилжаалагдаж буй компаниудад хөрөнгө оруулалт хийх, хаалттай хэлбэрээр барилга, уул уурхай, санхүү, аж үйлдвэрийн чиглэлийн компаниуд хөрөнгө оруулалт хийх юм. Ингэснээр 2014 онд 2.22 тэрбум төгрөгийн ашигтай ажиллах бол 2016 гэхэд 4.9 тэрбум төгрөгийн ашигтай ажиллах тооцоог Би Ди Сек ХК хийжээ. Тус компани нь 2013 онд Монголын хөрөнгийн биржийн хувьцааны арилжааны 73 хувийг дангаар гүйцэтгэсэн, нийт 14 компанийн 18.1 тэрбум төгрөгийн бондыг гаргаж хөрөнгө оруулалт татсан, 10 гаруй IPO хийсэн, хамгийн том брокер, дилер, андеррайтерийн компани юм.

2-3 IPO хийгдэх боломжтой

Хэдийгээр эдийн засаг хүнд байгаа ч андеррайтерийн компаниуд 2015 онд нийтдээ 2-3 IPO хийхээр төлөвлөж буй тухай албан бус мэдээлэл бий. IPO-ийн үнийн дүн болоод ямар салбарын компаниуд байгаа талаар одоогоор албан ёсны мэдээлэл байхгүй. IPO хийгдсэнээр шинэ бүтээгдэхүүнүүд бий болж хөрөнгийн зах зээл идэвхжих эерэг нөлөөтэй. Мөн шинээр IPO хийж байгаа компаниуд хамгийн багадаа нийт хувьцааныхаа 20 хувийг зах зээлд арилжаалах учир төвлөрөл харьцангуй бага, олон хөрөнгө оруулагчдаас хөрөнгө татаж байгаа учир засаглал харьцангуй сайн, мэдээлэл нь ил тод, хувьцааны ханш нь өсөх боломж өндөр

гээд өмч хувьчлалын хүрээнд хувьчлагдсан компанудиаас хэд хэдэн талаар давуу талтай байдгийг анхаарах хэрэгтэй.

Төрийн өмчийн хувьчлал эхэлж магадгүй

2014-2016 оны хооронд нийт 22 төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийг хувьчлах, өөрчлөн байгуулахаар Улсын Их Хурлын тогтоолын төслийг УИХ-ын дарга З.Энхболдод өргөн барьсан. Гэхдээ өнөөдрийг хүртэл төсөл батлагдаагүй. Хэрэв 2015 онд батлагдвал нийт 13 компанийг 100 хувь хувьчлах бол, есөн компанийн төрийн өмчийн хувийг бууруулна. Харин 22 компаниас дөнгөж долоог нь биржээр дамжуулан хувьчлахаар төлөвлөжээ. Үлдсэн 15 компанийг хаалттай эсвэл нээлттэй уралдаант шалгаруулалтаар хувьчлахаар төсөлд тусгажээ. Тэгвэл бидний хувьд бүх компанийг биржээр дамжуулан хувьчлах нь зарчмын хувьд илүү нийцтэй гэж үзэж байгаа юм. Учир нь аливаа төрийн өмчит компанийг байгуулахад зарцуулсан анхны хөрөнгө оруулалт нь ихэнх тохиолдолд иргэд, ААН-ын татварын хөрөнгө эсвэл экспорт, импортын татвар гэх зэрэг ямар нэг татварын хөрөнгөөс бүрддэг ба алдагдалтай ажиллавал мөн л татварын хөрөнгөөс санхүүжилт хийдэг. Иймээс төрийн өмчит компаниудын жинхэнэ хөрөнгө оруулагчид нь иргэд, аж ахуйн нэгжүүд гэж үзэж болох юм. Тэгэхээр хөрөнгө оруулагчдад өгөөж хүртэх боломжийг бүрэн олгох үүднээс эдгээр компанийг биржээр дамжуулан хувьчлах нь зүйтэй саналыг дэвшүүлж байна. Хэрэв бүх компаниудыг биржээр дамжуулан хувьчилбал иргэд, аж ахуйн нэгжүүдэд компанийн хувьцаа эзэмшигч болох тэгш эрх нээгдэнэ. Ийнхүү тэгш эрхийг нээж өгөх нь шударга бөгөөд төрийн үүрэг юм. Компаниудыг биржээр дамжуулан арилжаалснаар шинэ бүтээгдэхүүнүүд бий болж хөрөнгийн зах зээл тодорхой хэмжээнд идэвхжих эерэг нөлөөтэйг дурьдах нь зүйтэй.

Хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэхэд хэрхэн анхаарах бол

Сүүлийн жилүүдэд хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх шаардлагатайг олон нийт, мэргэжлийн байгууллагууд, улс төрчид онцлох болсон. Төрийн зүгээс оновчтой хэлбэрээр дэмжлэг үзүүлэхэд нээлттэй байгаагаа илэрхийлсээр байна. Тэгвэл 2015 оноос компаниуд ХХК-аас ХК болж өөрчлөгдвөл шууд бус санхүүжилтийн үр өгөөж хүртэх боломж нээгдэж магадгүй юм. Энэхүү төрийн бодлого нь хууль эрх зүйн орчноор дамжуулан хувьцаат компаниудад зориулсан шууд бус санхүүгийн дэмжлэгийг бий болгох зорилготой. Жишээ нь, хэрэв тухайн компани хувьцаат компани болж хөрөнгийн зах зээлд хувьцаагаа арилжаалбал, эхний жилүүдэд НӨТ-аас тодорхой хувиар чөлөөлөгдөх, экспортод бүтээгдэхүүнээ гаргадаг бол урамшуулал эдлэх, импортоор түүхий эд авдаг бол гаалын татвараас чөлөөлөгдөх гэх зэрэг санхүүгийн иж бүрэн хөшүүргийг хууль эрх зүйн орчноор дамжуулан эдэлнэ гэсэн үг. Энэ төрлийн зохицуулалтыг сайн суурь судалгааны үндэслэлтэйгээр нарийн хийж чадвал хувьцаагаа гаргах компаниудын тоо нэмэгдэж, зах зээлд шинээр бүтээгдэхүүн бий болох, үүний хэрээр зах зээл томрох, идэвхжих багагүй эерэг нөлөө үзүүлж болох юм. ■



ҮЗЭЛ БОДОЛ

Япон Монголын бизнесийн боломж



НАОКИ ХИСАДА
*/"Токио Мицубиши Юу Эф Жэй"
банкны Төлөөлөгчийн газрын дарга/*

Манай “Токио Мицубиши Юу Эф Жэй” банк нь 2013 оны арванхоёрдугаар сарын 20-нд Монголбанкаас өөрийн Төлөөлөгчийн газрыг нээх тусгай зөвшөөрөл авч, Улаанбаатар хотод үйл ажиллагаагаа эхлүүлсэн болно. Монгол Улс нь сүүлийн жилүүдэд байгалийн баялгаа олдворлон экспортолж эхэлснээр эдийн засгийн өсөлт нь тогтворжиж байна. Ялангуяа их хэмжээний нүүрс болон зэсийн ордоороо дэлхий нийтийн анхаарлын төвд байгаа Өмнөговь

аймагт цаашид Ази Номхон далайн орнууд руу экспортлохоор гадаадын хөрөнгө оруулалтыг татах томоохон хэмжээний төсөл, хөтөлбөр зэргийг дорвитой хэрэгжүүлэх ажил өрнөж байна. Үүний зэрэгцээ шаардлагатай дэд бүтэц, үндэсний үйлдвэрийг бэхжүүлэхтэй холбоотой асуудлуудыг ч нэн тэргүүнд шийдвэрлэх хэрэгцээ гарах болсон.

Япон, Монгол хоёр орон “Стратегийн хамтын ажиллагаа”-ны ерөнхий чиг үүрэгтээ гадаад харилцааг чухалчлах тал дээр санал нийлж ▶



ГЭРЭЛ ЗУРГИЙГ Б.БЯМБА-ОЧИР

► 2013 оны гуравдугаар сард хөрөнгө оруулалтын таатай орчин бий болгох, удаан хугацааны турш харилцан эдийн засгаа тогтвортой хөгжүүлэх гэсэн уг хоёр зүйлийг гол зарчмаа болгон хамтарч ажиллахаар хоёр орны төлөөлөгчид тохиролцсоноор аж үйлдвэрлэлийн тал дээр ч эдийн засгийн эргэлтийг улам илүү идэвхжүүлснээр ахиц гарна гэдэгт найдаж байна.

“Токио Мицүбиши Юу Эф Жэй” банк нь өнөөг хүртэл төслийн болон гадаад худалдааны санхүүжилтын үйлчилгээгээрээ дамжуулан Японы үйлдвэрлэлийн монгол дахь бизнесийг санхүүжүүлэн дэмжсээр ирсэн юм. Тус төлөөлөгчийн газрыг нээж үйл ажиллагаа явуулснаар илүү их мэдээлэл

цуглуулах, урьд урьдаас илүүтэйгээр харилцагчдынхаа хэрэгцээ шаардлагыг ханган ажиллахыг хичээж байна. Энэ удаагийн нийтлэлдээ Япон компаниудын амжилтын түүх, бизнесийн боломж мөн Япон, Хятад, Орос зэрэг орнуудын харилцаа, хамтын ажиллагааны тухай өгүүлэх болно.

Юуны өмнө Япон компаниудын амжилтын түүхэн замнал болон бизнесийн боломжийн талаар дурдъя. Японы хөрөнгө оруулалттай компаниудаас хамгийн их ололт, амжилттай байгаа аж ахуйн нэгж болох харилцаа холбооны томоохон төлөөлөл “Мобиком” корпорацийн талаар танилцуулъя. 1995 онд байгуулагдсан “Мобиком” корпораци нь Монгол

Улсад анхны үүрэн холбооны сүлжээг нэвтрүүлсэн компани юм. Өнөөдрийн байдлаар нийт дотоодын хэрэглэгчдийн тал хувь нь тус компаниар үйлчлүүлж байна.

Уг компани байгуулагдахаас нэг жилийн өмнө буюу 1994 онд Монгол Улсын Засгийн газраас үүрэн телефоны бизнес эрхлэх зөвшөөрлийн тендер зарласан. Энэ үед Япон улсад ч гар утасны хэрэглээ гурав орчим хувьтай байсан бөгөөд гар утсыг цаашид түгээн дэлгэрүүлэхэд амаргүй үед “Мобиком” корпораци хамтарсан бизнесээ эхлүүлэхээр шийдсэн юм. Өөрөөр хэлбэл, Монголд бизнес эрхлэнэ гэсэн саналыг сонссон тус компанийн ихэнх ажилтан яагаад хэмээн гайхаж байсан ►

► байж магадгүй гэж бодож байна. Гэсэн ч Монголд манлайлагч байхгүй ашгийн төлөөх бизнес олонтаа байдаг ба үүний тодорхой хариулт нь заавал хэн нэгэн байх ёсгүй хэмээн бодсон. Иймэрхүү бизнесийн шинэ орчинтой Монгол Улсад өөрийн орон зайг бий болгож, амжилт гаргаж буй түүх байна аа гэдгийг та бүхэнд хэлмээр байна.

Бас дахиад нэг зүйлийн талаар өгүүлбэ. Япон компани Монгол улсын Иргэний агаарын тээврийн газраас олон улсын нисэх онгоцны шинэ буудал барих захиалга хүлээн авсан. Захиалгын зардал нь ойролцоогоор 50 орчим тэрбум иен бөгөөд үүний 90 хувь нь Япон улсын технологийг ашиглах болзолтойгоор иенийн зээл авах төлөвлөгөөтэй байгаа юм. Уг нисэх онгоцны шинэ буудал том оврын онгоц хөөрч буух зориулалттай 3600 метрийн нислэгийн зурвас, жилдээ 2.0 сая зорчигч хүлээн авах хүчин чадалтай, 33000 хавтгай дөрвөлжин метр талбай бүхий терминал хийх төлөвлөгөөтэй ажиллаж байна. Энэ шинэ нисэх буудлын зорчигчдын тооноос авч үзэхэд Японы “Комацу” нисэх онгоцны буудлын хүчин чадалтай тэнцэхүйц байгаа юм.

Япон компаниудын хувьд бизнес эрхлэхэд боломжтойд тооцогддог Монголын дөрвөн салбарын талаар ярих нь зүйтэй гэж бодож байна.

Хамгийн нэгдүгээрт хөдөө аж ахуйн салбар орох юм. Монгол орны хувьд хөдөө аж ахуй бол эрдэлтэй салбар бөгөөд Хятад улсад үйлдвэрлэсэн хүнсний бүтээгдэхүүнээс татгалзах зорилготой байна. Өргөн уудам газар нутаг байгаа хэдий ч техник технологи байхгүй, хүнсний ногоо, жимс жимсгэнэ зэргийг тодорхой стандартын дагуу хадгалах шаардлагатай уг салбар нь маш их сонирхол тагтаа юм.

Сүүлийн үеийн жишээнээс дурдвал Япон компанийн Монголд нэвтрүүлсэн ургамал ногоо үйлдвэрлэлийн бизнес юм. Монголд өвөл гадна тайлбайд тариалалт хийх боломжгүй мөн Хятадаас импортолсон хүнсний ногоо нь хүнсний аюулгүй байдал талаасаа найдвар муутай зэрэг шалтгаануудыг үндэслэн бүх л улиралд хэрэглэх боломж бүхий ургамал тариалах үйлдвэрт хүнсний нарийн, ногоо тариалан худалдаанд гаргаж эхэлсэн юм.

Үүнд нарийн ногоог тариалахад гэрэл ашигласан усан тариалалтын аргыг хэрэгжүүлж байгаа бөгөөд Япон улсаас нарийн ногооны үйлдвэрийн

доторх чийгшил, нүүрс хүчлийн давхар исэл, шим тэжээлийн хувь зэргийг цахилгаан холбооны шугамаар дамжуулан алсын зайнаас удирдан, хангах технологийг нийлүүлж байгаа юм.

Түүнчлэн Улаанбаатар хотын ойролцоо 100 мянган хавтгай дөрвөлжин метр хэмжээтэй хүлэмжид гүзээлзгэнэ, өргөст хэмх, шанцай зэргийг тариалдаг газрууд ч бий болж байна. Ер нь сүүлийн үед дэвшилтэт техник технологи ашиглан хуурай газарт ч гэсэн сам хорхойг үржүүлэх боломж бий болж ирснээр Монголын бизнес эрхлэгчдийн хүсэлтийг хүлээн авч Японы технологийг ашиглан сам хорхой үржүүлэн худалдаалах төсөл хэрэгжиж эхэлсэн.

Өргөн уудам тал нутагтай монгол улсад хонь, үхрийн махыг хүнсэндээ голчлон хэрэглэж, загас бараг иддэггүй байсан ч одоогоос арваад жилийн өмнөөс Хятад зэрэг орнуудаас импортоор орж ирсэн далайн гаралтай хүнс хэрэглэдэг тансаг хэрэглээ бий болж байгаа бөгөөд ийм байдал нь шинэ бизнес эрхлэх боломж хэмээн ойлгогдож байна.

Хоёрдугаарт, барилгын салбар орох юм. Хөгжиж буй орон болох Монгол Улсын хувьд дэд бүтцийг сайжруулан хөгжүүлэх ажил маш хурдацтай явагдаж байгаа бөгөөд орон сууц, гүүр, зам, суваг шуудуу, усны хоолой зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэх шаардлагатай байгаа юм. Эдгээр нь Монголын дотоодын технологи, хөрөнгө санхүүгээр шийдэхэд хүндрэлтэй бөгөөд Япон компаниудын хүчин чадал, технологи, санхүүжилтэд найдаж буй. Нэлээд эртнээс Монголын барилгын салбарт шийтэнд ашиглаж болох барилгын шилдэг технологийг нэвтрүүлэхийн тулд Хоккайдогогийн барилгын үйлдвэрт дадлагажигч илгээн Японы дэвшилтэт технологиос суралцах ажил явагдаж байна. Нэмж хэлэхэд Монголд орон сууц болон хувийн сууцны гүйцэтгэгчээр ажиллаж байгаа япон компаниуд ч гарч ирсэн. Хувийн орон сууцанд япон компанийн шилдэг шийдэл бүхий гал тогоо, хэрэглэхэд хялбар хана зэрэгт суурилуулдаг гэрийн цахилгаан бараа хэрэглэгчдийн талархлыг хүлээж байгаа гэж сонссон учир энэ тал дээр ч Японы өндөр технологийг ашиглаж ажиллахыг хүсч байна.

Гуравдугаарт, хуучин авто машин голчилсон авто машин худалдаалах бизнес юм. Улаанбаатар хотод аялал болон албан томилолтоор очиход бид

бүгдийн гайхлыг төрүүлдэг нэг зүйл нь хэрэглэж байгаа машины 50 хувиас илүү нь япон авто машин байдаг явдал юм. Монгол улс бензин шатахуунаа Орос улсаас импортолж авдаг учир маш өндөр үнэтэй байдаг. Бас машинаар явах зам, орчин нөхцөл төдийлэн сайн биш, мөн байгалийн эрс тэс уур амьсгалтай учир өвлийн нөхцөлд хасах 30 хэмд хүрч цочир хүйтэрдэг хатуу нөхцөлтэй. Иймээс аюулгүй байдал, бат бэх тэсвэртэй байдал, шатахуун бага зарцуулдаг зэргээрээ үнэлэгддэг япон машинаас ялангуяа спорт болон хайбрид загварын машин ихэд эрэлттэй байдаг. Японоос экспортолж байгаа машины татварыг бууруулвал машины худалдаа болоод бусад үйлчилгээ явуулах бизнесийн зах зээл ч өргөжих найдвар бий. Авто машины бусад үйлчилгээний салбар гэдэг нь мотор болон цахилгаанаас үүдэлтэй гэмтлийг засаж чадах мэргэжлийн засварчин хангалтгүй байдгаас гадна сэлбэгийн нийлүүлэлт багагүй бэрхшээлтэй байдаг ба цаашид өндөр технологийн чадамжтай япон компаниудын оролцоотойгоор шинэ зах зээл бүрдэх боломжтой салбар гэж хэлж болно.

Дөрөвдүгээрт, агаарын бохирдлыг арилгахад чиглэсэн бизнес үйл ажиллагаа орох юм. Монголын нийслэл Улаанбаатар хот нь өвлийн улиралд дэлхийн хамгийн их агаарын бохирдолтой орны тоонд ордог. Энэ нь 500 орчим мянган хүн оршин сууж буй гэр хорооллын иргэд хасах 30 хэмийн хүйтнийг өнтэй давахын тулд нүүрс, түлээ хэрэглэдэг, мөн 20 гаруй жилийн өмнө баригдсан орон сууц болон үйлчилгээний барилгууд нь нүүрс түлж халаадаг бойлуур зэрэг дулааны төхөөрөмжтэйгээс улбаатай. Улаанбаатар хот өөрөө дөрвөн уулаар хүрээлэгдсэн газарт оршдог тул газарзүйн байрлалын хувьд ч бэрхшээл үүсгэснээрээ маш аюултайд тооцогдохуйц хэмжээний агаарын бохирдолтой болдог. Саяхнаас Японы хог цэвэрлэх төхөөрөмж үйлдвэрлэгч компани нь Монголын сургуулийн барилгад хэрэглэж байгаа нүүрс түлж халаадаг бойлуурт агаар шүүгч суурилуулах талаар хэлэлцээр эхлүүлж байна. Монголын Засгийн газраас ч байгаль орчныг сайжруулна гэж амлалт өгч байгаа тул энэхүү агаарын бохирдлыг багасгахад чиглэсэн үйл ажиллагаа чухалд тооцогддог гэж би хувьдаа үзэж байна.

Дараагийн нэг зүйл бол Япон, БНХАУ, ОХУ-тай харилцан хамтын ►►

ажиллагаатай байдаг явдал юм. БНХАУ, ОХУ гэсэн хоёрхон улстай хиллэдэг геополитикийн нөхцөлтэй учраас хөрш хоёр орны аль нэгтэй нь хэт явцууралгүй, тэнцвэртэй, өөрийн байр суурьтай байхын зэрэгцээ, гуравдагч хөрш орон болох Япон, Америк, Европ, Ойрхи Дорнодын орнуудтай харилцаа, хамтын ажиллагааг улам бэхжүүлэхэд анхааран ажиллаж байгаа юм.

Ийнхүү өнгөрсөн оны долдугаар сараас есдүгээр сарын хооронд Монгол Улсын Засгийн газраас Япон, БНХАУ, ОХУ-тай гэрээ хэлэлцээр хийсэн. Мөн оны долдугаар сарын 22-нд Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж Япон улсад айлчилж Шинзо Абэ ерөнхий сайдтай уулзаж эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрт санал нэгдсэн. Монгол Улс нь Японоос хуучин машин импортлоход авдаг таван хувийн гаалийн татварыг энэ 10 жилийн хугацаанд бууруулах, мөн шинэ машин импортлоход авдаг татварыг ч нэн даруй тэглэх саналтай байгаа юм.

Мөн мисо, цуу, япон архи, цагаан архи зэргийг ч гаалийн татваргүй болгох, ингэснээр Японы талаас хүнсний бүтээгдэхүүн Монголд өргөн нийлүүлэг боломж бүрдэнэ гэж үзэж байгаа юм. Түүнчлэн Япон улс Монгол улсаас импортлох ноолууран бүтээгдэхүүнээс авдаг байсан 11 хувийн гаалийн татварыг хүчингүй болгоод байна. Энэ нь Япон улсын хувьд 15 дахь Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрийн үр дүн юм. Харин Монгол улсын хувьд анх удаа байгуулсан Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр бөгөөд Хятад, Орос улсаас хамааралтай эдийн засгийн хараат байдлаас ангижрах зарчимд тулгуурласан гэгддэг. Боловсролын салбарыг дэмжин Монгол улсын Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам, ЖАЙКА-тай хамтран физик, техникийн чиглэлийн дээд боловсролыг дэмжих хөтөлбөрөөр шилдэг 1000 оюутныг Япон улсад суралцуулахаар болсон.

Энэхүү хөтөлбөрөөр агаарын тээвэр, авто зам, барилга архитектурын салбарт олон улсын стандартад нийцсэн инженер, мэргэжилтэн бэлтгэх боломжтой хэмээн үзэж байгаа юм. Нэмж хэлэхэд Монголын Худалдаа, хөгжлийн банк долдугаар сарын 22-нд Токиод Төлөөлөгчийн газраа нээсэн. Япон улсаас Монгол улсад гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, санхүүжилт татах,

хөрөнгө оруулагчдыг эдийн засаг, зах зээлийн мэдээллээр хангах үүрэгтэйгээр ажиллаж байна.

Дахин БНХАУ-ын талаарх яриагаа үргэлжлүүлэн авч үзье. БНХАУ-ын ерөнхийлөгч Си Зиньпин наймдугаар сарын 21-22-ны өдрүүдэд Монгол Улсад албан ёсны айлчлал хийсэн. Энэ удаагийн айлчлал нь БНХАУ-ын ерөнхийлөгчийн хувьд 11 жилийн дараах дээд хэмжээний айлчлал болсон юм. БНХАУ, Монгол Улсын хооронд дипломат харилцаа, эдийн засаг, гадаад худалдаа, зам тээвэр, банк санхүү, соёл, ашигт малтмал зэрэг олон салбарын 26 хамтын ажиллагааны баримт бичигт гарын үсэг зурсан.

Гадаад худалдааны хувьд 2020 он гэхэд хоёр орны хоорондын худалдааны эргэлтийг 10 тэрбум ам.долларт хүргэх зорилтыг тодорхойлсон. Санхүүгийн хувьд гурван жилийн валют арилжааны тухайд одоогийнхоос 1,5 дахин их буюу 2,44 тэрбум ам доллар болгон нэмэх тухай гэрээ байгуулж Монголын талын гадаад валютын нөөцийн хэмжээ өснө гэдэгт найдаж байна. Гадаад валютын нөөцийн тухайд БНХАУ-ын валют арилжааны хүрээнд 810 сая ам долларыг эргэлтэд оруулах боломжтой болж байгаа юм. Хятадын талын санхүүгийн дэмжлэг үзүүлэх хүрээг тэлснээр гадаад валютын эргэлтэд үүсч болох эрсдэлээс гарч чадна гэсэн түгээмэл ойлголт байсаар байна.

ОХУ-ын ерөнхийлөгч В.Путин өнгөрсөн оны есдүгээр сарын 3-нд Монгол Улсад албан ёсны айлчлал хийсэн. ОХУ нь Улаанбаатар төмөр замын хувьцааны 51 хувийг, Эрдэнэтийн уулын баяжуулах үйлдвэрийн 49 хувийг эзэмшдэг учраас ялангуяа төмөр замын ашигт малтмалын тээвэрлэлт зэргээс хамаарч хоёр орны худалдааны эргэлтийг 2013 оны дүнгээр 1,6 тэрбум ам доллар байгааг 2020 он гэхэд 10 тэрбум ам долларт хүргэх зорилт тавьжээ. Монгол-ОХУ-ын хамтарсан компани болох Улаанбаатар төмөр замын тухайд Сүхбаатараас Улаанбаатар, Сайншанд, Замын-Үүд хүртэл жилдээ 100 сая тонн ачаа тээвэрлэх хүчин чадал бүхий цахилгаанжсан хос төмөр замын шугам тавих төслийг 2020 он гэхэд хэрэгжүүлж дуусгах чигийг баримталж байна. Ийнхүү бүрэн ашиглалтад орсны дараа Ази, Европ, ОХУ, БНХАУ-ыг холбосон хамгийн ойр төмөр зам шинэчлэгдэх чухал ач холбогдолтой гэж үзэж байна.

Хөдөө аж ахуйн салбарт үхэр, хонь гэх зэрэг мах, махан бүтээгдэхүүний нийлүүлэлтэд дэмжлэг үзүүлэхээ илэрхийлсэн байна. Мөн Монгол Улсаас ОХУ руу зорчих зорчигчдийг визгүй болгох тохиролцоонд хүрчээ. Ерөнхийдөө ОХУ-ын ерөнхийлөгч В.Путин Монголд айлчилсан хугацаа нь тавхан цаг байсан нь БНХАУ шиг өргөн хэмжээний дэмжлэг үзүүлэе гэсэн байр суурьтай байгаагүй гэсэн сэтгэгдэл төрүүлсэн юм.


Энд Монгол Улсын талаарх ерөнхий ойлголт, өнөөгийн нөхцөл байдлын талаар тодорхой ойлголт өгөхийг зорьсон болно.

Цаашид анхаарвал зохистой гурван зүйл байна гэж үзэж байна.

Үүнд: Нэгдүгээрт: Оюутолгойн уурхайн хоёр дахь ээлжийн үйл ажиллагаа тогтвортой үргэлжлэх боломж бий юу? гэдэг асуудал.

Хоёрдугаарт: Уг нь бол макро эдийн засгийн чиг хандлагын талаар яриамаар байна. Эдийн засгийн тогтвортой байдлыг бэхжүүлэхийн тулд тавих хяналт төдийлөн амар биш байдаг учраас Монгол Улсын гадаад валютын нөөцийн эргэлтийг анхааран үзэх нь зүйтэй гэж бодож байна. Мэргэжлийн сурах бичигт тодорхойлсноор гадаад валютын нөөцийн зохистой түвшний нэгдсэн ойлголт байхгүй боловч ажил хэргээр “гадаад валютын нөөц/, импортын хэмжээ” нь импортын гурвн сарын хэмжээнээс илүү, “гадаад валютын нөөц/, богино хугацаат өр төлбөрийн хэмжээ” нь нэг жил төлбөр хийх боломжтой хэмжээг жишиг түвшин хэмээн үзэж хэрэглэдэг.

Гуравдугаарт: Уул уурхайн салбарт чиглэсэн гадаадын хөрөнгө оруулалт дахин идэвхжиж байгаа бөгөөд үүнд БНХАУ манлайлан оролцох төлөвтэй байна. Өөрөөр хэлбэл, БНХАУ-аас хамааралтай хөрөнгө өруулалтын хэмжээний өсөлтийг нарийн хянах шаардлагатай болно. Хөгжиж буй орны хувьд менежментийн олон асуудал байгаа ч зэс, нүүрс зэрэг ашигт малтмалын арвин их баялагтай Монгол улсын хувьд урт болон дунд хугацаанд эдийн засгийг хөгжүүлэх боломж байгаа юм. Ийнхүү дээрх гурван зүйлийг сайтар эргэцүүлэн бодож цаашдаа Монголын эдийн засгийн хөгжлийн чиг хандлагад анхаарлаа хандуулъя гэж бодож байна. Манай “Токио Мицүбиши Юу Эф Жэй” банкны хамт олон ч өөрсдийн чадлын хэрээр хичээнгүйлэн дэмжин ажиллах болно. ■



ҮЙЛДВЭРЛЭЛ

Хямралын гарц бол экспорт

Б.ДӨЛГӨӨН /Эдийн засагч/

2015 оны босгон дээр Ерөнхий сайд Ч.Сайханбилэг хэлсэн үгэндээ Монголын эдийн засаг хямарлаа гэдгийг хүлээн зөвшөөрлөө. Эдийн засгийн тодорхойлолтын хувьд хоёр улирал дараалан эдийн засаг агшихыг хямрал гэж нэрлэдэг. Гэтэл 2014 оны арваннэгдүгээр сарын байдлаар ДНБ 16.5 их наяд төгрөгт хүрч, энэ эрчээрээ явбал манай эдийн засаг долоо орчим хувийн өсөлттэй гарах аж. Гэтэл ард иргэдэд яагаад өсөлт хямрал мэт мэдрэгдээд байна вэ? Үүний цаана үндсэн хоёр хүчин зүйл байна.

Нэгдүгээрт, манай эдийн засаг 2011 онд 17.5 хувь, 2012 онд 12.3 хувь өсөж байснаа буурч 2013 онд Засгийн газрын зүгээс болон Монголбанкны бодлогын үр дүнд 11.8 хувь өсөж, улмаар энэ жил долоон хувь өсөж байгаа нь бидэнд цагт 100 км хурдтай явж байгаад хурдаа сааруулж цагт 50 км хурдтай болж буурсан мэт мэдрэмж төрүүлсэн байх. Хоёрдугаарт, уул уурхайн салбар л үнэндээ өнгөрсөн онд эдийн засгийг авч гарч байгаа бөгөөд Дэлхийн банкаас гаргасан тайланд тусгаснаар 2014 оны эхний гурван улирлын хугацаанд ДНБ-ий өсөлтийн 71 хувийг уул уурхайн салбар бүрдүүлсэн байна. Харин энэ хугацаанд барилгын салбар 11 хувь, бөөний болон жижиглэн худалдаа 6.8 хувиар тус тус унажээ.

Хамгийн их өсөлттэй салбар болох уул уурхайн салбар нийт албан ёсоор хөдөлмөр эрхэлж буй ажилчдын дөрвөн хувийг ажлын байраар хангадаг. Гэтэл хамгийн өндөр хувиар богино хугацааны ажлын байр бий болгодог барилгын салбар, ажлын байр ихээр үүсгэдэг үйлчилгээний салбар хоёр 2014 оны эцэст 10 хувь буурсан нь өнөөдөр нийт ард иргэдэд хямрал нүүрлэж байгаа мэт шууд тусаж байгаа юм. Эдгээр салбарыг тусгайлан тасалж авч үзэж болдог бол бөөний болон жижиглэнгийн худалдаа, барилгын салбарт хямрал бодит утгаараа нүүрлэжээ.

Манай бизнес эрхлэгчид одоогоор 2015 оны бизнес төлөвлөгөөгөө хэдийнэ гаргаад Төлөөлөн удирдах зөвлөлөөрөө батлуулсан. Төлөөлөн удирдах зөвлөлийн хурал дээр тавигдсан гол асуултын нэг бол 2015 онд үйл ажиллагаандаа ямар өөрчлөлт оруулах вэ, цаашид ямар арга хэмжээ авах гэдэг асуулт байсан гэдэгтэй та бүхэн санал нэгдэх байх. Эдийн засагчийн хувьд үзэхэд 2015 оныг бизнес эрхлэгчид маань эдийн засгийн хүндрэлтэй жил болох талаас нь бэлтгэлтэй хандах нь зөв. Нөгөө талаас эдийн засгийн хямралтай үед гаргасан зоримог шийдвэрүүд цаашид компанийг үндэстэн дамнасан корпораци болгон томруулах үндэс болж өгдөг. Нэг ёсондоо бид 2015 онд хямралын дүр зурагтаа дарлуулж, дунд болон урт хугацаанд бидэнд олдож байгаа боломжуудаа алдаж болохгүй, эдгээр боломжууд маань богино хугацаанд ч гэсэн хувийн хэвшлийн болоод улс орныг тулгарч буй хүндрэлээс гаргах хүч болж өгнө. Үүнийг гурван ойлголтоор тайлбарлая.

Нэг: Бид зөвхөн Монгол гэсэн зах зээл дотроо өрсөлдвөл бие биенээ татаж унагаана. Өнөөдөр манай томоохон үндэсний гэсэн тодотголтой компаниуд маань

дотоодын зах зээлээ хувааж аваад хангалттай хэмжээнд нийлүүлэлт хийж байна. Архи, ус, ундаа, гурилан бүтээгдэхүүн гээд хүнсний бараанаас эхлүүлээд цемент, бетон зуурмаг барилга гээд Монголд үйлдвэрлэх боломжтой бүтээгдэхүүн бүрээр зах зээлээ хувааж аваад хангаж байна. 2010-2013 оны хооронд эдгээр бүтээгдэхүүний хэрэглээ хүмүүсийн худалдан авах чадвар сайжирч, эдийн засаг тэлэхийн хэрээр огцом өсөлт үзүүлж байсан бол одоо жам ёсоор хэрэглээний өсөлт тогтворжиж, эдийн засагтай улбаатай хэрэглэгчийн зүгээс үзүүлж буй эрэлт тааз мөргөн удааширлаа. Хэрэв манай компаниуд зөвхөн дотоодын зах зээл дээр үргэжлүүлэн өрсөлдөнө гэвэл дотооддоо үйлдвэрлэж буй бүтээгдэхүүн бүр дээр үнийн дайн улам ширүүсч, ёстой оршихуй эс оршихуй дээр тулах болно. Энэ бол зах зээлийн зарчим.

Анхны хөрөнгө оруулалт өндөр байх ёстой салбарт үнийн дайн бүх оролцогчоо таган унагаах хэмжээнд хүргэхгүй ч гэлээ, ашгийн түвшинг эцэст нь хүртэл шавхах аюул бий. Харин хөрөнгө оруулалт хамгийн бага шаардагддаг блок мэт зарим нэг бүтээгдэхүүний хувьд 100 гаруй компани зэрэг өрсөлдөж, тал хувь нь бараг сул зогсоход хүрээд байна. Налайх дүүрэгт гэхэд л найман блокийн үйлдвэр байгаагийн зургаа нь сул зогсож байх жишээтэй. Энд компанийн хүчин чадлыг нэмэгдүүлж хэрэггүй гэж хэлэхийг зорьсонгүй, харин энэхүү компанийн тэлэлтийн бодлогыг зөвхөн дотоодын зах зээлээр хязгаарлагүйгээр экспорт руу чиглүүлэх боломжтойг дахин дурьдахыг хүсэж байгааг уншигч авхай зөвөөр ойлгоно буй за. Монгол үйлдвэрлэгчид бид дотроо өрсөлдөж, нэг нэгнийгээ барихад улайрах биш харин гадаад зах зээл дээр гарч дэлхийн дайдад хүч зориг, ухаан бодлоо уруулдуулах том зорилго агуулах хэрэгтэй. ➤




► **Хоёр: Урд, хойд хөршийн зах зээл дээр өрсөлдөх юм бол хангалттай боломж байна.** Үүнийг бататгаж хэлэх хэд хэдэн шалтгаан бий. Хятадаас эхэлж. Юуны түрүүнд сүүлийн 30 жилд Хятад улсад 500 сая хүн ялуурлаас ангижирч, дундаж давхрага тэр хэмжээгээр хүрээгээ гэлсэн. Эдийн Засгийн Хамтын Ажиллагааны Хөгжлийн байгууллагын дэргэдэх судалгааны төвөөс гаргасан таамаглалаар бол 2026 он гэхэд Хятадын дундаж давхрага дахиад 200 сая хүнээр нэмэгдэнэ. Үүний улмаас 2009 он гэхэд Ази Номхон далайн бүс нутаг дэлхийн нийт дундаж давхрагын 18 хувийг эзэлж байсан бол 2030 он гэхэд энэ бүс нутагт дэлхийн худалдан авалтын гол сегмент болох дундаж давхрагын 66 хувь амьдарч байх болно. Түүний ихэнх нь хятадууд байна.

Хоёрдугаарт, Монгол хуурай газраар Хятадтай хамгийн урт хиллэдэг улсад тооцогддог. Бид элэг бөөрөөр нийлсэн мэт ойрхон оршиж байна. Урд хөршийн хойд хэсэгт хамгийн чинээлэг амьдралтай хүмүүс амьдардаггүй ч гэлээ монголчууд бүгдээрээ үйлдвэрлэгч боллоо ч гэсэн хангаж дийлэхгүй том зах зээл энэ хэсэгт оршоор байна. Саяхан хэвлэгдэж гарсан “Хятадыг 1 цагт” номонд өнөөдөр Хятад улсад 700 сая гаруй хүн хотод амьдарч байгаа бөгөөд 2030 он гэхэд 1 тэрбум хүн хотод амьдрах бөгөөд ингэхийн тулд хотын тоо ч нэмэгдэнэ, хүн ам ч өснө. Өнөөдөр Хятадад нэг саяас илүү хүн амтай 160 хот байдаг бол Европод ийм дайны 35 хот байдаг байна. Тэгвэл МакКензи компанийн таамаглалаар бол 2025 он гэхэд Хятадад нэг саяас дээш хүн амтай 220 хот байна. Нэг ёсондоо Улаанбаатар хотын дайны 200 гаруй хот байна гэсэн үг. Бид ганцхан Улаанбаатар хотдоо бүтээгдэхүүн үйлчилгээгээ нийлүүлснээс урд хойд хөршид байгаа Улаанбаатар шиг зуун зуун зах зээл рүү хараагаа бэлчээх цаг ирсэн.


Гуравдугаарт хойд хөрш маань Украины асуудлаас болоод тэдний худалдаа эдийн засгийн хамтын ажиллагаа нэлээд хүндэрсэн. Мөн эдийн засгийн тодорхой хоригууд тавигдаж эхлээд буй. Цаашид ч богино хугацаанд энэ асуудал шийдэгдэнэ гэсэн хүлээлт аль аль талдаа алга. Учир иймд Орос цаашид Европоос хамааралтай бүтээгдэхүүнээ бусад улсаас татан авах сонирхолтой байгаа бөгөөд энэ хүрээнд Монгол байтугай Чили, Бразил рүү өндөр түвшинд айлчлал, яриа хэлэлцээр хийж, эдгээр улстай хийж байгаа гадаад худалдааг тэлж эхэллээ. Өмнө нь стандартын хувьд тэнцэхгүй гэсэн ангилалд орчихоод байдаг байсан манай хэдэн махны үйлдвэрүүд маань нүд ирмэхийн зуур “онц” дүн авч, экспортлох зөвшөөрлөө авлаа. Энэ бол зүгээр мах, харин үүний цаана бидэнд олон боломж харагдаж байгаа гэдгийг нуух юун.

Гурав: Хятад улс хөгжихийн хэрээр олон үйлдвэр Хятадаас гарч бусад орон руу шилжиж байгааг бид өөртөө ашигтайгаар эргүүлэх хэрэгтэй. Манай өмнөд хөрш үйлдвэрлэлийн дараачийн шаг руу аажмаар шилжиж байгаатай холбоотойгоор ойрын ирээдүйд 85 сая ажлын байр хөгжлөөр дутуу яваа улс руу шилжинэ гэж Дэлхийн Банкны Хятад гаралтай эдийн засагч Жастин Ифү Лин хэлсэн. Тэгвэл эдгээр ажлын байр шилжинэ гэдэг хятадууд эндээс гарсан бүтээгдэхүүнийг хэрэглэхээ зогсоно гэсэн үг биш бөгөөд илүү ашиг өндөртэй, технологийн илүү нарийн ажиллагаатай бүтээгдэхүүн үйлдвэрлэлд анхаарлаа хандуулах учир эдгээр ажлын байрыг бий болгодог үйлдвэрлэлийг Монголд хөгжүүлж, эргээд бид Хятад руу экспортлох боломжтой болно гэсэн үг. Эдгээр ажлын байр Хятадаас “дүрвэх” гол шалтгаан гэвэл Хятадын ажиллах

Уул уурхайн бус ДНБ-ий өсөлт /салбараар (%)



Экспорт 2010-2014* (мянган ам.доллар)



хүчний оролцооны түвшин 2012 онд хамгийн дээд цэгтээ хүрсэн бөгөөд нийт хүн амтай харьцуулахад ойрын ирээдүйд энэ түвшинд дахин хүрэхгүй учраас ажиллах хүчний хомсдол руу бага багаар орно. Мөн 2013 оны байдлаар Үндэсний статистикийн хорооноос гаргасан тайланд Монголын нэг хүнд ногдох ДНБ 6 сая 54 мянган төгрөг буюу 3650 ам.доллар байхад Хятадад 6800 ам.доллар байгаа гэж Дэлхийн Банкны мэдээллийн санд байгаа нь тэнд хүний хөдөлмөрөөс хамаарал бүхий ажлын байр улам л өртөг өндөртэй болж байгааг илэрхийлнэ.

Эцэст нь хэлэхэд Монголын экспорт 2011 онд огцом өссөний дараагаар хоёр жил бууралттай явсан байна. Харин 2014 онд Оюу Толгой компани экспорт хийж эхэлснээр дахин огцом өсөлтийг үзүүллээ. Хэдийгээр манай экспортын бүтээгдэхүүн уул уурхайн бүтээгдэхүүнээс шууд хамааралтай байгаа ч гэлээ ирээдүйд үүнийг илүү төрөлжүүлэхийг төрийн зүгээс ч хүсч байгаа. Тийм ч учраас зөвхөн Монголын гэсэн үндэстэн дамнасан корпорацийг байгуулахаар зүтгэж байгаа хүмүүс ч биш, ер нь бизнесээ өргөтгөө гэсэн хүн бүр экспорт руу чиглэж ажиллах нь манай орны хөгжлийн гол гарц юм. Бидэнд асар том боломж байгаа гэдгийг мартаж болохгүй. Хятад хэлнээ хямралыг “危机” буюу “weiji” гэдэг бөгөөд үүнийг ханзаар бичихэд “боломж”, “аюул” гэсэн хоёр үгэнд ордог ханзыг нийлүүлж бичдэг. Цаад санаа нь хямралын үед боломж, аюул хоёр зэрэг оршдог гэсэн утгыг агуулдаг. Бүгдээрээ 2015 оныг боломжийн жил болгоцгооё. ■

ХУДАЛДАА

Монголд тавтай морил

А.БҮРЭНЖАРГАЛ

Улс төр, эдий засгийн түвшинд ОХУ манай улстай хөршийн харилцаатай. Харин түүхэн замнал, туулсан замаараа тэд, бид ахан, дүүсийн барилдлага тогтоож зүс нь өөр ч цус нь нэг мэт нөхөрлөж ирсэн.

Тэргээ 1923 оны арванхоёрдугаар сард хоёр улс хооронд худалдааны анхны хэлэлцээрийг үзэглэсэн нь дипломат харилцаа, гадаад худалдааны өнөөгийн амжилт, ололтын үндэс болсон чухал үйл явдал болсон билээ. Манай улсын хувьд үйлдвэр, аж ахуйн газар барьж байгуулах дотоод нөөц бололцоо дутмаг, ажиллах хүч сул байсан тул хуучнаар ЗХУ зарим үйлдвэр, аж ахуйн газрын өргөтгөл, сэргээн засварлалт болон хүчин чадлыг нэмэгдүүлэх чиглэлд санхүүгийн болон боловсон хүчний ихээхэн туслалцаа үзүүлж байжээ. Түүнчлэн Монгол Улсад байгалийн баялгаа нээн илрүүлэх, түүнийгээ ашиглах, үйлдвэрийн зориулалт бүхий олон арван барилга, байгууламж барих зээл олгох замаар тусламж үзүүлж байсан нь манай улсад аж үйлдвэрлэл хөгжих, үндэсний ажилчин анги бий болох үндэс болсон гэдэг.

Улиран одсон 2014 онд ОХУ-ын Ерөнхийлөгч В. Путин Монгол Улсад хийсэн албан айлчлал хоёр улсын харилцааг ахисан түвшинд сэргээсэн гэж болно. Баярын нулимсаар сэтгэлээ илтгэсэн хойд хөршийн төрийн тэргүүн манай улсад хэдхэн цаг саатаад буцахдаа хөршүүд хоорондоо визгүй зорчих боломжийг баталгаажуулсан.

Дээрх боломж өнгөрсөн оны арваннэгдүгээр сарын 14-нөөс хэрэгжиж эхэлснээс хойш Монголыг зорих ОХУ-ын иргэдийн тоо эрс нэмэгдсэн гэдгийг Нийслэлийн аялал жуулчлалын газраас онцлон тэмдэглэсэн.

Улаанбаатарын “Найман шарга” валютын зах дээр рубль солиулах жуулчдын тоо эрс нэмэгдэж байгаа талаар валют арилжаалагчид сонирхуулах нь албаны дээрх мэдээллийг багалгаажуулах жишээтэй. Түүгээр ч зогсохгүй ноос, ноолууран бүтээгдэхүүний эрэлт ихэссэн нь барааны эргэлтэд эерэг үзүүлэлт авчирч буйг салбарынхан тайлбарлаж байгаа юм.

Монгол чихэр байна уу

Хойд хөршийнхний сонирхол Монголд аялах төдий өндөрлөхгүй. Монголд “Монгол чихэр байна уу” хэмээн сураглан явахтай таарав. Гэтэл

импортын бүтээгдэхүүнээр “гангарах” манай дэлгүүрүүдэд үндэсний үйлдвэрлэлээ дэмжих бас бахархах хандлага үгүйлэгдэж буй нь хоёр улсын худалдаа өргөжихийн хэрээр харагдаж эхлэв.

Өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүнээс гадна эмнэлэг, сувиллын үйлчилгээ манайхыг зорих оросуудын дунд эрэлттэй байгаа аж. “Улаанбаатар Сонгдо” эмнэлгийн захирал Б.Болдсайхан “Манай эмнэлэгт хойд хөршөөс олон хүн ирж үзүүлсэн. Тэд зөвхөн эмнэлгийн үйлчилгээ аваад зогсохгүй зочид буудал, дэлгүүр хоршоогоор үйлчлүүлэх гээд олон салбарын худалдааны эргэлтэд хувь нэмрээ оруулж байгаа” гэсэн юм. Хоёр улс хооронд визгүй болсноор зорчих урсгал сайжирах нь боломж дагуулах гарц гэдгийг холбогдох салбарын мэргэжилтнүүд хэлж байна. Иймд Нийслэлийн аялал жуулчлалын газрын мэдээлснээр манай улс аялал жуулчлалын салбартаа онцлон анхаарч ажиллахаар төлөвлөжээ. ОХУ-ын иргэд нэг жилд 4.8 сая ам.доллар аялал жуулчлалд зарцуулдаг бөгөөд хамгийн их жуулчинтай топ 10 орны жагсаалтад багтдаг.

Нэг жилд 40 хоногийн амралт эдлэх тэд хөдөө гэхээс илүү суурин газар ▶▶



► зочилох хүсэлтэй байдаг гэнэ. Үнэтэй ресторанд хооллон соёл, урлагийн үзвэрт халаасаа “сэгсрэхэд” бэлэн гэлцдэг аж. Тэгвэл хотын аялал хийх сонирхолтой жуулчид манайхыг зорих нь Монголын худалдаа, үйлчилгээний салбар сайжрах суурь болно гэдгийг Нийслэлийн аялал жуулчлалын газрын дарга Э.Багтулга хэллээ.

Бизнесээ хөрсжүүлэе

Манай улсад ОХУ-ын хөрөнгө оруулалттай нийт 838 аж ахуйн нэгж бүртгэгдсэн байдаг нь нийт аж ахуйн нэгжийн 6.54 хувийг бүрдүүлдэг.

2006-2010 онд амжилттай хэрэгжиж дууссан Монгол-Оросын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг хөгжүүлэх хөтөлбөрийн дүнд хоёр орны хоорондын худалдааны эргэлт нэг тэрбум ам.долларт хүрсэн байдаг. Гэвч сүүлийн жилүүдэд энэхүү худалдааны эргэлт багагүй саарсан. Өнгөрсөн оны статистик үзүүлэлтээс харахад нийт бараа эргэлт 2014 оны эхний 11 сарын байдлаар 1.48 тэрбум ам.долларт хүрснээс импорт 1.42 тэрбум ам.доллар, экспорт 55.8 сая ам.долларт тус тус хүрчээ. Тэгвэл худалдааны алдагдал өнгөрсөн оны эхний 11 сарын байдлаар 1.37 тэрбум ам.доллар байгаа аж. Энэ нь Монгол Улс нефтийн хэрэгцээний 90 гаруй хувийг Оросоос импортлодог, экспортыг нэмэгдүүлэхэд тээврийн өндөр зардал, гаалийн татвар, тарифын бус саад тогтор их байгаатай холбоотой гэдгийг Гадаад харилцааны яамнаас мэдээлж буй.

Эдийн засгийн хөгжлийн яамны сайд асан Н.Багбаяр “Бидний хамтын ажиллагаа харьцангуй удаашралтай байлаа. Айлчлалын хүрээнд Олон улсын хөрөнгө оруулалтын банкны зүгээс төсөл хөтөлбөрүүдэд хөрөнгө оруулах боломж нээлттэй болсон. Тэр дундаа хөдөө аж ахуйн чиглэлд түлхүү хамтарч ажиллах боллоо” гэсэн юм. Хөдөө аж ахуйн чиглэлд хийх ажлын хүрээнд Эрдэнэт хотод байрлах “Эрдмийт”, “Преком” хэмээх хоёр компанид мах экспортлох зөвшөөрөл олгосон.

Цаашид хөндөх чухал асуудлын жагсаалтад хамтарсан хөрөнгө оруулалттай компаниуд зүй ёсоор багтана. Тухайлбал, уулын баяжуулах “Эрдэнэт”, “Монголросцветмет” үйлдвэр, “Улаанбаатар төмөр зам” хувь нийлүүлсэн нийгэмлэг зэрэг компанийн эдийн засгийн чадавхыг дээшлүүлэх талаар хэлэлцэж буй. Монгол, Оросын хамтын ажиллагаа зам

тээвэр, эрдэс баялаг, эрчим хүч, батлан хамгаалах, хүнс, хөдөө аж ахуй, соёл боловсрол, эрүүл мэндийн салбаруудад идэвхитэй хөгжиж байна. Тухайлбал, дээр дурьдсан байгууллагуудын эдийн засгийн чадавхаас гадна эрх зүйн орчныг сайжруулах асуудалд анхааран ажиллаж буй аж. Түүнчлэн Алтанбулагийн чөлөөт бүсэд хамтарсан аж ахуйн нэгж байгуулах, хөрөнгө оруулалтыг дэмжих, хил, гаалийн хүнд суртлыг арилгах чиглэлээр ажиллаж байгаа нь хоёр улсын худалдааны хөгжилд дөхөм болох учиртай. Мөн залуусын боловсролыг дэмжих үүднээс ОХУ-ын Засгийн газраас тус улсын их, дээд сургуульд суралцуулах монгол оюутны тоог нэмэгдүүлэх чиглэлийг

баримталж жил бүр 300 орчим монгол залуусыг өөрийн улсын тэтгэлгээр сургах юм байна.

Баавгай, луугаар дүрслэгдэх дэлхийн хоёр том эдийн засгийн дунд орших Монгол Улс чоно эдийн засагтай болох боломж бүрэн бий. Ингэхийн тулд хоёр хөршийнхөө зах зээлийн эрэлт, хэрэгцээнд суурилан хөгжих, цаашид гуравдагч зах зээлд танигдах хэтийн ирээдүйг бодлогоор зураглах нь чухал. Монгол Улсын Засгийн газрын санаачилгаар Монгол, Орос, Хятад гурван улсыг дамнанас төмөр замын тээврийн асуудлаар зөвлөлдөх уулзалтыг зохион байгуулж, гурван улсын нутаг дэвсгэрээр дамжих төмөр замын тээврийн коридорыг хөгжүүлэх чиглэлээр идэвхтэй ажил өрнөж байна. ■

ХӨРШ

“Луу”-гийн эрин ба өөртөө итгэх өмнөд хөрш

Б.БАЯРТОГТОХ

Зүүн Азийн улсууд өнөөдөр зах зээлийг удирдаж байна. Түүний нэг томоохон төлөөлөгч нь БНХАУ. Дэлхийн нийт хүн амын 20 хувийг эзлэх тус улс зургаан жилийн өмнө дэлхийн хамгийн том авто машины зах зээл болсон. Тухайн жил буюу 2009 онд 13.5 сая авто машин үйлдвэрлэсэн байдаг. Нобелийн эдийн засгийн шагналт, Чикагогийн их сургуулийн профессор Роберт Фогели “2040 он гэхэд Хятадын ДНБ 123 их наяд болж, дэлхийн ДНБ-ий 40 хувьтай тэнцэнэ” хэмээн 2010 онд АНУ-ын “Гадаад бодлого” сэтгүүлд хэтийн төлөв байдлыг таамаглан бичсэн удаатай.

Эдийн засгийн хүчин чадавх, олон улсын байр суурь бэхжих тусам тэд орчин үеийн улсынхаа түүхэнд байгаагүйгээр өөртөө итгэлтэй болж эхэлсэн. Гурван их наяд ам.долларын валютын нөөцөөрөө дэлхийн бусад орныг хол тэргүүлж буй өмнөд хөрш Дорнод Азийг хошуучлагч. БНХАУ АНУ-ын Засгийн газрын 1.1 их наяд ам.долларын бондыг эзэмшиж

байгаа. Энэ нь америкчууд Хятадад төдий хэмжээний өртэй гэсэн үг. Хятад АНУ, Европын холбоо, Япон, Өмнөд Солонгос гээд дэлхийн хүчирхэг орнуудын худалдаа, хөрөнгө оруулалтын хамгийн чухал түнш болж чадсан. Хятадын эдийн засгийн өсөлт өнгөрсөн онд 7.4 хувьтай гарна гэсэн судалгааг тус улсын Төвбанкнаас оны өмнө гаргасан.

Дэлхийн гар утасны 70 хувийг хангах урд хөрш тэргүүн зэргийн өндөр технологийн бие даасан төв. Тэд 1998 онд өндөр технологийн төлөвлөгөөг батлан гаргаж ихээхэн хэмжээний хөрөнгө зарцуулсан байдаг. Энэ нь 2020 он гэхэд Хятадыг АНУ-ын дараа, Европ, Японы өмнө орох өндөр технологийн хоёр дахь гүрэн болгох зорилт юм. Дэлхийн хамгийн том зах зээл Хятадад буй учраас тэнд хамгийн том үйлдвэр хэдийнэ суурьших болсон. Энэ нь өмнөд хөршийг “дэлхийн үйлдвэр” болгон хувиргасан. Үйлдвэрлэгч төдийгүй хэрэглэгч орны зах зээлд тэмүүлэх сонирхол одоо ч ер сулраагүй байна.

Хятад хямд төдийгүй чадварлаг мэргэшсэн ажиллах хүч, сайн инженер, ►►

► судлаач шинжээчдийн яндашгүй сантай. Тиймээс үйлдвэрлэгч орнууд үйлдвэрлэлээ Хятад руу шилжүүлсэн байдаг. Үүнээс гадна БНХАУ Дэлхийн худалдааны байгууллагад элссэн нь гадаадын хөрөнгө оруулалтын нөхцөл нэлээд сайжрах, даян дэлхийн өнцөг булан бүрээс үйлдвэрлэл Хятад руу шилжих явцыг улам хурдасгах болсон аж. Энэхүү түүхэн үйл явдал нь Хятадын экспортод ихээхэн боломж нөхцөл нээж өгсөн гэдэг. Үүний үр шим өнөөдөр гарч, “Луу”-гийн эрин үе ирсэнийг өгүүлэх болсон.

Бидний байнгын хэрэглээ болсон компьютерын 90 хувийг тус улс үйлдвэрлэж, олон улсын зах зээлд нийлүүлдэг. Тайваний дээд сургуулиуд жилд 4500 инженер төгсгөж байхад Хятадын дээд сургуулиуд 150 мянган инженер бэлтгэн гаргаж байна. Шанхайд нэг инженерийг Тайваний нэг инженер бэлтгэх зардлын дөрөвний нэгээр л бэлтгэх жишээтэй.

Монголын нийт оюутны тоо 130 орчим мянга бөгөөд үүний 30 гаруй мянга нь тухайн жилд төгсөж байна. Тэгвэл Хятадад жилд 7.5 сая оюутан төгсдөг аж. Хөгжлийн хүчирхэг “арми” болсон оюунлаг залуусын 50 гаруй хувь нь шинжлэх ухааны салбарын мэргэжилтэн. Үүнтэй зэрэгцэн барууны томоохон компаниудад өмнөд хөршид судалгаа шинжилгээний төвөө байгуулах нь эрс нэмэгдсэн.

БНХАУ-ын Үйлдвэр, худалдааны яамны мэдээллээр 1500 гаруй судалгаа шинжилгээний төв одоогоор Хятадад үйл ажиллагаа явуулж байна. 2001-2011 оны

хооронд дэлхий нийтэд танигдсан патентуудын 72 хувь нь урд хөршийнх. Хятад зөвхөн өндөр технологийн тэргүүлэгчээр хэмжигдэхгүй ногоон биотехник буюу ургамал, амьтны гентехникийн судалгаагаар хамгийн том хэрэглэгч бөгөөд судалгаа шинжилгээгээр АНУ-ын дараа орж байна.

Европтой харьцуулахад Хятад нь дээрх салбарт хөгжил дэвшлийн төлөө шинэ тутам тэмүүлж буй орон. Тиймээс гентехникийн хувьд өөрчилсөн ургамал ногоог туршилтын талбайгаас сугалж хаядаг хүн үгүй. Үүнээс гадна урд хөрш АНУ-ын дараа орох сансрын гүрэн болохоор зорьж байгаа. Хятад өнөөдөр Японоос илүү тооны чадварлаг инженерүүдийг бэлтгэх болсон. Энэ нь Хятадын шинжлэх ухааны ирж буй шинэ мянганы залгамж халаа юм. Тэд мэдлэгт тулгуурласан эдийн засагтай орныг бүтээх жинхэнэ эзэд. Хоосноос үүссэн мэт Хятад сүүлийн 15 жилд дэлхийн экспортын дөрөв дэх гүрэн болж гарч ирсэн. Хятад нь дэлхийн зах зээлд хүч түрэн орж ирсэн сүүлийн үед тодорч буй хүчирхэг эдийн засаг. Тэд аж үйлдвэржилт, хотжилт, зах зээлийн эдийн засаг руу хийх шилжилт гэсэн гурван хувьсгалыг нэгэн зэрэг хийсээр байна. ■

БИЗНЕС ЗӨВЛӨГӨӨ

Тэд ийн ӨГҮҮЛЭВ

Бизнес эрхлэгч гэхээр бүхнийг чадагч супер хүн гэж ойлгож болохгүй. Хэдийгээр тэд өөрсдийн хүчээр амжилт болоод алдарын оргилд хүрсэн байж болох ч хэн нэгнээс үнэт зөвлөгөө авалгүй өдий зэрэгт хүрээгүй нь лавтай. Бизнесийн салбарт нэрээ “тамгалсан” эрхэмүүд ч амжилтынх нь ард найз, нөхөд, гэр бүл гээд олон хүний итгэл сэтгэл, хүч хөдөлмөр бийг хүлээн зөвшөөрдөг. Ийнхүү бизнесийн ертөнцөд “гуру” (номлогч) гэгддэг хүмүүсийн эрхэм зөвлөгөөг хүргэж байна.

“Сайн багаар өөрийгөө хүрээлүүл. Тэгээд багаа аажмаар хөгжүүл”- Шейла Жонсон, “Salamander Hotels and Resorts”-ийн үүсгэн байгуулагч, гүйцэтгэх захирал



Шейла Жонсон багаар ажиллах чадварын тухай арвин мэдлэгтэй нэгэн. Тэрбээр спортын салбарт “Washington D.C.’s Capitals”, “Wizards”, “Mystics” зэрэг гурван ч франчайз бизнесийг амжилттай авч яваа хүчирхэг нэгэн билээ. Мөн Шейла ВЕТ буюу “Black Entertainment Television” сүлжээний үүсгэн байгуулагчдын нэг төдийгүй тансаг зэрэглэлийн “Salamander Hotels and Resorts” сүлжээ амралтын газрыг үүсгэн байгуулж, гүйцэтгэх захирлаар нь ажиллаж байна. Шейла хэлэхдээ “Баг бүрдүүлэлт бол бизнес эрхлэгчийн хийж болох хамгийн ашигтай хөрөнгө оруулалт. Тиймээс шилдэг хүмүүсээр сайн баг бүрдүүлэх нь ногдол ашиг өндөртэй хөрөнгө оруулалт юм” хэмээсэн байна. ►

▶ **“Дараагийн ажилтнаа үргэлж мэдэж бай”- Мелинда Эмерсон, “Quintessence Group”-ийн үүсгэн байгуулагч, гүйцэтгэх захирал**



Жижиг бизнес эрхлэгчдийн мөнхийн айдас нь хүний нөөцийн асуудал байдаг. “Хэн ч чиний бизнесийг чамаас илүү хайрлахгүй. Иймд түүнийгээ чи л хамгаалах хэрэгтэй” хэмээн “Quintessence” группын үүсгэн байгуулагч, гүйцэтгэх захирал Мелинда Эмерсон хэлдэг аж. Хүнд цагт ажилтнуудаа алдах эрсдэл тулгардаг. Тийм өдөр ирэхэд үргэлж бэлэн байх хэрэгтэй. Тэрбээр “Ажилд аваагүй ч чамд таалагдсан нэгэн байвал тэдэнтэй холбоотой байхад гэмгүй. Учир нь хэзээ нэг өдөр тэдний хэрэг гарч мэднэ шүү дээ” хэмээн зөвлөдөг байна.

“Урьдчилан харахад хамаг цагаа зарцуул”- Жим/Жеймс Маррен, “MGM Resorts International” компанийн ерөнхийлөгч, гүйцэтгэх захирал



Хоромын дотор хувь заяаг тань эргүүлж чадах казиногийн ертөнцөд өнгөрсөн рүү өнгийх нь сайны дохио биш. Иймд урагш өөд тэмүүл гэсэн зарчмыг “MGM Resorts International”-ийг үүсгэн байгуулагч Кирк Керкориан өөрийн бизнестээ чандлан мөрддөг нэгэн аж. Бизнесийнхээ очыг гал болгон дүрэлзүүлэхэд чухал

нөлөө үзүүлэх энэхүү зарчмыг өдгөө Жим үргэлжлүүлэн манаж явна. Жим Маррен компанийнхаа ажилчдыг урт хугацаанд бат орших ирээдүйг төсөөлж, төлөвлөдөг байхыг хүсдэг аж. Түүний хэлж буйгаар ажилчид юу хийж байгаагаа мэддэг байхаас гадна юуны төлөө тухайн ажлыг хийж буйгаа мэддэг бас ойлгодог байх нь бизнест маш чухал гэнэ.

“Нотолгоо хүлээж суувал чи удирдагч биш зөвхөн дагагч”- Кристин Дей, “Luvo” эрүүл хүн үйлдвэрлэгч компанийн гүйцэтгэх захирал



Кристин өөрийгөө бүтээгч гэх дуртай. “Starbucks”-ийн Ази, Номхон далайн бүсийн салбар хариуцсан захирлаар ажиллаж байсан түүний амьдралыг харах өнцгийг Америкийн бизнес эрхлэгч, “Starbucks”-ийн гүйцэтгэх захирал Ховард Шхулцийн нэгэн зөвлөгөө өөрчилсөн гэдэг. “Инноваци зах зээлийн судалгаанд үндэслэдэггүй” гэх Ховардын зөвлөгөөний тухай Кристин хэлэхдээ “Бий болоогүй зүйлд нотолгоо гэж үгүй. Юу гэдгээс үл хамааран зөвхөн зөн билиг, зорилго, хүсэл тэмүүлэл л аливааг бодит болгодог. Шинийг эрэлхийлэгч компаниуд улиг болсон зүйлийг ардаа үлдээж дараагийн зах зээлийн шилжилтийг эхлүүлэхээс эмээдэггүй” хэмээн бусад бизнес эрхлэгчиддээ зөвлөж байна.

“Айх хэрэггүй. Үсэр”- Рехан Чодри, “Life is beautiful” фестивалийн үүсгэн байгуулагч

Өмнөх ажлаа орхин “Life is beautiful” фестивалийг зохион байгуулах шийдэмгий алхам хийхийн тулд Рехан олон жилийг зарцуулжээ. Өдгөө Лас Вегасын бас нэгэн чимэг болж буй уг баярын үйл ажиллагааг анх эхлүүлэхэд Реханы багш түүнд тун хэрэгтэй зөвлөгөө өгсөн нь түүнийг



өнөөдрийнх нь амжилтад хүргэсэн билээ. Түүний хэлж буйгаар бизнес эрхлэгч байна гэдэг нь бизнесийн талаар ихийг мэддэгт бус хүсэл эрмэлзэлтэй бас зоригтой алхам хийж чаддаг байхыг хэлэх аж. Рехан “Шийдэмгий алхам хийхэд тохиромжтой цаг гэж байхгүй. Зоригтой хөдлөхийн тулд цаг хугацаанд баригдах шаардлагагүй. Чи хэзээд урагш алхаж чадна. Тэгэх ч ёстой” гэв. Ингэснээр ямар нэг асуудлыг хэт бодохоос зайлсхийж, гол зүйлдээ анхаарлаа хандуулахад тус болдог гэдгийг тэрбээр онцолжээ.

“Хүнлэг бай”- Рийс Пачеко, “Shelby.tv”-ийн үндэслэгч



Бизнесээ эхлүүлж буй үед мөнгөний өнгөнд хууртах нь бий. Гэвч хэрэглэгч, үйлчлүүлэгчид “ХҮН” гэдгийг ямагт санах хэрэгтэйг Рийс Пачеко зөвлөж байна. Тэрбээр “Хүнлэг байна гэдэг нь дэлхийг ч өөрчлөх том хүчин. Учир нь үүний ард амьдрал нуугдаж байдгаас гадна бизнес эрхлэгчийн хувьд хамтран ажиллагсад төдийгүй хөрөнгө оруулагчидтай харьцах харьцаанд чухал нөлөө үзүүлэгч гол хүчний нэг болдог” хэмээн тайлбарласан байна. ■